БНМАУ
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

Х. Лувсанбалдан

ТОД ҮСЭГ, ТҮҮНИЙ ДУРСГАЛУУД

Улаанбаатар хот
1975

БНМАУ
Шинжлэх Ухааны Академи
Хэл зохиолын хүрээлэн

Х.Лувсанбалдан

А.Г. Сазыкин

ТОД ҮСЭГ ТҮҮНИЙ ДУРСГАЛУУД

Редактор Ц.Дамдинсүрэн

Шинжлэх Ухааны Академийн хэвлэх
Улаанбаатар — 1975

4 мөн
Л-82

Олон улсын
монголч эрдэмтний
III их хуралд
зориулав.

Х.Лувсанбалдан

Редактор Ц.Дамдинсүрэн

Техник редактор хийж,хуулан бичсэн Х.Лувсанбалдан

Хэвлэлтэнд 1974 оны 11-р сард оруулж 1200 ширхэг хэвлэв. Цаасны хэмжээ 60x90.1/16.Хэвлэлийн хуудас 22,5 В-54275. Х.Г.№ 431/74, За. № 291

Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр
Улаанбаатар хот Нэгдсэн үндэстний гудамж 15

VII-1
344-74

УДИРТГАЛ

Тод үсэг зохиогдоод 320 гаран жил болсон бөгөөд тод үсгийг судлаж эхэлснээс хойш 120 гаран жил өнгөрлөө.

Тод үсгийн талаар гарсан анхны томоохон бүтээл бол 1847 онд Казанийн их сургуулийн профессор А. Поповын нийтлүүлсэн ,,Калмыцкая грамматика" гэдэг ном юм. А.Попов „Эрдэнийн сан субашид", „Мэдээтэй, мэдээгүйг ялгагч судар ', „Рамаяна", „Гэсэрийн туужь", Баатар Увштүмэний зохиосон „ Дөрвөн ойрдын түүх", Халимагийн Дармабал хатнаас Казаний төлөөний сайд А.Волынскийд илгээсэн захидал зэрэг хэрэглэгдэхүүнийг ашиглан зохиолоо бичжээ.

А.Поповын „Халимаг хэлний зүй" гарснаас хойш хоёр жилийн дараагаар А.Бобровников, „Грамматика монгольско-калмыцкого языка" гэдэг номыг бичиж 1849 онд нийтлүүлжээ. А.Бобровников „Эрдэнийн сан субашид", „Сарны гэрэл" болон бусад олон зохиолыг ашиглаж монгол-халимаг хэлний зүйгээ бичжээ. Дурдсан хоёр зохиол нь монголын судлалын чухал бүтээл болсон бөгөөд одоо ч гэсэн үнэ цэнээ алдаагүй хэвээр байна.

Халимаг хэлний зүй, монгол-халимаг хэлний зүйг зохиогчид өөрсдийнхөө зохиолыг Астрахань хотын шашны семинарт суралцагчдад зориулсан болохоор нэг талаар халимагийн ярианы хэлийг тусгасан тэр үеийн тод үсгийг гол болгож, нөгөө талаар Зая бандидын орчуулгын хэлийг анхааран үзэж түүнийгээ „ бичгийн хэл" гэж үзжээ.

Энэ хоёр хэл зүй гарснаас хойш нилээд жилийн дараа тод үсэг, ойрдын уран зохиолын талаар сонирхолтой зохиол бүтээлүүд гарчээ.

Юуны өмнө А.Позднеев, тод үсгээр нийтлүүлсэн

нилээд үлгэр, халимаг орос толь болон бусад зүйлс, Вл. Котвичийн, халимаг оньсого, зүйр цэцэн үгс зэрэг тод үсгээр нийтлүүлсэн сонирхолтой бичиг зохиол гарсныг дурдах хэрэгтэй.

Хожим үед академич Б.Я.Владимирцовын „ Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия", доктор Г.Д.Санжеевын ,,Сравнительная грамматика монгольских языков", академич Ш.Лувсанванданы ,,Дөрвөлжин, тод үсгийн зөв бичих дүрэмд монгол хэлний урт эгшгийг хэрхэн тэмдэглэсэн нь" гэдэг өгүүлэл, академич Ринчений „ Монгол бичгийн хэлний зүй", доктор Д.А.Павловын „ К вопросу о созданий Тодо бичиг", „ Некоторые вопросы развития фонетики калмыцкого языка по Тодо бичиг", эрдэмтэн А.В.Бадмаевын „ Зая пандита", „ Калмыцкие историко-литературные памятники в русском переводе" Д.Карагийн „ Книги монгольских кочевников", доктор И.Я.Златкины ,,Зая пандита - как политический деятель", Ц.Дамдинсүрэнгийн „ Монголын уран зохиолын дээж зуун билигт" оруулсан Зая бандидын намтрын хэсэгт хавсаргасан номын монгол төвд орчуулгын нэр, Америкийн Нэгдсэн Улсад нийтлэгдсэн „ Калмыцко-ойратский сборник" гэдэг ганц сэдэвт цуврал бичгийн зарим өгүүлэл зэрэг зохиол нь тод үсэг,ойрдын утга зохиолын судлалд сонирхолтой хувь нэмэр оруулсан зохиол бүтээл байв.

Гэвч тод үсэг, ойрдын утга зохиолын талаар хийсэн судлагаа нь бүрэн төгс болсон хэмээн үзэж хараахан болохгүй юм.

Бид сүүлийн үед тод үсгийн үе үеийн олон судар номыг олж цуглуулсан нь тод үсэг, ойрдын утга зохиолын судлалд шинэ санаа нэмэрлэж болох болов.

Бидний цуглуулга нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс батласан „ Соёлын дурсгалт зүйлийг

хамгаалах тухай хуулийн" заалттай яв цав тохирч байна.

Тод үсгийн номын цуглуулгын дотор Зая бандид болон түүний шавь нарын орчуулга, гар бичмэл барын ном зэрэг олдохуйяа бэрх болсон ховор дурсгал хадгалагдаж байгаа юм. Эдгээр сонин дурсгалуудаас эхээр нь нийтлүүлэх, хэл бичиг, үг үсэг, уран зохиолын талаар судлагаа хийх хойшлуулшгүй чухал зорилт тавьсан билээ. Үүний үр дүнд тод үсгээр бичсэн түүх, анагаах ухаан, уран зохиолын сонирхолтой бичиг дурсгалыг гэрэл зургаар нийтлүүлсний гадна „ Тод үсэг, түүний дурсгалууд" гэдэг ганц сэдэвт зохиолыг эрдэмтдэд толилуулж болох боллоо. Энэхүү ганц сэдэвт зохиол нь дөрвөн бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт, тод үсэг зохиосон Ойрдын Зая бандид Намхайжамцын намтрын тухай; хоёрдугаар бүлэгт, тод үсгийн үсэг зүй, авиа зүй, үг зүй, үгсийн сангийн тухай; гуравдугаар бүлэгт, манай улсын сан хөмрөгүүдэд байгаа тод үсгийн ном зохиол түүний ангилал; дөрөвдүгээр бүлэгт, Зая бандид, түүний шавь нарын орчуулга буюу Ойрдын нутагт орчуулсан орчуулгын тухай тус тус дурдав.

Ганц сэдэвт зохиолд тод үсгийг судласан эрдэмтдийн саналаас зөрөөтэй буюу шинээр дэвшүүлж тавьсан зүйл бидэнд бий. Үүнд:

I. Тод үсгийг одоо болтол зөвхөн Дөрвөн ойрдод зориулан зохиосон гэдэг саналыг нягтлан үзэхэд хэрэглэгдэхүүн болох Зая бандидын зохиосон „ Үсгийн найрлага" гэдэг цагаан толгой бидэнд бүрэн бүтнээр олдов. Үүнд тод үсгийг ,, Омог монгол улсын хувьтанд" зориулан зохиосон гэж бичсэн болохоор биднээс илүү баталгаа шаардалгүйгээр дээрх саналыг няцааж болох болов.

2. Тод үсэгт тэмдэглэсэн урт эгшгийг зарим

эрдэмтэд хос эгшиг гэж үзээд үүнийг дундад эртний монгол хэлний үлдэц гэж үзсэн нь үнэн баримттай нийцэхгүй байгааг дурдаж бид саналаа дэвшүүлэн тавилаа.

3. Манай улсын Нийтийн номын сан, Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөг, Увс, Ховд аймгийн орон нутаг судлах музей, Зөвлөлт Холбоот Улсын Ленинград хот, Элист хотод байгаа тод үсгийн ном, Германд хадгалагдаж байгаа тод үсгийн номын бүртгэлтэй танилцаж манайд тод үсгийн ямар ямар ном байгааг тодорхойлон ангилав.

Нэгдүгээр бүлэг

ОЙРДЫН ЗАЯ БАНДИД НАМХАЙЖАМЦ

I.Зая бандид Намхайжамцын намтарт холбогдох сурвалж бичиг

Зая бандидын дотнын шавь Раднаабадраа гэгч „Рабжамба Зая бандидын тууж сарны гэрэл хэмээх энэ мэт болой" гэдэг нэртэй номыг I69I онд[I] зохион дуусгаж үлдээсэн байна.

Зая бандидын тухай энэ намтраас илүү тодорхой мэдээ сэлт бидний гарт байхгүй байна. Раднаабадраагийн зохиосон намтар бол зарим нэгэн хутагт лам нарын намтрын адил тэдгээр лам нарын увдис, ид шидийг товойлгон чимж[2] бичээгүй, болсон үйл явдлыг үнэн зөв бичсэнээрээ түүхийн сонин сурвалж бичиг болох юм.

Зая бандидын намтар „ Сарны гэрэл" гэдэг ном манай улсын Нийтийн номын санд монгол үсгээр[3] бас хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт тод үсгээр бичсэн нэг эх хадгалагдаж байна[4].

Дурдсан хоёр гар бичмэлээс гадна Зөвлөлт Холбоот Улсын Шинжлэх Ухааны Академийн Дорно дахиныг судлах хүрээлэнгийн Ленинградын салбарт тод үсгээр бичсэн „ Сарны гэрэл" байгаа юм.Зөвлөлт Холбоот Улсад хадгалагдан буй „ Сарны гэрлийн" хэд хэдэн бичмэлээс хамгийн сайн нь энэ эх болно[5].

Зөвлөлт Холбоот Улсад хадгалагдан буй мөн намтрын хоёрдугаар хувь бол Ленинград хот дахь А.А.Жда-

новын нэрэмжит, улсын их сургуулийн Дорно дахины факультетийн номын санд хадгалагдаж байна. Энэ намтрыг 1860 оны 5-р сард нэг эх бичгээс хуулан бичжээ.[6]

Зөвлөлт Холбоот Улсад хадгалагдаж буй намтрын гуравдахь хувь бол Зөвлөлтийн Шинжлэх Ухааны Академийн Дорно дахиныг судлах хүрээлэнгийн Ленинградын салбарт профессор А.М.Позднеевийн цуглуулганд бий. Эдгээр намтар нь үг үсгийн талаар бага сага зөрөөтэй боловч үндсэндээ адил юм.

Сарны гэрлийг зохиогч Раднаабадраа нь Зая бандидтай хамт байж нүдээр үзсэн, Зая бандидын талаар сонссон, хүнээс асуун сурвалжилсныгаа энд бичжээ.

Сарны гэрэл хэмээх энэ намтар нь найман бүлэгтэй.

Нэгдүгээр нь, Зая бандид сахил хүртэж Төвдөд чиж суусан;

Хоёрдугаар нь, Төвдөд сууж эрдмийн мухарт хүрч нэр авч лам болсон;

Гуравдугаар нь, гурван богдын /Далай лам,Банчин богд,?/ эш зарлигаар Монгол Ойрдод гарсан;

Дөрөвдүгээр нь, Монгол Ойрдын лам болж ном орчуулан долоон хошуу халх Дөрвөн ойрдод шашин дэлгэрүүлсэн;

Тавдугаар нь, Төвдөд дахин очиж өргөл барьц, эд агуурсан ихэд өргөсөн;

Зургадугаар нь, Төвдөөс Ойрдод буцаж очоод сайн хувьтнаа ном үзүүлсэн;

Долоодугаар нь, Дахин Төвд уруу явах завсраа нас барсан;

Наймдугаар нь, Зая бандидын хойт дүр хувилан төрсөн ийм найман бүлэгтэй.

Раднаабадраа энэ зохиолдоо он цагийг алгасалгүй дараалах ёсыг чанд баримтлаж Дөрвөн ойрдын дотор болсон сайн муу үйл явдлыг нууж хаалгүй бичжээ.

Зарим баримтыг /1690 онд Далай ламаас илгээсэн ухуулах бичиг зэрэг/ тэр хэвээр хуулан бичсэн зүйл нилээд буй.

Бидний гарт байгаа Сарны гэрлийн монгол эхийг тод үсгийн ямар нэг эхээс хуулж бичсэн нь илэрхий байна. Ийм ч учраас Сарны гэрлийн монгол эхэд анхаарвал зохих нилээд алдаа бий. Жишээ нь: Babaxan гэхийг Baybayas /4-р талд/, nom orčiulǰi гэхийг nom üǰügülǰü /5-р талд/, glu-giyin xān гэхийг yalayu-yin qayan /3-р талд/, 7-р талд бүтэн мөрөөр орхигдуулсан, Ulān burādu гэхийг Ulayan büriyen-dü /12-р талд/ Xonjin blama-ber гэхийг xorin blam-a-ber /13-р талд/, zöün yariyin zaxa-tai гэхийг ǰegün yar-un čayan-tai /33-р тал/ zayasu ese barin, usu buzarlaqsan гэхийг čayasu ese barin, usu buǰarlaysan /60-р талд/ гэх мэтийн алдаа нилээд байна.

Бас „Сарны гэрлийн" орос орчуулга хэд хэд байгаагийн зарим нь дутуу юм. Хамгийн анхны орчуулга бол Г.С.Лыткины орчуулга болно.

Г.С.Лыткины дараагаар оросын нэрт монголч эрдэмтэн К.Ф.Голстунский, Зая бандидын намтрыг товчлон орчуулсныгаа „1640 оны Монгол Ойрдын цаазын бичиг. Галдан хун тайжийн нэмсэн зарлиг, жич Халимагийн Дондогдаш ханы үед Ижил мөрний Халимаг торгуудад зориулж зохиосон хууль цааз" гэдэг номын тайлбарт[7] хавсаргажээ.

Бүр хожим „Сарны гэрлийг" 1938 онд Г.Н.Румянцев орос хэлнээ орчуулсан боловч хэвлэгдээгүй байна. Орос орчуулгаас бидэнд олдож буй бараг бүрэн нэг орчуулгыг[8] тод болон монгол эхтэй нь тулган үзэхэд

үгийн утгыг бүрэн ойлгоогүйгээс алдсан ташаарал нилээд байгаа юм. Энд зарим нэг жишээг дурдъя. Тод үсгийн „Сарны гэрэлд", „ эдүүгээ хувь ноохул хоёр түм түүрэн адуу амуй"[9] гэжээ.

Нэр үл мэдэгдэх хүний орчуулгад "Хабин и Охона подтвердили, что тогда всего было только 10,000 лошадей"[10] гэжээ. Үүнд хувь ноогдуулбал гэсэн үгийг хоёр хүний нэр гэж ташаараад адууны тоог нэг түм хэмээн эндүүрчээ. Сарны гэрлийн монгол эхэд „Брайбүнгийн хувраг шарын эрхэнээр угтан..."[11] гэснийг нэр үл мэдэгдэх хүний орчуулгад „Тамошнее духовенство встретило его на Шарыни Эркин"[12] гэж орчуулжээ. Үүнд Зая бандидыг Брайбүнгийн хуврагууд шарын шашны эрхэм хүний ёсоор хүндлэн угтаж авсан гэснийг дулим ойлгож „Шарыни Эркин" хэмээх газар угтан авсан гэжээ. Нэр үл мэдэгдэх хүний орчуулгад энэ мэтийн алдаанаас гадна хуудсыг сольж, хойно байх зохистой зүйлийг өмнө оруулан, өмнө байх ёстой зүйлийг хойно оруулан орчуулсан зүйл ч бий.

Ер нь энэхүү нэр үл мэдэгдэх хүний орчуулгыг ашиглахад хүрвэл монгол буюу тод эхтэй эрхбиш тулган үзэх нь чухал юм.

Ховдын харьяат Алтайн Захчины „Өлзий цагаан бадма номлол бүтээл өргөн дэлгэр" сүм буюу „ Дашбадгар-шадав-даржаалин" гэдэг хийдийн түүх „ Алтан эрих" гэдэг сонин бичиг манай тод үсгийн номын хөмрөгт хадгалагдаж байгааг бас дурдах хэрэгтэй . Энэ номд Зая бандидын намтарт зарим нэгэн талаар сэлбэх чанартай мэдээ байгаагаас гадна Дөрвөн ойрдын түүхэнд холбогдох сүүл үеийн зарим зүйл байгаа нь сонирхолтой юм.

Энэ номыг бид нийтлүүлж амжаагүй учраас монголын түүхэнд холбогдолтой мэдээний агуулгыг түүвэрлэн гаргаж танилцуулъя.

Энэ зохиолыг муутуу цааснаа хар бэхээр, бийрээр бичсэн бөгөөд нийт 86 хуудастай ном юм. Уг ном нь толгой холбон зохиосон магтаал шүлгээр эхэлж байгаа бөгөөд цаашид Жамъяншадавын гэгээний зохиосон данзайн дараалыг баримталсан байна.

24в - 26в тал хүртэл монголын зарим хаадын,хаан ширээнээ суусан он цаг болон тэдгээрийн шүтэж байсан лам нарын тухай;

31а - 32в талд Түмэдийн Алтан хааны тухай, Монголчууд шарын шашинд орж нүгэл хилэнцийг тэвчин бөөгийн мөргөлтэй тэмцэх тухай. Гүүш хаан төрсөн тухай;

32в - 33в тал хүртэл Зая бандид 6 нас хүрсэн болон сахил хүртэж Төвдийн Цогт Брайбүн хийдэд суусан тухай;

33в - 34в талд Халхын Цогт тайж Хөх нуурт очсон, Гүүш номын хааны явдал, Зая бандид, Монгол Ойрдод буцаж ирсэн тухай;

38а - 39а талд Зая бандид, Төвдөд ирээд буцсан. Манж хаан Далай ламыг ордондоо урьсан тухай;

40а талд Гүүш номын хаан нас барсан тухай;

40в талд Зая бандид 64 насан дээрээ нас барсан тухай, түүний хойт дүрийг тодруулсан тухай;

41в талд Хүрэн бэлчир хэмээх газар хэлэлцээр хийсэн тухай;

42а - 42в талд Галдан бошигт, Халхад довтолсон, Жавзундамба хутагт Манжид зугтаасан тухай;

42в - 43а талд Цэвээнравдан, Галданцэрэн нар дараалан хаан ширээнд суусан тухай ;

43в талд Ажаа Цэвээндоржнамжил, Ламдорж, Даваач нар богино хугацаагаар хаан ширээ эзлэн суусан тухай;

44в - 45а талд Захчины Маамууд зайсангийн тухай, Ойрд, Үндсэн ламтан Цүлтэмринчен 57 нас хэрсэн, Үенчийн Улаан сүм гэдгийг байгуулсан тухай;

47в - 48а талд Хэвт ёсны гуравдугаар он цагаагчин гахай жил бичсэн төгсгөлийн үг;

Үүний дараа 48а - 52в талд он цагийн жагсаалт;

5I - 65а талд гүн Мингийн зарлиг байна. Үүнд Ойрдын гарал, шашны дэлгэрсэн түүхт явдал зэргийг товч боловч тоочин бичсэн сонирхолтой хэсэг буй.

65а - 69а талд цанид дацан байгуулсан тухай ;

69в - 85а талд цанид дацангийн малын данс,өргөл барьцанд ирсэн зүйлийн жагсаалт;

85в- 86а талд энэхүү данзайг бичсэн Дармабадраагийн / Чойсамбуу/ бичсэн төгсгөлийн үг байна.

2. Зая бандидын хийсэн ажил үйлс

Раднаабадраагийн зохиосон ,, Сарны гэрэл" гэдэг зохиолоос Ойрдын Зая бандидын намтар, хийж байсан ажлын төлөвийг мэдэж болно.

Ойрдын Зая бандид Намхайжамц бол хошуудын хүн бөгөөд эцэг нь Баавхан юм. Зая бандидын өвөг нь Дөрвөн Ойрдод ихэд алдаршсан Хүнгүй Заяач гэдэг хүн байжээ. Баавхан найман хүүтэй байсны тавдугаар нь Зая бандид Намхайжамц юм.

I599 он буюу шороо гахай жил Зая бандид төржээ. Зая бандидын I7 хүртлэх насны үйл явдлыг ,, Сарны гэрэлд" дурдсангүй.

Анхааран үзвэл ,, Сарны гэрлийг" зохиогч Раднаабадраагийн гарт Зая бандидын багын амьдрал, үйл явдлын талаар тодорхой хэрэглэгдэхүүн байсангүй бололтой[I3]. Ер нь бодож үзэхэд Намхайжамц Ойрдын язгууртны хөвгүүдийн нэгэн адил байж I7 нас хүрсэн болохоос зайлахгүй.

Тэр цагт Дөрвөн ойрдын ноёд нэг нэг хүүдээ сахил хүртээж банди болгоё гэж тохиролцсонд Байвгас баатар Намхайжамцыг үрчлэн авч сахил хүртээж банди болгосон байна.

Намхайжамц Ойрд нутгаас гарч Төвдийг зорин явсаар I6I6 онд Хөх нуурт хүрээд улмаар I6I7 онд Төвдийн Цогт Брайбүн хийдэд очиж суужээ.

Ингээд Төвдөд I6I6-I638 он хүртэл 20 гаран жил суухдаа ,, таван ухааны" номыг гоц сурснаараа бусдад гайхагдаж байжээ. Зая бандид цанид хэмээх гүн ухааны талаар ,, рабжамба"[I4] гэдэг цол хамгаалахдаа нэг ч үг эс алдсанд бүгдээрт гайхагдаж алдар нэр нь дуурисан байна.

Ингээд Зая бандид I638 онд Төвдөөс Ойрд нутаг руу явжээ.

Зая бандидыг Дөрвөн ойрдод буцахын өмнө түүнд Үү Далай лам ,, ... чи ер өтөл бус шавь гэж мутар дахь эрэхээ хайрласан ажээ... Миний төлөө монгол хэлтэнд шашин хийгээд амьтанд ном орчуулж туслан үйлд..."[I5] гэж хэлсэн байна.

Зая бандид I639 оны намар Дөрвөн ойрд, Тарвагатайн Харавгайд, Очирт тайжийн дээр ирж өвөлжжээ.

I640 онд Ойрд, Халхын ноёд цугларч ,, Их цааз" гэдгийг тогтоохоод Зая бандид оролцсон эсэх талаар тодорхой баримт ,,Сарны гэрлээс" олдохгүй байна. ,, Тэндээс долоон хошуу Дөрвөн ойрд чуулга буй. Монголын Засагт хан, Ойрд хоёр тайж тэргүүтэн буй"[I6] гэснээс өөр зүйл дурдсангүй. Эрдэмтэн К.Ф.Голстунский бол Зая бандидыг тэр чуулганд оролцсон гэжээ Үнэхээр ч дээрх чуулганд оролцсон болов уу гэдэг үндэс бас байна.

I639 оны намар Төвдөөс ирмэгцээ Тарвагатайд,

Очирт тайжийн дээр өвөлжөөд 1640 онд болсон чуулганд Баатар хун тайж зэрэг Ойрдын бусад дээдэстэй эн зэрэгцэх байранд Зая бандид байсан учраас л түүний нэр нь Халхын ноёдод алдаршиж 1641 оны хавар Халхын Засагт хан элч илгээн Зая бандидыг урихад хүрсэн байж болохоор байна. Хэрэв 1640 оны чуулганд Зая бандид оролцоогүй байсан бол Халх нутгаас зайдуу Тарвагатайд, Очирт тайжийнд, Төвдөөс ирж өвөлжсөн нэгэн залуу ламыг Халхын ноёд яахин мэдэх билээ.

1641 оны хавар Засагт хан, Зая бандидыг залж тэндээс Түшээт хаан, Цэцэн хан дамжуулан залсан байна.Зая бандид ийнхүү залагдан явсаар 1642 онд Ойрддоо буцаж ирсэн байна. Халхад Зая бандидын явсан зорилго мөн л тодорхой бус юм.Гэвч Халх долоон хошуунд Зонховын шашныг дэлгэрүүлэхийн чацуу гурван хаантай биеэр учирч Манж Чин улсын түрэмгийлэлийн эсрэг нэгдэх гэсэн Монгол Ойрдын хуулийн үзэл санааг тэдэнд давтан сануулах зорилгоор явсан[17] бололтой гэсэн доктор И.Я.Златкиний тодорхойлолт туйлын оновчтой бололтой.

Зая бандид 1650 оноос бус,1642 оноос эхлэн ном орчуулсан баримт бидэнд байна. 1642 онд „ Банчин хутагтын туух" гэдэг номыг орчуулжээ. Бас Халхын Засагт хан „ Эцгийн ном" хэмээхийг орчуулж өгнө үү хэмээн хүссэн ёсоор энэ онд эхлэн орчуулаад Бугас хэмээх газар Очирт тайжийн дээр өвөлжжээ[18].

1643 оны 6-р сард Халхын Засагт ханы хүссэн ёсоор „ Эцгийн номыг" орчуулж төгсөөд Хөндлөн Дүүрэгч буюу Хөндлөн Увшийн дээр Хаслаг хэмээх газар өвөлжжээ[19].

1644 оны зун Зая бандид, Байвгас баатрын хүү Очирт тайжийн дээр зусч байтал Дархан цорж гэдэг

хүн түүнийг Эрчисийн сүмд залж „ Маань Гамбум" орчуулж өгнө үү гэсэн ёсоор мөн оны өвөл уг номыг төгсгөн орчуулжээ[20].

Зая бандид, Халхын гурван аймагт зочилсныхоо дараахан 1645 онд Ижил мөрний Халимагт очлоо[21].

Халимагт очиход Хоо Өрлөгийн хөвгүүд Шүхэр дайчин, Гомбо Илдэн, Лувсан, Санж тайш, Кирсан нар хүндлэн угтаж барьцыг сэтгэшгүй их өргөжээ[22]. Зая бандид ч дээд, дунд, доод давхаргатны сэтгэлд зохилдуулан бурхны номыг номлосон байна. Энд Зая бандид бурхны ном номлож явсан үнэн баримт байгаа болов ч түүний цаана улс төрийн ямар бодлого нуугдаж байсныг тааварлахгүй өнгөрч болохгүй юм.

Зая бандид, Халхын гурван аймагт аялсныхаа дараахан /2 жилийн дараа/ Ижил мөрний Халимагт очсоны шалтгаан бол Халимагийг Баатар хун тайжийн удирдлагын дор нэгтгэх бодлогыг Шүхэр дайчин тэргүүтэй Халимагийн ноёдод ятгаж явсан хэрэг биш байгаа.

1646 оны хавар Хөндлөн Увш, хошуудын Цэцэн хан, Баатар хун тайж хоёрт цэрэглэн халдаж тулалдсан байна. Ийнхүү Хөндлөн увш, хоёр тайжийг /Цэцэн хан , Баатар хун тайж/ эвлэрүүлэх зорилгоор Зая бандид эхлээд Хөндлөн Увштай уулзаж, дараа нь Ильд нутаглаж байсан Цэцэн ханыд очиж байжээ[23].

Ингээд 1646 оны өвөл Зая бандид Шар тохой хэмээх газар Авлайн дээр өвөлжсөн ажээ[24].

1647 оны өвөл Хөндлөн Увшийг Цэцэн хан, Баатар хун тайж хоёртой Зая бандид уулзуулж тэднийг эвлэрүүлэв. Мөн онд Баатар хун тайж Каракалпакт цэрэг мордуулахад Цэцэн хан тэр хоёрын хооронд хов жив орсныг зохицуулан зөв бурууг нь ялгаруулж өгчээ[25].

Мөн оны зун Хошуудын Цэцэн хан, Зая бандидтай

уулзжээ [26]

1648 оны зун Зая бандид Баатар хун тайжийн дээр зусаж,, өвөл нь Зүй хэмээх газар Авлайн дээр өвөлжиж байхдаа бидний тодорхойлон хэлэлцэх гэж байгаа тод үсгийг зохиолоо[27].

1649 оны өвөл Зая бандид Бор талын сүмийн хавь Хар бутан хэмээх газар өвөлжижээ[28].

1650 онд Зая бандидыг Ойрдын зарим ноёд энд тэнд залж байсан заллагыг хүлээн авч Талхи, Илийн хуланч, Булган голоор явж байгаад мөн намрын дунд сард Хөөргийн говь хэмээх газраас Төвд орохоор явж байх замдаа Булингар хэмээх газар өвөлжив[29].

Ийнхүү Зая бандид 1638 онд Төвдөөс Дөрвөн ойрдод буцаж ирснээс хойш 12 жилийн дараагаар дахин Төвдөд очих болсон нь бидэнд сонирхолтой байна. Багш шавийн барилдлагаатай болсон хуучин танилуудтайгаа уулзах жирийн нэгэн зорилго Зая бандидад байсан уу, эсвэл Монгол, Ойрд, Төвд, Манж чин улсын гадаад дотоод улс төрийн бодлоготой холбогдол бүхий нарийн төвөгтэй асуудал байсан уу гэдэг талаар Зөвлөлтийн түүхч доктор И.Я.Златкиний бичсэн ,,Зая пандита как политический деятель"[30] гэдэг сонирхолтой өгүүлэл байгаа юм.

Зая бандид, Булингараас хөдлөж 1651 оны хавар Хөх нуурт хүрчээ. Тэр үед Далай лам, Их шаваа /ширээт/, Гүүш хаан нар Цэцэг тал хэмээх газар очоод Хар хотод удлэхэд Зая бандид тэнд уулзаж байлаа[31]. Зая бандидыг Төвдөд хүрэлцэн очиход шарын шашны эрхэм хүний ёсоор ихэд хүндлэн угтсан байна.

Зая бандид 110,000 лан мөнгөтэй Төвдөд очиж өргөл барьц барих, их лам нарын санд өргөх, бурхан бүтээх, Барибүн хийдийн дээврийг алтдах тэргүүтэнд зарж ,, Намсрайн хөвгүүн мэт баян" хэмээн нэрд

гарсан байна.

Ингээд Зая бандид хар луу жил буюу 1652 онд Хөх нуурын хөвөө Шавартай хэмээх газраар дайран тэнд мөргөл тавиад Ойрд нутагтаа буцсан байна[32].

1653 онд Зая бандид Төмөр цорго хэмээх газар Авлайн дээр өвөлжив. Энэ жил Баатар хун тайж нас барсан ажээ[33].

1654 онд Зая бандид Булнайн усан хужир хэмээх газар Авлайн дээр зусаад Торгуудад явсан байна. Энэ жил Зая бандид Ураг Мунцаг гэдэг газар өвөлжжээ[34].

1655 онд Ойрдын Тойн Омбо, Аюуш ноён, Алдар тайш, Огжодва, Мэргэн тайж, Гомбо-илдэнгийн хөвүүн Санжин, Үржин, бас Намуцэрэн, Шарав Омбо зэрэг ноёд Зая бандидыг залж байлаа. Тэгээд Зай хэмээх газар Дайчингийн /Шүхэр дайчин ?/ дээр хүрч өвөлжив[35].

1656 онд Ойрдын ноёд Лувсан, Огжодва, Тугал , Мэргэн тайж нар хоорондоо муудалцахад Зая бандид эвлэрүүлж байв. Тэгээд энэ жил Дөрвөд Тойны дээр Хар хуум хэмээх газар өвөлжсөн байна[36].

1657 онд Ойрдын зарим ноёд Зая бандидыг урин залж байснаас гадна Эрчис мөрөнд байгуулсан Авлайн хийдийг амилуулахад их лам нар түүний дотор Зая бандид оролцож очсон байна.

Энэ жилийн зун Зүүн гарын ноёд хоёр анги болж баруун хэсгийг Цэцэн хан, зүүн хэсгийг Авлай нар тэргүүлж тулалдахыг завдсанд Зая бандид эвлэрүүлсэн удаа бий. Тэгээд тэр өвөл Бөкүүний голд өвөлжив[37].

1658 онд Зая бандид Цэцэн ханыд айлчлан ирэхэд Цэцэн хан удийн газар, түүний хатан Пунцагролма зуур хоногийн газраас угтан авав. Тэр жил Шар тохой хэмээх газар зусаад мөнөөхөн Шар тохой хэмээх газар өвөлжив[38].

1660 онд болсон онц явдал бол , тэр оны намар Байвгас баатрын / эх тусгаартай/ хөвгүүд Цэцэн хан, Авлай хоёр Зая бандидын дэргэд аминчлан уулзжээ. Энэ уулзалтаар Зая бандид, Цэцэн хан, Авлай хоёрыг эвлэрүүлэх гэсэн боловч амжилтгүй болсон нь бидэнд илэрхий юм. Тэр өвөл Зая бандид, Хар тал хэмээх газар өвөлжлөө[40].

1661 онд Цэцэн хан, Авлай хоёр байлдаж Авлай дийлдсэн байна. Зая бандид, Төвдөд явах тухай дотно хүмүүстэйгээ зөвлөж Төгрөг хонгор өлөн хэмээх газар өвөлжжээ[41].

1662 онд Зая бандид, Төвдөд явах замын зуур үсэг саамал хэмээх газар нутаглаж байсан Сэнгээгийн өргөөнд арваад хоноод цааш Төвдийг зорин явах замын зуур нас барлаа[42].

/Он онд Зая бандидын хийсэн үйл ажлыг сурвалж бичгээс түүвэрлэн авсан цэсийг нэгдүгээр хавсралтаас, Зая бандидын зорчин явсан замын тойм зургийг хоёрдугаар хавсралтаас үзнэ үү/.

Монголын соёлын түүхэнд ойрдын Зая бандид Намхайжамцын оруулсан хувь нэмэр их юм.

Үүний нэг нь 1648 онд монгол бичгийг засварлан тод болгож тодорхой үсгийг зохиосон явдал болно.

Нөгөө нь 1650-1662 оны хооронд шамдан ажиллаж 10 гаруй жилийн хугацаанд 170 гаруй номыг төвд хэлнээс монгол хэлнээ орчуулсан явдал юм.

Хоёрдугаар бүлэг

ОЙРДЫН ЗАЯ БАНДИДЫН ЗОХИОСОН ТОД ҮСЭГ

1.Тод үсэг зохиох болсон шалтгаан

Монголчууд эрт дээр цагт уйгаржин үсэг авч хэрэглэсэн бөгөөд чухам хэдийд энэ үсгийг авч хэрэглэснийг эрдэмтэд одоогоор олж тогтоогоогүй байсаар байна. Ер нь уйгаржин бичгийг монголчууд Уйгараас уламжлан авсан юм уу Согдоос уламжлан авсан юм уу гэдгийг нягтлан судлаагүй байна.

Эрт цагт монголчуудын авч хэрэглэсэн уйгаржин үсэг бол аажимдаа амьд ярианы хэлнээс ихэд зөрөөтэй болж ирсэн байна.

Ингээд монголчууд бичиг үсгээ өөрчлөн амьд ярианы хэлэнд ойртуулах оролдлого гарсаар байжээ. Ийнхүү өөрчлөн сайжруулах оролдлого нь хоёр чиглэлтэй байсан байна. Нэгдүгээр чиглэл нь, харь улс үндэстний үсгийг авч монгол хэлнээ тохируулан хэрэглэх, хоёрдугаар нь уйгаржин монгол үсгээ засан сайжруулах чиглэл байв.

Юань улсын үе 1269 онд Пагва ламын зохиосон дөрвөлжин үсэг бол төвдийн үсгийг тэр хэвээр авсан нь бидэнд мэдээж юм. Дөрвөлжин үсэг буюу улсын үсгийг зөвхөн монгол хэлтэнд зориулан зохиосон бус Юань улсын доторхи бусад улс үндэстний хэрэглэвэл зохих нийтийн үсэг болгох зорилтыг тавьсан юм.

Дөрвөлжин үсэг дэлгэрүүлэхийг хүчлэн чармайж Юань улсын төрийн зүгээс өдий тедий зарлиг тунхаг гаргасан боловч тедий л их газар авч чадаагүй байсаар уйгаржин монгол бичигтээ дахин шилжин орсон байна.

Дөрвөлжин үсгийн дараагаар бичиг үсгээ сайжруулах гэсэн нэгэн оролдлого бол бидний тухайлан авч хэлэлцэх гэж буй тод үсэг юм.

Ойрдын Зая бандид Намхайжамц бол харь улс үндэстний үсгийг авч хэрэглэхийг шамдсангүй урьд өмнө хэрэглэж байсан уйгаржин монгол үсгээ тодорхой болгож ярианы хэлэнд ойртуулсан тод үсэг зохиох чиглэлийг баримталжээ.

Ойрдын Зая бандид яагаад тод үсгийг зохиох болсон бэ гэдэг асуудал урьдын судлаачдын ч сонирхлыг татаж байв. Одоо ч гэсэн энэ асуудал сонирхолтой хэвээр байна.

Тод үсэг зохиосон үеийн түүхэн нөхцөл байдлыг[43] хянан үзэх явдал бол тэр үсэг зохиосон шалтгааныг үнэн зөвөөр тайлбарлахад тус нэмэр болох юм.

ХҮП зууны дөчөөд он бол монголын тусгаар тогтнолын түүхэнд түгшүүртэй үе байсан билээ. Манж Чин улсын булаан эзлэгчид өвөр монголыг эзлэн авч Халх Зүүн гарыг заналхийлж байсан үе юм. Тэр үед Халх, Зүүн гарын ноёд өөрсдийн дотоодын бутрал самууныг намжааж, харийн түрэмгийлэгчдийн эсрэг нэгдэн тэмцэх оролдлого гарч байсан байна.

Халх, Зүүн гарын ноёдын иймэрхүү оролдлогыг нэгэн үе Зүүн гарын Эрдэнэ баатар хун тайж толгойлж байсан болов уу гэж үзэхээр баримт түүхэнд цухас гарч байна.

1640 оны 9-р сард Халхаас Засагт хан, Түшээт

хаан биеэр, Цэцэн ханы хоёр хүү, Хөх нуураас Гүүш хан, Ижил мөрнөөс Хоо өрлөг, Зүүн гарын Эрдэнэ баатар хун тайж, Очирт тайж зэрэг нэртэй томхон феодалууд Зүүн гар улсын нутаг Тарвагатайд хүрэлцэн ирж чуулаад „Дөчин, Дөрвөн хоёрын их цаазыг" тогтоосон байна.

Энэхүү „Их цаазын" нэгдүгээр зүйлд Монгол Ойрд хоёрын нэгдлийн тухай зүйлийг оруулсан байна.„ Алив хүн энэ төрийг эвдэн, их аймаг улсыг алж талж авбал монгол ойрд хоёр нэгдэвд / Л-Б. онцлон зурав/ түүний ганц биеий нь тавиад биш бүхнийг цөм авч тавигчид хагасыг нь өгөөд үлдсэн хоёр хагасыг авах болов"[44] гэжээ. Мөнхүү хуулийн дараачийн зүйлүүдэд харийн дайсныг / Манжийн түрэмгийлэлийг/ сэргэмжлэх асуудлыг чухалчлан заасан байна. „Монгол Ойрдод дайсан ирвэл хэл өг. Тэр хэл сонсож байж захын их ноёд эс ирвэл зуун хуяг, зуун тэмээ, мянган адуу авах. Бага ноёд эс ирвэл арван хуяг, арван тэмээ , зуун адуу авах болов"[45]гэжээ. Цааш нь „Их дайсныг үзэж сонсож байж эс хэлбэл урийн үр хөөж алъяа, талъяа"[46] гэж тогтоосон байна.

Ийнхүү Халх ойрдын нэгдлийг ихэд анхаарсан 1640 оны „Их цааз"-ыг хэн санаачилж зохиосон бэ гэдэг асуудлын тухай Зөвлөлт Холбоот Улсын эрдэмтэн түүхч И.Я.Златкин бичихдээ уг хуулийн эх нооргийг зохиож чуулганыг зарлан хуралдуулагч нь Зүүн гарын хан Баатар хун тайж мөн бололтой[47] гэжээ.Бас 1640 оны ноёдын чуулганыг Халх, Хөх нуур, Ижил мөрөнд бус Зүүн гар улсын нутаг Тарвагатайд хийсэн явдал бол Баатар хун тайжийн санаачилсан гэдэг баримтыг батлах нэмэлт зүйл болохыг түүхч И.Я.Златкин бичсэн байна[48].

Энэхүү хуулийг тогтоосноос хойш нэг жилийн да-

раа буюу 1641 онд Зая бандид Намхайжамц Халхын гурван аймгаар зочлон яваад 1642 онд ойрдод буцаж ирсний дараахан 1645 онд Ижил мөрний халимагт зочилж байсан нь түүний намтраас тодорхой болохыг дээр дурдсан билээ.

Зая бандид ийнхүү энд тэнд зочилж байсны гол шалтгааныг давтан хэлэхэд Зүүн гарын Баатар хун тайжийн удирдлагын доор Халх долоон хошуу[49], Зүүн гар зэргийг нэгтгэж Юань улс мэт том улс байгуулах зорилго тавьж байсан юм биш байгаа.

Ойрдын Зая бандид 1643-1644 онд орчуулсан „Маань гамбум"-ын төгсгөлийн үгэнд Эрчис мөрнийг „Юань улсын өр"[50] гэж бичсэн явдал бол ерийн нэгэн сул задгай үг хэмээн үзэж болохгүй, харин Ойрдоор төв болгосон нэгдсэн улс байгуулах гэснийг давтан батлах баримт юм биш үү.

Улс төрийн ийм л орчинд Зая бандид тод үсэг зохиосон билээ.

Үүний нөгөө талаар 1640 оны „Их цаазанд" онцлон тэмдэглэсэн нэг зүйл бол бөө мөргөл шүтэх явдлыг хуулиар хязгаарласан явдал болно. „Удган бөө хэн хүн авч явбал уригч хүний морийг ав,ирэгч удганы морийг нь ав, үзэж байж эс авбал түүний морийг ав,онго хэн хүн үзвэл авах болов. Эзэн нь булаалдаж эс өгвөл морийг нь ав"[51]гэжээ. Үүгээр үзвэл халх, ойрдын аль алинд бөө мөргөлийн нөлөө хүчтэй байсны гэрч мөн.

Зая бандид Төвдөөс Ойрдод буцаж ирэхдээ шарын шашны тэргүүн нараас ямар эш зарлигтай байсныг тодорхойлох баримт „Сарны гэрэл" болон „Алтан эрхэн" гэдэг сурвалж бичигт тохиолдож байна. „Мөн энэ жил / Шар барс жил буюу 1638 он/ ойрд хутагтын гэгээн гурван богдын эш зарлигаар ер монгол хэлтэн,ялангуяа

Долоон хошуу Дөрвөн ойрд нутагт шарын шашин дэлгэрүүлэхийн тул Зуугаас Ойрд нутагт залрав"[52] гэжээ.

Энд онцлон тэмдэглэсэн „Ялангуяа Долоон хошуу Дөрвөн ойрд нутагт шарын шашин дэлгэрүүлэх" гэж байгаагаар үзэхэд Зая бандидын үйл ажиллагааны хүрээ зөвхөн Дөрвөн ойрдоор хязгаарлагдаж байсан хэмээн нотлох үндэс байхгүй юм.

Ер нь тод үсэг зохиох болсон шалтгааныг нэгдүгээрт, улс төрийн бодлогын үүднээс, нөгөө талаар шарын шашныг дэлгэрүүлэх зорилгын үүднээс уялдуулан авч үзэх нь зүйтэй. Тод үсгийг Зая бандид зөвхөн Дөрвөн ойрдод зориулан зохиосон гэж нилээд эрдэмтэд үзсээр ирлээ. Одоо ч гэсэн зарим эрдэмтэд чингэж үзсээр байна. Гэвч тод үсгийн материалыг нарийвчлан судлаагүйгээр ийм дүгнэлт хийж байгаад шүүмжлэлтэй хандах хэрэгтэй юм.

Зая бандидын өөрийн нь зохиосон „Үсгийн найрлага"[53]гэдэг цагаан толгойн төгсгөлийн үгэнд үсэг зохиох болсон зорилгоо товч боловч дурдсан байна . Энэ цагаан толгойн төгсгөлийн үгийг хойно сийрүүлбэл :





гэжээ[54].

Энд дурдсан „Омог Монгол улсын хувьтанд хялбэр болгохын тул" зохиосон үсгийг зөвхөн Дөрвөн ойрдын үсэг гэж батлах үндэс бидэнд байхгүй юм.

Дээр дурдсанаар „Ер монгол хэлтэн, ялангуяа Долоон хошуу, Дөрвөн ойрд нутагт шарын шашин дэлгэрүүлэх" эш зарлигийг Далай лам, Банчен богдоос авсан Зая бандид мэтийн хүн, бурхан шашны ном зохиол бичих үсгээ зөвхөн Дөрвөн ойрдод зориулан зохиох уу гэдэг зүй ёсны асуудал гарах[55] билээ.

Алив туурвисан ажлын эхлэл, түүний үр дүн хоёр хоёр өөр байж болно. Тод үсгийг эхлэн зохиоход бүх монгол хэлтэнд зориулан зохиосон боловч, түүний үр дүн нь Дөрвөн ойрдын бичиг болон үлдсэн юм биш үү.

Зая бандид тод үсгийн бичлэг, дүрмийн талаар чухам юу зохиож туурвисаны тухай тодорхой мэдэх баримт одоогоор бидэнд байхгүй байна. Түүгээр ч

барахгүй тод үсэг зохиосон он цагийн тухайд зарим сурвалж бичиг будилсан[56] байна.

„Сарны гэрэл"-д тод үсгийг зохиосон тухай дурдахдаа „Тэр зун Зүүн гарын Баатар хун тайжийн дээр зусав. Тэр жилийн өвөл Авлай тайж Зүйд хамт өвөлжив. Тэр хулгана жилийн өвөл тодорхой үсэг зохион үйлдэв"[57] гэжээ.

Гэтэл „Дөрвөн ойрдын тууж түүх" гэдэг бичмэлд „Арван нэгдүгээр жарны эхэн аравдагч гал хулгана жилийн өвөл Баатар хун тайж тэр хоёр өвөл Зуугийн голд хамт өвөлжиж тойн цэцэн Равжамба Зая бандидын гэгээн /ийг/ залсанд тэнд тодорхой номын үсэг..."[58] зохиосон гэжээ. Энэхүү II-р жарны эхэн аравдагч гал хулгана жил гэдэг нь 1636 онтой тохирч байгаа юм. 1636 онд Зая бандид Баатар хун тайжийн дээр байгаагүй Төвдөд байсан байна. Ийм учраас „Дөрвөн ойрдын тууж түүхэнд" байгаа энэ зүйл тодорхой боловч үнэн баримтаас 12 жилээр зөрж байна.

2. Тод үсгийн үсэг зүй

Тод үсгийн нилээд хэдэн цагаан толгой бидэнд олдсон бөгөөд зарим нэгэн сонирхолтой цагаан толгой байгаа тухай мэдээ бидэнд байна. Жишээ нь Захчинд „ " гэдэг ном[59] байжээ.

Зая бандид „ " гэдэг зохиол орчуулсныг „Сарны гэрлийн" монгол эхэд хавсарган нийтлүүлснийг бид сайн мэдэх билээ. Түүнээс гадна 1965 онд Увс аймгаас „ " гэдэг цагаан толгой бид олж ирсэн юм. Энэхүү „Үсгийн найрлага" гэдэг цагаан толгой оол тод үсгийн талаар туурвисан Зая бандидын анхны бүтээлүүдийн нэг мөн бололтой. Энэ цагаан толгойн товч агуулгыг доор

сийрүүлбэл: Нэгдүгээрт, эхлэл үг 2 бадаг шүлэг , хоёрдугаарт, Энэтхэгийн 50 үсэг /I6 эгшиг, 34 гийгүүлэгч/ түүнийг галиглах ёс, гуравдугаарт, төвдийн 30 үсэг, түүнийг галиглах ёс, дөрөвдүгээрт , монголын I6 үсэг(a, na, xa, γa ; da, ta, ba, ma ; za(ǰa, za),ca(ča-ca), ya, ra ; la , va, sa , ša) буюу тодорхой үсэг, I3 дэвсгэр үсгийг тус тус бичжээ. Эцэст нь төгсгөлийн үг 7 бадаг шүлэг буй. „Үсгийн найрлага" гэдэг цагаан толгой маш товчхон боловч энэтхэг, төвдийн үсгийг хэрхэн галиглах, „Монголын I6 үсэг" буюу тод үсэг нь уйгаржин монгол бичгийн чухам юуг нь тодорхой болгож өөрчилсөн бэ гэдгийг мэдэх боломжийг бидэнд өгч байна.

Тод үсгийн эгшиг. Тод үсэгт a-г[60] уйгаржин монголтой бараг адил боловч адагт орсон а-г орхицоор / / тэмдэглэх нь туйлын ховор байна. Жишээлэхэд, уйгаржин монголд[61] baγan-a, тод монголд[62] baxana ;мо. aq-a ,то. aha; мо . daruγ-a , то. daruγa ; мо. yabuy-a , то. yabuya ;мо. то. padma ;мо. takiy-a , то. takā гэх мэт.

Тод үсэгт e-г[63] үгийн эхэнд титэмтэй, дунд адагт -гээр тэмдэглэсэн нь уйгаржин монгол үсгийн дунд адагт орсон -ээс е-г ялгаварлан тодорхой болгосон байн. Жишээ нь: мо: ende ,то. ende; мо. mes-e,mese,то. mese ; мо. nere,ner-e , то. nere ;мо. bere,ber-e, то. bere гэх мэт.

Тод үсэгт i-г[64] үгийн дунд адагт орсон хэлбэрийн талаар уйгаржин монголтой адил боловч уйгаржин монгол үсгийн үгийн дунд орсон у-гээс ялгаварлаж тодорхой болгосон байна.Жишээ нь: мо. itegel, то. itegel ; мо. amitan ,

то. amitan ; мо. yirtüncü-yin , то. yertüncüyin ;мо. daki, то. daki ; мо. tabin ,tabi, то. tabi гэх мэт.

Тод үсэгт о-г[65] дөрвөлжин гэдэстэй тэмдэглэжээ. Энэ нь уйгаржин монгол бичгийн -гоос о-г ялгаж тодорхой болгосон байна. Үгийн эхэнд титэмтэй, үгийн дунд адагт гоор тэмдэглэжээ. Жишээ нь:мо. oron,то. oron ;мо. olanta, то. olonto гэх мэт .

Тод үсэгт u-г[66] гэдэстэй урдаа өргөстэй[67] тэмдэглэжээ. Энэ нь уйгаржин бичгийн -гаас u-г ялгаж тодорхой болгосон байна. Үгийн эхэнд титэмтэй,үгийн дунд , адагт болгож тодруулан тэмдэглэсэн байна. Жишээ нь: мо. uxaγan,то. uxān мо. dusul,то. dusul; мо. bolqu , то. bolxu гэх мэт .

Тод үсэгт ö-г[68] дөрвөлжин гэдэстэй дээд талдаа өргөстэй тэмдэглэжээ. Энэ нь уйгаржин бичгийн -гөөс ö -г ялгаж тодорхой болгосон байна. Үгийн эхэнд титэмтэй, үгийн дунд адагт -гээр тэмдэглэсэн байна. Жишээ нь: мо. örgen,то. örgün ;мо. törülkiten,то. törölkitön ; мо. böger-e,то. börö гэх мэт.

Тод үсэгт ü-г[69] гэдэстэй тэмдэглэжээ. Уйгаржин үсгийн -гээс ü-г тодорхой болгожээ. Үгийн эхэнд титэмтэй, үгийн дунд адагт -гаар тэмдэглэсэн байна. Жишээ нь: мо. ügei, то. ügei, мо. üjüg,то. üzüq,мо. degedü,то. dēdü гэх мэт.

А-гийн төрлийн долоон үсгийг хүснэгтээр үзүүлбэл:

	мо	то	мо	то	мо	то	мо
эхэн							
дунд							
адаг							
галиг	a	a	e	e	i	i	o

	то	мо	то	мо	то	мо	то
эхэн							
дунд							
адаг							
галиг	o	u	u	ö	ö	ü	ü

Тод үсгийн гийгүүлэгч. Тод үсэгт na -г[70] хоёр араатай өмнөө нэг цэгтэй тэмдэглэсэн нь уйгаржин монголоос ялгасан зүйл үгүй. Гэвч тод үсгийн амьтай n үсэгт ямагт цэг тавьдаг заншилтай юм. Гэтэл уйгаржин бичгийн гар бичмэл, барын номд a, na хоёрыг ялгаваргүй бичдэг. Жишээ нь: гэхийг ayan ч гэж уншиж болно, nayan ч гэж уншиж болно. Тод үсгийн n-ийг үгийн эхэнд үгийн дунд (n+v), (n+c), адагт хэлбэрээр тэмдэглэнэ. Жишээ нь: мо. namur, то. namur, мо. ün-e-tei, то. ünetei; мо. tende, то. tende; мо. köbegün, то. köbüün гэх мэт.

Тод үсэгт ng-г тэмдэглэсэн нь уйгаржин монгол үсгээс ялгаварлагдах зүйлгүй. ng үсэг үгийн эхэнд эгшгийн өмнө үл тохиолдоно. Жишээлбэл: мо. singgeküi, то. šinggeküi; мо. amuγulang, то. amuγuulang гэх мэт.

Тод үсэгт ха-г[71] үгийн эхэн, дунд гурван араатай өмнөө хоёр цэгтэй тэмдэглэсэн нь уйгаржин

монгол бичгийн γa/qa -гаас ха-г ялган тодорхой болгосон байна. ХҮП зууны бичмэл судруудад qa(q+v)-г тод үсгийн адил толгойгүй, толгойн оронд нэг арба нэмж бичсэн явдал байдаг. qa-г ингэж тэмдэглэхийг Зая бандид санаачилсан бус угаас ингэж бичиж байсан уламжлалтай байжээ. Жишээ нь ХҮП зууны үеийн бичмэл „Маань гамбумын" сударт: /37а/qudaldučin, /6в/ qoγosun; /24а/ qoγar aqamad, /23а/aq-a degü, /23в/qar-a aγulan, /23а/qomq-a иймэрхүү бичлэг өдий тедийг олж болно. Харин Зая бандид тэр үеийн иймэрхүү бичлэгийг журамлан х-г хоёр араатай, өмнөө хоёр цэгтэй тэмдэглэх болгосон байна. Жишээлэхэд : ХҮП зууны үеийн цэггүй бичмэлээр бол гэхийг qalaγun, эсвэл γalaγun гэхийг aqui, эсвэл aγui гэж уншиж болох жишээтэй байхад тод үсэгт xaloun, axui гэх зэргээр тодорхой ялгаж байна.

Тод үсэгт ке[72]-г үгийн эхэн дунд тэмдэглэсэн нь уйгаржин үсгийн g/k-гээс к-г ялгаж тодорхой болгосон байна. К-гийн энэхүү өргөстэй хэлбэрийг эрт үеэс уламжлан ирсэн хэлбэрээс үлгэр болгон авсан байж магадгүй. Жишээ нь „Бодичиръяа Авадарагийн" I56в, I57а талд kemen, kiged гэх мэт. Уйгаржин монгол бичигт гэдгийг gem, эсвэл kem гэж уншиж болно. Гэтэл тод үсэгт gem kem гэж ялган бичнэ. Уйгаржин монгол бичигт гэж бичээд gübege, köbege гэж алинаар нь ч уншиж болно. Гэтэл тод бичигт gübē, köbō гэж ялгаж байна.

Тод үсэгт γa-г[73] үгийн эхэн дунд гурван араатай өмнөө бинттэй тэмдэглэсэн байна. Энэ нь уйгаржин үсгийн q/γ -гаас γ -г ялгаж тэм -

дэглэсэн байна. Уйгаржин үсэгт гэж байхад ongour, эсвэл ongγur гэж уншиж болно. Гэтэл тод үсэгт xongxor, xongγor гэж тодорхой ялгаж болно.

Тод үсэгт ge-г[74] уйгаржин монгол үсэгт байсан тэр хэвээр авсан байна. Жишээ нь мо. gegen , то.

Тод үсэгт q-аар уйгаржин монгол бичгийн γ хоёрыг тэмдэглэжээ. нь зөвхөн гийгүүлэгчийн g өмнө үгийн эцэст тохиолдоно. Жишээлбэл: мо. qamuγ , то. xamuq ; мо. bariγči, то. bariqči; мо. čečeg; то. ceceq; мо. üǰegči , то. üzeqči гэх мэт .

Тод үсэгт ka[75] нь уйгаржин монгол үсгийн heth+iγa+iya -гийн нийлбэрийн өмнө тохиолдож байна. Жишээ нь: мо. taqïy-a , takiy-a то. taḳā; мо. saqïγulsun, sakiγulsun , то. saḳuusun; мо. ǰoqïγal , ǰokiyal,то. zokōl; мо. dokiy-a,то. doḳō гэх мэт. Зая бандид уйгаржин үсгийн (heth+iγa+iya) -гаас уламжилж үсгийг авсан бололтой.

Тод үсэгт үгийн эхэн, дунд, адагт da -г[77] хэлбэрээр тэмдэглэсэн байна. Энэ нь уйгаржин үсгийн хэлбэрийг нэгтгэж зөвхөн d-гаар тэмдэглэсэн нь -г ялгаж тодорхой болгосон байна. Жишээлэхэд: уйгаржин үсэгт гэж бичээд teyin dayin гэж аль нэгээр уншиж болно. Тод үсэгт dayin гэж бичвэл өөрөөр дуудаж болохгүй юм. Ер нь d-г t-гээс ялгаж -гаар бичсэн зүйл ХҮП зууны үеийн гар бичмэлд тохиолддог юм. Энэ нь тод үсгийн нөлөө бус d,t хоёрыг ялгах оролдлого гарсаар байсны илрэл мөн.

Тод үсэгт ta-г[78] үгийн эхэн дунд адагт нэг хэлбэрээр тэмдэглэх болсон нь уйгаржин үсгийн -гээс t-г ялгаж тодорхой болгосон байна. Уйгаржин монголд гэж бичсэнийг dere tere гэж уншиж болно. Гэтэл тод үсэгт гэж бичсэнийг tere гэхээс өөрөөр уншиж болохгүй.

Тод үсэгт ba-г[79] тэмдэглэсэн нь уйгаржин монгол үсэгтэй адил байна. Гэвч адагт орсон b -г хэлбэрээр бичнэ. Жишээ нь: мо. то. гэх мэт.

Тод үсэгт ma-г[80] үгийн эхэн дунд адагт тэмдэглэсэн нь уйгаржин монголоос ялгаварлагдах зүйл байхгүй байна. Жишээ нь: мо. modun , то. modun ; мо. emegel , то. emēl мо. nom , то. nom гэх мэт .

Тод үсэгт[81] үсгээр z ǰ хоёр авиаг тэмдэглэсэн байна. Энэ нь уйгаржин монгол үсгийн үгийн эхэнд орсон -гаас ǰ(z) -г ялгаж, үгийн дунд орсон -гаас мөн ǰ(z)-г ялгаж тодорхой болгосон байна. ǰ,z хоёрыг ганц үсгээр тэмдэглэсэн бөгөөд i эгшиг юм уу, эсвэл i-гээс бусад эгшгийн өмнө орсноор ялгаж байжээ. Жишээ нь: мо. ǰun, то. zun; мо. γaǰar ,то. γazar; мо. ǰil то. ǰil ;мо. nayiǰi nar,то. nayiǰinar гэх мэт.

Тод үсэгт ca(či)[82] -г уйгаржин монгол үсгийн дунд орсон -гээс č c-г ялгаж тэмдэглэсэн байна. č,c хоёр авиаг ганц үсгээр тэмдэглэсэн бөгөөд i эгшгийн өмнө орсон юм уу, эсвэл i-гээс бусад эгшгийн өмнө орсноор ялгаж байжээ. Жишээлбэл: мо. caγ,то. caq; мо. elči, то. elči гэх мэт .

Тод үсэгт ya-г[83] тэмдэглэсэн нь уйгаржин монгол үсгийн -гаас у-г ялгавартай болгож тэмдэглэсэн байна. Жишээ нь: мо. yasu, то. yasu; мо. oyutai, то. oyoutai гэх мэт .

Тод үсэгт ra-г[84] үгийн эхэн дунд адагт уйгаржин монгол үсэгтэй адил тэмдэглэсэн байна. Жишээлбэл: мо. raqu, то. rahu; мо. ǰarliγ , то. zarliq, мо. edür, то. ödör гэх мэт.

Тод үсэгт la-г[85] үгийн эхэн дунд адагт уйгаржин монгол үсэгтэй адил тэмдэглэсэн байна. Жишээ нь: мо. blama, lama, то. blama, lama; мо. olan, то. olon; мо. gerel , то. gerel гэх мэт .

Тод үсэгт wa -г -гаар тэмдэглэсэн нь уйгаржин монгол үсгийн wa -гийн хэлбэрийг жаахан өөрчлөж үсэг нэмсэн байна. Ийнхүү шинэ үсэг нэмсэн нь -гаар е-г тэмдэглэсэнтэй холбоотой юм. Энэ үсэг монгол үгэнд тохиолдохгүй. Жишээ нь: то. byewa .

Тод үсэгт sa-г[86] үгийн эхэн дунд уйгаржин монгол үсгийн нэг адил тэмдэглэсэн байна. Уйгаржин монгол бичигт адагт орсон s-ийг хэлбэрээр бичдэг байсныг тод монгол үсэгт нэгэн мөр болгож -ээр бичих болсон юм. Жишээ нь: мо. sayin, то. sayin; мо. dürsü, то. dursü ; мо. ulus, то. ulus гэх мэт.

Тод үсэгт ša-г[87] уйгаржин монгол бичигтэй адил тэмдэглэсэн байна.i эгшгийн өмнө орсон s-ийг уйгаржин монгол бичигт s-ээр бичээд š-ээр унших байсан бол тод үсэгт цөм š-ээр бичих дуудах болжээ Бас s+iyi -г цөм тод үсэгт š-ээр бичих болсон байна. Жишээ нь: мо. sitügen , то. šütēn ; мо. gesigün , то. gesöün ; мо. ters-ün, то. teršiyin ; мо. ulus-un , то. ulušiyin гэх мэт .

Гийгүүлэгч үсгийг уйгаржин монгол үсэгтэй харьцуулан хүснэгтээр үзүүлбээс:

	мо	то	мо	то	мо	то	мо	то	мо	то	мо	то	мо	то
эхэн														
дунд														
адаг														
галиг	n		ng		a	x	k		v	γ q	g	g q		k

	мо	то	мо	то	мо	то	мо	то	мо	то	мо	то	мо	то
эхэн														
дунд														
адаг														
галиг	d		t		b		m		j	j z	č	č c	y	

	мо	то	мо	то	мо	то	мо	то	мо	то
эхэн										
дунд										
адаг										
галиг	r		l		w		s		š	

Тод үсгийн галиг. Зая бандид тод монголын I6 үсгийн хамтаар Энэтхэг, Төвдийг үсэгчлэн буулгах галиг зохиосон байна. Энэхүү галиг үсгийн тухайд холбогдох зохиол гэвэл Зая бандидын орчуулсан[88] "[illegible]", "[illegible]". зохиосон " Үзгийн найрлага" гэдэг цагаан толгойд галиг үсэг бий.

"Олон номын үндсэн үзгийн ялгаал гэдэг цагаан толгойд энэтхэгийн 50 үсэг, төвдийн 30 үсгийг галиглах ёсыг тодотгон өгүүлж "Энэтхэгт үгүй төвдөд буй үсэг аль вэ, Энэтхэг төвд хоёуланд буй өгүүлэх ёсон адил бус үсэг аль вэ, Зузаан үсэг аль вэ,хүчтэй үсэг аль вэ, дунд үсэг аль вэ, залгих үсэг аль вэ, урт үсэг аль вэ, их үсэг аль вэ, өчүүхэн үсэг аль вэ, эр үсэг аль вэ, эм үсэг аль вэ, манин үсэг аль вэ, маш урт үсэг аль вэ, таван махбодын үсэг аль вэ, тэдний дуун гарах найман орон аль вэ"[89] гэсэн. I5 асуултын хариу өгч, энэтхэг төвдийн үсгийг ангилсан байна. "Тарни унших аргыг хураасан хэмээх" ном нь эхлэлийн үг, гурван бүлэг, төгсгөлийн үгтэй юм. Нэгдүгээр бүлэг нь "[illegible]" гэсэн нэртэй бөгөөд үүнд I6 эгшиг, 34 гийгүүлэгч жагсаан бичээд эдгээр үсгийг 29 эр, I2 эм, манин 9 хэмээн ангилжээ. Хоёрдугаар бүлэг "[illegible]" гэсэн нэртэй бөгөөд огторгуйн махбодид хамаарах II үсэг, хий махбодид хамаарах II үсэг, гал махбодид хамаарах 9 үсэг, усан махбодид хамаарах I2 үсэг, шороо махбодид хамаарах 9 үсэг гэж ангилаад авиа нь хоолой, хэлний үзүүр шүд, орой, тагнай зэрэг газар бүтнэ гэжээ. Тэгээд гийгүүлэгч үсгийг ташаа бичвэл өвчин олон болох, эгшиг үсгийг буруу бичвэл аминаас хагацана, жирийн алдаатай болбол ургүй болно гэсэн байна. Гуравдугаар бүлэг "[illegible]"

"[illegible]" гэсэн нэртэй бөгөөд үүнд урт, богино үсгийг хэрхэн унших, тэргүүтэн,урвасан аймгийг унших ёс зэрэг зүйл орсон ажээ.

Зая бандидын зохиосон галиг үсгийг хойно сийрүүлбэл:

а. Энэтхэгийн I6 эгшиг

төвд										
тод										
латин галиг	a	ā	i	ī	u	ū	r	r̄	ḷ	ḹ

төвд						
тод						
латин галиг	e	i	o	au	am	ah

б.Энэтхэгийн 34 гийгүүлэгч

төвд												
тод												
латин галиг	ka	kha	ga	gha	na	ca	cha	ja	jha	na	ta	tha
төвд												
тод												
латин галиг	da	dha	na	ta	tha	da	dha	na	pa	pha	ba	bha

төвд										
тод										
латин галиг	ma	ya	ra	la	wa	ša	ša	sa	ha	kha

в. Төвдийн 30 үсэг

Төвд												
Тод												
латин галиг	ka	kha	ga	na	ča	čha	ǰa	na	ta	tha	da	na
Төвд												
Тод												
латин галиг	pa	pha	ba	ma	ca	cha	ja	wa	ža	za	'	ya

Төвд						
Тод						
латин галиг	ra	la	ša	sa	ha	a

Аюуш гүүш зохиосон, галигийнхаа зарим үсгийг аль болохоор төвд үсгийн хэлбэрт ойртуулахыг оролдсон байдгийг бид мэднэ[90].

Зая бандидын зохиосон галигаас олон үсгийн хэлбэр Аюуш гүүшийн галигтай[91] тохирч байгаагаар үзэхэд Зая бандид, галиг үсэг зохиохдоо Аюуш гүүшийн галигийг ашигласан нь лавтай байна. Гэвч Аюуш гүүшийн галиг үсгийн хэлбэрийг бага сага өөрчилсөн зүйл үзэгдэж байна. Жишээ нь: -г Аюуш гүүшийн галигт гэж бичсэн байхад Зая бандид төвд үсгийн хэлбэрт ойртуулж болгосон байна. -г Аюуш гүүшийн галигт -гаар бичсэн байхад Зая бандидын галигт төвд v эгтэй хэлбэрийг нь ойртуулж -гаар бичсэн байна. -г Аюуш гүүшийн галигт гэж бичсэн байхад Зая бандидын галигт хэлбэрээр тэмдэглэсэн байна.

Цаашид төвдийн -ya зүүсэн үсгийн ya -г Аюуш гүүшийн галигт гэх мэтээр бичсэн байхад Зая бандидын галигт ya -г тэр хэлбэрээр нь авч хэрэглэсэн байна. Жишээ нь: гэж тэмдэглэсэн байна. Ном судрын дотор орсон Самгарид тарни, төвд үг, хүний нэр зэргийг галиг үсгээр бичсэн нь олонт тохиолдож байна. Гэвч бичмэл дармал номын дотор хоорондоо төстэй үсгийг хутгасан алдаатай бичлэг элбэг тохиолдож байна.

3. Тод үсгийн авиан зүйн онцлог

Тод үсгийн баримт материалыг сайтар судлах явдал бол ХҮП зууны үеийн өрнөд, дорнод монголын аялгууны төлөв байдлыг мэдэх чухал баримт болж өгнө. Юуны өмнө бид тэр үеийн монгол хэлний эгшиг авианы тогтолцоонд ямар өөрчлөлт орчихоод байсныг авч үзье.

Хэдийгээр тод үсэг зохиогдоод 320 гаран жил болж байгаа боловч тэр үеийн материалыг шүүн үзэхэд эгшиг гийгүүлэгч авианы тогтолцоо нь одоогийн ярианы хэлнээс туйлын бага зөрөөтэй байжээ.

Нэгдүгээр үеийн эгшиг. Үгийн тэргүүн үеийн і эгшиг ихэнх нөхцөлд дараа үеийн уруулшсан эгшигтэй ижилшсэн байна. Жишээ нь: мо. ǰirγuγan, то. zurγān; мо. sitügen, то. šütēn; мо. sigüsü, то. šüüsü; мо. ǰiruqai, то. zuruxai; мо. siroi, то. šoroi; мо. siγui, то. šuγui; мо. sikür, то. šükür; мо. sibaγun, то. šobuun; мо. sirügün, то. šürüün гэх мэт. Гэвч тод үсгийн бичмэл барын номд тэргүүн үеийн і эгшиг цөм, дараа үеийн эгшигтэй ижилсээгүй байдал үзэгдэж байна. Жишээ нь: мо. nidün, то. nidün; мо. čilaγun, то. čiloun; мо. niγur,

то. niγour гэх мэт.

Үгийн тэргүүн үеийн е эгшиг ихэнх нөхцөлд уруулшсан эгшигтэй ижилшсэн байна. Жишээ нь: мо. ebül, то. übül; мо. edüge, то. ödüge; мо. edür, то. ödör; мо. ergün, то. örgün; мо. temür, то. tömür гэх мэт. Үүний нөгөө талаар тэргүүн үед орсон о, ö эгшгийн нөлөөгөөр дараах үеийн эгшгүүд нь зохицон уруулшсан явдал тод үсэгт үлэмж тохиолдож байна. Жишээ нь: мо. oron, то. oron; мо. örgen, то. örgön; мо. dörben, то. dörbön; мо. qotola, то. xotolo; мо. olan, то. olon; мо. dotura, то. dotoro гэх мэт.

Хос эгшиг. v + yi -ийн нийлбэр нь тод үсэгт хоёр үе бөгөөд зарим нутгийн аялгуунд хос эгшиг болсон байна. Үүнд:

Үгийн эхэн, дунд	ayi	oyi	uyi	eyi		üyi
Үгийн эцэст	ai	oi	ui	ei	öi	üi

Жишээ нь: мо. ayiladun, то. ayiladun; мо. qayiralaqui, то. xayiralaxui; мо. γayiqamsiγ, то. γayixamšiq; мо. nayiǰi, то. nayiǰi; мо. tuulai, то. toulai; мо. sanabai, то. sanabai; мо. oyir-a, то. oyiro; мо. oyitan, то. oyiton; мо. qoyitu, то. xoyitu; мо. toyin, то. toyin; мо. nom-tai, то. nomtoi; мо. čöγtai, то. coqtoi; мо. todurqai, то. todorxoi; мо. uyidqar, то. uyidxar; мо. abqui, то. abxui; мо. siγui, то. šuγui; мо. taγalaqui, то. tālaxui; мо. aqui, то. axui;

мо. siγui, то. šuγui; мо. taγalaqui, то. talaxui; мо. aqui, то. axui; мо. teyin, то. teyin; мо. ügei, то. ügei; мо. ögülebei, то. ögüülebei; мо. ilerkei, то. ilerkei; мо. törübei, то. töröböi; мо. üyiledkü, то. üyiledkü; мо. ǰüyil, то. züyil; мо. ideküi, то. ideküi; мо. sinǰilekü̈i, то. šinǰilekü̈i гэх мэт. Бас тод үсэгт iu, iü -гийн хос эгшиг тохиолдож байна. Жишээ нь: мо. ariγun, то. ariun; мо. serigün, то. seriün гэх мэт. Тод үсэгт хос эгшгийг тэмдэглэсэн нь уйгаржин монгол бичгээс тедий л их ялгавар байхгүй байна. Гэвч үгийн нэгдүгээр үеэс хойш oi, öi -ийн хос орсон нь уйгаржин монгол бичгээс ялгавартай болж ярианы хэлэнд ойртсон байна.

Урт эгшиг. Сүүлийн үед тод үсэгт урт эгшиг тэмдэглэсэн талаар монголч эрдэмтдийн сонирхлыг зүй ёсоор татсан хэд хэдэн шинэ санал гарсан[92] байна.

Доктор Г.Д.Санжеев "Монгол хэлнүүдийн харшуулсан хэл зүй" гэдэг зохиолдоо "Ойрдын зарим нутгийн аялгуунд буюу тэр ч байтугай нилээд олон аялгуунд нь XVII зууны дундуур урт эгшиг бүрэлдэн тогтох явц бүрмөсөн төгсөөгүй байсан"[93] гэжээ. Жишээ нь: мо. naγur, то. nour; мо. egüle, то. öüle гэх мэт.

Академич Ринчен, доктор Санжеевын дурдсан саналыг бүрэн зөвшөөрөөд "Хөвсгөлийн Дархадын аялгуунаа монгол бичгийн агу, эгу нь бусад монгол аялгууны адил уу, үү болоогүй оо, өө болсон байдаг байна. Үүний учрыг олж танихад, Түрэг үндэстэн асан дархад, монгол хэл аялгуутай болохдоо баруун монгол

Ойрдын тэр үеийн аялгуунд орсон учир, тухайн үед бусад монгол аялгуунаа агу-г уу болж, эгү-г үү болж байхад, Дархад түүнийг Ойрдын арван долоодугаар зууны бичгийн дурсгалд гэрч баримттай оо/оу/, өө дуудлагаар авсан учир, одоо хүртэл монгол бичгийн жагун /загун/ гэдгийг зоон, зуон, монгол бичгийн эгүлэ-бусад монгол аялгуунаа үүлэ /үүл/ гэдэг болсныг өөлэ гэж дууддаг байна"[94] гэжээ.

Академич Ш.Лувсанвандан, доктор Санжеевын саналыг мөн л зөвшөөрөөд тод үсгийн ou ,öü -г монгол хэлний урт эгшгийн хөгжилд нэгэн үе болгосон байна. Бас Ойрдод "удаан" гэдэг нэртэй " ᠶᠠ " тэмдгийг урт а буюу е мөн болохоос биш тухайн эгшгийн уртыг тэмдэглэсэн тэмдэг бус гэж нотлосон байна.[95] Жишээ нь: мо. sayad , то. sāad ; мо. deger-e , то. deēre ; мо. toγ-a , то. toā ; мо. tölüge , то. tölöē ; мо. qariγad , то. xariād гэх мэт.

Дурдсан эрдэмтдийн санал маш сонирхолтой боловч дахин шалгууштай баримт тод үсгийн дурсгалаас олдож байгааг тоймлон хэлье.

Эрдэмтдийн саналыг базаж үзэхэд монгол бичгийн хэлний aγu,egü нийлбэрийг тод үсэгт ou, öü -гээр тэмдэглэсэн нь дундад эртний монгол хэлний тэрхүү үзэгдэл ХҮП зууны тэргүүн хагас хүртэл Ойрд аялгуунд хадгалагдаж байсан гэдэг талаар санал нэгтэй байна хэмээн үзэж болох юм.

Гэтэл тод үсгийн дурсгалыг нарийвчлан үзэхэд монгол бичгийн aγu,egü -гийн ямар ч нийлбэр байхгүй газар мөнөөхөн ou, öü-г хэрэглэсэн байна. Жишээлэхэд: мо. oγun, то. oγoun ; мо. niγur , то. niγour ; мо. anguči ,то. angγouči; мо. aγulqu , то. aγoulxu ; мо. nuγud , то. noγoud; мо. ögülekü , то. ögöülekü; мо. terigüten , то. terigöüten; мо. nigülesküi , то. nigöülesküi гэх мэт.

Эрдэмтдийн санал дээр нэмж хэлэхэд тод үсгийн ou,öü нь зөвхөн aγu, egü -гийн нийлбэрээс үүсдэг бус бас iγu,igü -гийн нийлбэрээс буй болж байна. Жишээлэхэд мо. γasiγudan, то. γašoudan; мо. gesigün , то. gešöün ; мо. ičigüri , то. ičöüri; мо. γasiγun, то. γašoun ; мо. ǰigsigüri, то. ǰiqsöür гэх мэт. Үүнд aγu,egü,iγu, igü -гийн нийлбэрийн a,e, i нь дараахь үеийн эгшгийн нөлөөгөөр уруулшсан гэж үзэж болох байна. Гэтэл мо. ügürmeg , то. öürmeq; мо. düguregsen , то. döürüqsen; мо. küjügüü , то. küzöü гэх мэт үгийн ügü-гийн нийлбэрийн эхний үеийн ü нь дараахь үеийн ü -гийн нөлөөгөөр ö болж болох уу?

Дээр дурдсан зүйлийг дүгнэн хэлэхэд тод үсэгт байгаа ou öü нь дундад эртний монгол хэлний байдлыг тусгасан нь огтхон ч бус зөвхөн урт u , ü -г тэмдэглэсэн арга гэж үзвэл зохино.

Үүнээс үндэслэн урт u, ü -г яагаад хоёр тэмдгээр тэмдэглэсэн бэ ? гэдгийг анхаарахгүй байж болохгүй юм.

Тус хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт буй Зая бандидын зохиосон " Үзгийн найрлага"[96] гэдэг цагаан толгой улсын нийтийн номын санд буй " Олон номын үндсэн үзгийн ялгал"[97] гэдэг цагаан толгойн аль алинд төвд үсгийн буюу -г -гоор[98]

[illegible] буюу [illegible] -г [illegible] -гоор хаджээ. Бас " Тарни унших аргыг хураасан" гэдэг номд:

[illegible]

гэжээ. Тод үсэгт урт эгшгийг " ᠯᠠ " болон давхар эгшгээр [ᠣᠣ, ᠤᠤ] тэмдэглэж байгааг дээр иш татсан зүйлээс салангид үзэж болохгүй юм.

Үүний нөгөө талаар тод үсгийн дурсгалын зүйлд ᠣᠣ ou, ᠥᠥ -г uu,üü -гээр бичсэн зүйл цөөнгүй байна. жишээлэхэд: мо. [illegible] üjegülbei, то. [illegible] üzüülbei [найман мянган шүлэгтийн бар]; мо. [illegible] qaldaγulqu, то. [illegible] xalduulun [бурхны 67 төрлийн туужид]; мо. [illegible] samaγun, то. [illegible] [618 [27]-р тэмдэгт гар бичмэлд]; мо. [illegible] aγurlaqu, то. [illegible] uurlād [ханах төөнөхийг ихэд хураасан дэвтэр I] гэх мэт. Хэрэв aγu, egü -гийн нийлбэрийг ou,öü -гээр хэлж байсан юм бол тод үсгийн дээр үеийн бар, бичмэл сударт яагаад ᠣᠣ uu ᠥᠥ üü -гээр бичсэн бэ? гэдэг асуудал бидэнд сонирхолтой байна. Ер нь ХҮШ зууны үеийн тод үсгийн бичиг сударт ᠣᠣ ou, ᠥᠥ -г ᠣᠣ uu, ᠥᠥ -гээр бичдэг болсныг ярианы хэлнээс ангид үзэж болохгүй билээ.

Энэ талаар Зөвлөлт Халимагийн эрдэмтэн Д.А.Павловын бичсэн өгүүлэл сонин юм. "Зохиогч нь үл мэдэгдэх толь болон А.Соколовын толь бичигт [ХҮШ зууны

2-р хагас буюу 1769-1771 оны ou,öü -г бүх л нөхцөлд урт ū,ǖ -гээр тэмдэглэсэн байна"[99] гэжээ.

Бас А.Бобровников "Монгол халимаг хэлний зүйн бичигтээ" "...ийнхүү ū, ǖ -г ᠣᠣ хэмээн хоёр өөр тэмдгээр тэмдэглэх ямар ч шаардлагагүй байна. Хэрэв ингэж бичихэд хүрвэл зөвхөн бичгийн үзэмжинд зориулсан төдий болох юм"[100] гэж бичсэн байна.

Академич Ш.Лувсанвандан тод үсгийн урт эгшгийг тэмдэглэх " ᠯᠠ " зураасыг урт а, е гэж үзсэн нь сонин боловч бодит баримттай бас л зөрж байна. Хэрэв " ᠯᠠ " зураасыг урт а,е гэж үзэхэд хүрвэл мо. [illegible] boγoqu, то. [illegible] bōxui; мо. [illegible] toγorin, то. [illegible] tōrin; мо. [illegible] qoγola, то. [illegible] xōl; мо. [illegible] boγol, то. [illegible] bōl; мо. [illegible] toγosun, то. [illegible] tōsun; мо. [illegible] qoγosun, то. [illegible] xōsun; мо. [illegible] ǰoγoγ, то. [illegible] zōq; мо. [illegible] oγosur, то. [illegible] ōsur; мо. [illegible] sögökei, то. [illegible] sökü; мо. [illegible] sögöm, то. [illegible] söm; мо. [illegible] čögörüm, то. [illegible] cörröm[101] гэх мэт үгнээ байгаа уртын зураасыг юугаар тайлбарлах вэ ?. Үүнээс гадна тод үсгийн " Саран хөхөө"-ний сударт imi[102] [iēmi болно гэж үү], timi[103] [tiēmi болно гэж үү] байгааг юугаар тайлбарлах вэ ?

Эдгээр үгийн хоёрдугаар үед а буюу е байхгүй байгаа нь сонирхолтой байна.

Үүгээр үзвэл " ᠯᠠ " зураас нь ā, ē -г тэмдэглэсэн бус мөн л тухайн эгшгийн уртыг тэмдэглэсэн байна.

Гэвч тод үсгийн дурсналд то. [illegible] külīsü [мо. [illegible] küliyesü]; то. [illegible] tabīd [мо. [illegible] talbiγad]; то. [illegible] xanīγād, [мо. [illegible] qaniyaγad]; то. [illegible] bičīd [мо. [illegible] bičiged; то. [illegible] böljīd [мо. [illegible] bögeljiged]; то. [illegible] barīd,

/barivad /; то mörgüd, /мо. mörgüged /; то. tabūd, /мо. tabuvad/; то. döčid /мо. döčiged / гэх мэтийн сонин бичлэг тохиолдож байна. Ойрдын алив нэгэн аялгуунд энэ мэт хэлж байсан баримт бидэнд олдоогүй байна. Хэрэв ийм нөхцөлд академич Ш.Лувсанвандангийн дээр дурдсан баталгаа маш оновчтой мэт боловч тийм биш юм.

Тод үсгийн дүрэмд авиа зүйн зарчмыг гол болгоогүй үг зүйн зарчмыг чухалд үзсэн нь илэрхий байна. Жишээлэхэд küli, biči -, mörgü- гэсэн үндэс байхад түүн дээр дагавар залгахад külēsü bičēd, mörgōd гэж бичихэд үгийн үндэс алдагдах учир külīsü, bičīd, mörgūd гэж бичихээс өөр аргагүй байна. Тод үсэгт үг зүйн зарчмыг баримтлахгүй байсан сан бол bari-, barīd ; soli-, solīd; xari-, xarīd ; xori-, xorīd гэж бичихийн оронд barād, solād , xarād, xorād гэж бичихэд хүрэх учраас үгийн үндсийг хэвээр хадгалахаас өөр арга байсангүй. Энэ мэт үгэнд үгийн үндсийг хэвээр хадгалах уу, байх уу гэдэг асуудал саяхан болтол маргаантай байжээ.

1957 оны 3-р сард Үрэмч хотноо хуралдсан Шинэжааны монгол хэлний эрдэм шинжилгээний хурал дээр үсгийн дүрмийн тухай асуудал хэлэлцэж " i " эгшгээр төгссөн чанга үгийн үндсэнд дагавар залгахад үндсийг хэвээр үлдээж, /жишээ нь: soli- , solīd cabči-, cabčīd ; bari-, barīči гэх мэт/ хөндий үгэнд үгийн үндсийг эвдэж / жишээ нь: ergi-, ergēd ; tülki-, tülkēd; döči- , döčēd ; küli -, külēsün ; sedki-, sedkēd гэх мэт/ бичих нь зүйтэй

гэсэн санал гарч[104] байжээ.

Үг зүйн зарчмыг баримтлан зохиосон тод үсгийн дүрмийг одоо авиа зүйн зарчимд ойртуулахаар оролдоход энэ мэтийн бэрхшээл тохиолдож байгаа нь зүй ёсны асуудал юм.

Зөвлөлт Холбоот Улсын нэрт монголч Б.Я.Владимирцов тод үсгийн дүрмийн талаар сонирхолтой ажиглалт хийж, " Энэ бол ардын ярианы үг хэлнээс ялгавар бүхий олон хуучин үг, монгол үгтэй бөгөөд үсгийн нарийн дүрэм нь үг зүйн зарчимд үндэслэсэн зохиомол хэл байв"[105] гэжээ.

Эцэст нь дүгнэж хэлэхэд тод үсэгт урт эгшгийг хоёр үсгээр тэмдэглэх, бас " ᠶ " зураасаар тэмдэглэх ийм хоёр арга байсан байна.

<u>Дэвсгэр үсэг</u>. Тус хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт хэд хэдэн цагаан толгой буй. Эдгээр цагаан толгойн эцэст дэвсгэр үсэг хавсаргасан байна. Уйгаржин монгол бичигт n, ng, b, γ,(g), y, d,m, r,s,l,w эдгээр II дэвсгэр үсэг байдгийг бид сайн мэднэ. Үүнээс гадна давхар дэвсгэр[106] гэж буй.

Тод үсэгт давхар дэвсгэрийг үл оролцуулан бодвол 13 дэвсгэр байна. Энэ дэвсгэр нь n,ng,b,q,y,d, m,r,s,š,l,w,ᠶ[107] эдгээр юм. Үүнээс бидний дээр ярилцсан " ᠶ " /уртын тэмдэг/-ийг дэвсгэр үсэгт оруулсан нь сонирхолтой байна. Зая бандид тод үсэгт " ᠶ " -г төвдийн ᠠ -тай тохируулан бодоод дэвсгэр үсэгт оруулсан байж болох юм[108].

Тод үсгийн хэрэглэгдэхүүн бол монгол хэлний ялангуяа Дөрвөн ойрд, Халх долоон хошууны монголчуудын аялгуунд ХҮП зууны дунд үеэр ямар өөрчлөлт ороод байсныг магадлах нэгэн үе болж өгөх юм. Ийм учраас тод үсэг гарахаас 400 шахам жилийн өмнө зо-

хиогдсон дөрвөлжин үсгийн хэрэглэгдэхүүнийг тод үсгийнхтэй харьцуулан үзэхэд энэ завсар авиан зүйн талаар ямар өөрчлөлт ороод байсан бэ гэдгийг бид авч үзье.

Нэгдүгээрт, тэргүүн үед орсон i,e эгшиг дараа үеийн уруулшсан эгшигтэй ижилшсан байв.

Хоёрдугаарт, үгийн тэргүүн үед орсон o,ö эгшгийн нөлөөгөөр дараахь үеийн эгшгүүд нь зохицон уруулшсан үзэгдэл ялангуяа Халх долоон хошууны аялгуунаа бүрнээ буй болсон байжээ.

Гуравдугаарт, хоёр эгшгийн хооронд орсон γ,g, b сугарч урт эгшиг бүрэлдэн тогтох явц төгс гүйцсэн байжээ.

Дөрөвдүгээрт, дундад эртний монгол хэлний ǰ -гээс dž,dz(z) ,č -гээс tš,ts тасран салсан байжээ.

Тавдугаарт, i эгшгийн өмнө орсон s нэгэнт š болон хувирсан байжээ.

4.Тод үсгийн үг зүйн онцлог

Тод үсгийн дурсгалуудад үг зүйн талаар уйгаржин монголоос юугаараа өөр,юугаараа тодорхой болсон бэ гэдгийг авч үзье.

Тоо заах дагавар. Монгол бичгийн хэлэнд олон тоо заах нилээд дагавар байдаг билээ. Гэтэл тод үсгийн эртхэн үеийн дурсгалуудад уг дагавраас тун цөөхнийг хэрэглэсэн байна.

Монгол бичгийн хэлэнд долоон эгшиг,n- гийгүүлэгчээр төгссөн үгэнд-nuγud,-nügüd -ийг залгана. Гэхдээ nuγud-ийг эр эгшигт үгнээ,nügüd -ийг эм эгшигт үгнээ залгана. Гэтэл тод үсэгт үгийн төгсгөл

эгшиг, гийгүүлэгч, эр, эм үгийг үл харгалзан ганц-хан noγoud дагаврыг хэрэглэсэн байна. Жишээ нь: nom noγoud , toqtōl noγoud , tarālang noγoud, coq noγoud , sang noγoud, burxan noγoud , γalab noγoud, moγoi noγoud, čimeq noqoud, ed noγoud, tib noγoud,

maxamud noγoud, tüyidker noγoud, erdem noγoud, üyile noγoud, dusul noγoud, dēdü noγoud, eme noγoud гэх мэт .

Тод үсгийн дурсгалуудад nar(-ner), - d дагавар цөөхөн үгийн дараа, ховорхон хэрэглэсэн байна. Уйгаржин монгол бичигт эр эм эгшигт үгийн алинд ч болов -nar дагавар залгаж байхад тод үсэгт эр эгшигт үгнээ -nar, эм эгшигт үгнээ -ner дагавар залгаж байна. Жишээ нь: nayijinar , tenggeriner , yertünčüner , tögüsüqsed , nöküd гэх мэт.

Дээр дурдсанаас бусад дагаврыг эхэн үеийн дурсгал бичгүүдэд бараг хэрэглэсэнгүй байна.

Тийн ялгалын дагавар. Тод үсгийн бичиг зохиолоос тийн ялгалын дагаврыг авч үзвэл монгол бичгийн хэлэнд байдаг дагаврыг л ярианы хэлэнд ойртуулж тодорхой болгосон байна.

Уйгаржин монгол бичигт харьяалахын тийн ялгалын дагавар -yin, -un(-ün) -u-(ü) байдгийг бид сайн мэднэ. Гэтэл уйгаржин монгол бичгийн -yin дагаврыг тод үсэгт -yin, (gi)yin хоёр өөр дагавраар тэмдэглэж байна. Богино эгшгээр төгссөн

үгийн дараа, хос эгшгээр төгссөн үгийн дараа yin урт эгшгээр төгссөн үгийн дараа (-gi) yin дагуулж оайна. Жишээ нь: мо. sar-a-yin то. sarayin , мо. metü-yin , то. metüyin ; мо. ölǰei-yin ,то. ölzöyin; мо. dalai-yin , то. dalayin ;мо. degüü-yin , то. döügiyin ; мо. örlüge-yin, то. örlögiyin ; мо. mayu-yin , то. mougiyin гэх мэт.

Монгол бичгийн хэлний -un(ün) дагаврыг тод үсэгт -(i) yin ,-(gi)yin дагавраар u(ü)-г- i дагавраар тэмдэглэсэн байна. n,ng гийгүүлэгчээс бусад гийгүүлэгчээр төгссөн үгнээ (i)yin дагавар , n гийгүүлэгчээр төгссөн үгнээ-i дагавар, ng гийгүүлэгчээр төгссөн үгнээ (-gi)yin дагавар залгаж байна. Жишээ нь: мо. čerig-ün , то. cerigivin ; мо. busud-un , то. busudivin ; мо. namur-un , то. namuriyin ; мо. erdem-ün , то. erdemiyin ; мо. nökör-ün , то. noküriyin ; мо. amitan-u , то. amitani ; мо. kümün-ü , то. kümüni ; мо. qayan-u , то. xani ; мо. sibayun - u , то. šobuuni ; мо. bayasqulang-un , то. bayasxulanggiyin ; мо. ǰobalang-un , то. zobulanggiyin ; мо. yasalang-un , то. yasalanggiyin гэх мэт.

Уйгаржин монгол бичигт өгөх оршихын тийн ялгалын дагаврыг -tur(-tür), -dur(-dür), -tu (-tü) -du(-dü), -ta(-te), da(-de) -a (-e) дагавар оайна. Эдгээр дагаврыг удаас тод үсэгт зөвхөн -tu, -tü -du -dü дагаврыг авч

хэрэглэжээ. -tu, -tü дагаврыг хатуу дэвсгэрээр төгссөн эр, эм эгшигт үгэнд -du, -dü дагаврыг зөөлөн дэвсгэр болон эгшгээр төгссөн эр эм эгшигт үгнээ залгана. Жишээ нь: мо. zambutib-tü, то. zambutib-tü , мо. qamuy-tu , то. xamuq-tu ; мо. niyur-tu ,то. niyour-tu; мо. dooradus-tu , то. dorodus-tu; мо. balyad-tu, то. balyad-tu; мо. bükün-dü, то. bükün - dü; мо. nom-du, то. nom-du; мо. köl-dü , то. köl-dü , мо. amuyu-lang-du , то. amuyulang-du; мо. ary-a-du, то. arya-du; мо. ami-du, то. ami-du гэх мэт.

Тод үсгийн дээрхэн үеийн бичмэл номд -a, -e дагавар огт тохиолдохгүй байна. Зая бандидын орчуулсан " Маань гамбум" гэдэг зохиолын монгол эхэд čanar-a [3а], oron-a [3в], ti(i)b-e [3в], ǰüg-e [5а], kümün-e [7в], aduyusun-a [7в] гэж байгааг тод үсгийн мөн сударт činar-tu [2а] oron-du [2в], tib-tü [2в], züg-tü [5а], kümün-dü [6а], aduusun-du [6а] гэж бичсэн байна.

Уйгаржин монгол бичигт заахын тийн ялгалын дагаврыг -yi, -i -гээр тэмдэглэдэг билээ. Гэтэл тод бичигт эгшгээр төгссөн үгэнд -yi,гийгүүлэгчээр төгссөн үгэнд -i , урт хос эгшиг , ng гийгүүлэгчээр төгссөн үгэнд -gi дагавар залгаж байна. Жишээ нь: мо. degedü-yi , то. dēdü-yi ; мо erdeni-yi , то. erdeni- yi ; мо. udq-a-yi , то. udxa-yi ; мо. ünen-i , то. üneni ; мо. nuyud-i

то. noγoudi ; мо. mungqaγ-i , то. mungxagi ; мо. ǰalaγu-yi , то. zulou-gi ; мо. ügei-yi , то. ügei-yi , мо. medeküi-vi , то. medeküyigi ; мо. badaraqu-yi , то. badaraxui-gi ; мо. bui-yi , то. bui-gi; мо. gelüng-i , то. gelunggi ; мо. ǰobalang-i , то. zobulonggi; мо. tariyalang-i , то. tarālanggi гэх мэт.

Уйгаржин монгол бичигт гарахын тийн ялгалын дагаврыг -ača (-eče) -ээр тэмдэглэж байна. Үүнийг тод үсэгт нэгэн мөр болгон журамлаж эр эгшигт γ , эм эгшигт γг алин болович ялгаваргүй -ēce дагавар дагуулах болсон байна. Жишээ нь: мо. γool-ača то. γol—ēce; мо. nada-ača , то. nada-ēce ; мо. yaγun-ača , то. youn-ēce ; мо. qola-ača, то. xolo-ēce; мо. ebedčin-eče, то. ebečin-ēce ; мо. ǰüg-eče , то. züg-ēce ; мо. eǰen-eče , то. ezen-ēce гэх мэт.

Уйгаржин монгол бичигт үйлдэхийн тийн ялгалын дагаврыг -bar (-ber) , -iyar (-iyer) -аар тэмдэглэж байгаа бөгөөд тод үсэгт -bēr -yēr дагавраар тэмдэглэж байна. Эгшиг үсгээр төгссөн үгээ эр эгшиг, эм эгшигт үгийг үл харгалзан зөвхөн bēr дагавраар, гийгүүлэгчээр төгссөн үгнээ мөн эр эм эгшигт үгийг үл харгалзан -yēr дагавраар тэмдэглэж байна.Жишээлбэл: мо. dur-a-bar то. dura-bēr; мо. elči-ber, то. elči-bēr ; мо. auγ-a-ber , то. auγa-bēr; мо. küčü-ber , то. küčü-bēr ; мо. modun-iyar , то. modun-yēr ; мо. γar-iyar, то. γar-yēr ; мо. coγ-iyar, то. coq-yēr

гэх мэт. Мөн дагаврыг зарим сударт ярианы хэлэнд бүр ойртуулан бичсэн зүйл үзэгдэж байна. Жишээ нь: Бурхны 67 төрлийн туужинд durār, bügüdēr, erkēr, yosōr гэж бичжээ.

Уйгаржин монгол бичигт хамтрахын тийн ялгалын дагаврыг -tai (-tei) -гээр тэмдэглэж байхад тод үсэгт -tai -tei -toi, -töi дөрвөн хэлбэрээр тэмдэглэсэн байна. Эдгээрээс эр эгшигт үгнээ -tai, -toi, эм эгшигт үгнээ -tei -töi дагавар залгаж байна. Жишээлбэл: мо. γayiqamsiγ-tai, то. γayixamsiq-tai; мо. qoor-a-tai, то. xortoi; мо. soyuγ-a-tai, то. soyō-toi; мо. sedkil-tei, то. sedkil-tei; мо. üǰesgüleng-tei, то. üzeküleng-tei; мо. töröl-tai,то. töröltöi; мо. öngge-tei, то. ünggütöi гэх мэт.

Үүнээс гадна уйгаржин монгол бичгийн -luγ-a, -lüge дагаврыг тод үсэгт -luγā, -lügē -гээр тэмдэглэсэн байна. Бас ярианы хэлэнд ойртуулан -lā дагаврыг тэмдэглэсэн зүйл хуучин бичиг сударт хаяа тохиолдож байна. Жишээлбэл: мо. amitan-luγ-a, то. amitan-luγā; мо. kümün-lüge, то. kümün-lügē; мо. nada -luγ-a;то. nadalā / Бурхны 67 төрлийн туужинд / гэх мэт.

Тод үсгийн дурсгалуудад тохиолдож буй тийн ялгалын дагаврыг монгол бичгийн хэлтэй харьцуулан хүснэгтээр гаргавал :

	мо.	то.
хар-	-yin	-yin



Үйл үгийн хэлбэр. Тод үсгийн бичиг зохиолоос үзэхэд үйл үгийн дагавар нөхцлийг тэмдэглэсэн байдлыг үзвэл идэвхгүй болж хэрэглэгдэхээ байсан дагаврыг хасч, идэвхтэй хэрэглэгдэж байсан зарим дагаврыг тодорхой болгосноос гадна зарим дагаврыг зөвхөн журамлаж үлдээсэн байна.

Тод үсгийн дээрхэн үеийн дурсгал бичгүүдэд үйл үгийн захирах хүсэх хэлбэрийн дагавар -qtun, -qtün, -ya, -ye, -tuγai, -tügei, -su, -sü дагавар тохиолдож байна. Жишээлбэл: мо. yabuγ-tun, то. yabuqtun; мо. üjegtün, то. üzeqtün; мо. üyiledüy-e, то. üyiledüye; мо. abuy-a, то. abuya; мо. odsu, то. odsu; мо. ögsü, то. öqsü ; мо. toγtatuγai, то toqtotuγai; мо. iretügei, то. iretügei гэх мэт.

Сонгодог бичгийн хэлэнд байдаг -suγai, sügei гэх мэт зарим дагаврыг тод үсгийн дурсгалын зүйлд огт тохиолдохгүй байна. Маань гамбүмийн тод эхийг монгол эхтэй тулгаж үзэхэд -suγai, sügei дагавар бүхий бүх газарт -su, -sü дагавар туйлбартай хэрэглэсэн байна. Жишээлэхэд монгол Маань гамбүмийн 6а талд üyiledsügei, тод Маань гамбүмийн 5а талд üyiledsü, монгол Маань гамбүмийн IIа талд absuγai, тод Маань гамбүмийн 9в талд absu гэх мэтчилэнгээр бичсэн байна.

Тод үсгийн дурсгалуудад цагийг заах хэлбэрийн -bai, -bei, -boi, -böl, -mui, -müi дагавар тохиолдож байна. Жишээлбэл: мо. qarbubai, то. xarbubai ; мо. bütübei , то bütübei, мо. jokiyabai ; то. zokōboi ; мо. ködelbei , то. ködölböi ; мо. tuγur-

bimüi , то. tuurbimui; мо. sedkimüi , то. sedkimüi гэх мэт. Тод үсгийн дурсгалуудад ǰuqui,-ǰügüi дагавар огт тохиолдохгүй байна. Маань гамбумийн тод эхийг монгол эхтэй тулгаж үзэхэд монгол эхийн -ǰuγui ,-ǰügüi дагаврыг -bai , -bei, -boi, -böi дагавраар сольсон байна. Жишээлэхэд Маань гамбумийн 6а талд talbiǰuγui, тод үсгийн Маань гамбумийн 5а талд talbibai, монгол эхийн IIв талд beledǰügüi, тод эхийн 9а талд beledbei, монгол эхийн IOв талд oruǰuγui, тод эхийн 9а талд oroboi, монгол эхийн I2а талд törüǰüγüi, тод эхийн IOа талд töröböi гэх зэргээр тус тус тохиолдож байна.

Тод үсгийн дурсгалуудад -mu (-mü) дагавар бараг тохиолдохгүй байна. Жишээлбэл монгол үсгийн Маань гамбумийн 5а талд ese tesüγsen amu гэхийг тод эхийн 4а талд ese tesüqsen bui гэсэн байна.

Тод үсгийн зарим дурсгалын зүйлд -lai, -lei, -nai,-nei дагавар ховор боловч тохиолдож байна. Жишээлбэл: sonosolai, хаγacoulunai /Бурхны 67 төрлийн туужид/ гэх мэт.

Тод үсгийн дурсгал бичгүүдэд нөхцөл үйл үгийн -ǰi, -či, [+]-[ā]d, [ϑ]-[ē]d, [N]-[ī]d, [ᠬ]-[ō]d, [ᠬ]-[ö]d, -n, -baču, -bečü ,

-boču bočü дагавар лбэг тохиолдож байна. Жишээ нь: мо. üǰeǰü, то üzeǰi; мо. debisčü, то. debisči; мо. saγuγad , то. souγād; мо. ireged , то. irēd; мо. bičiged, то. bicīd; мо. toγtaγad,

то. toqtōd; мо. nögčiged, то. nöqčöd; мо. qubilun, то. xubilun;мо. tegüsün, то. tögüsün; мо qaγačabaču, то. xaγacabaču; мо. kemebečü , то. kemebečü; мо. bolbaču, то. bolbocu ; мо. ögbečü, то. öqböčü гэх мэт.

Сонгодог бичгийн хэлний basu ,-besü дагавар тод үсгийн ном зохиолд ховор тохиолдож байна. Монгол тод үсгийн :Маань гамбумийг" харшуулан үзэхэд сонгодог бичгийн хэлний -basu,-besü дагавар бүхий газарт -xulā, -külē дагавар бичсэн байна. Жишээ нь: Монгол эхийн IIа талд oldabasu, тод үсгийн эхийн 9в талд oldoxulā, монгол эхийн 6а талд edlebesü, тод эхийн 5в талд edlekülē гэх мэт.

Сонгодог бичгийн хэлний -tal-a,-tel-e дагаврыг тод үсэгт -tala, -tele -гээр тэмдэглэсэн боловч элбэг тохиолдохгүй байна.Жишээ нь: мо. yabutal-a, то. yabutala;мо. iretel-e, то. iretele гэх мэт.

Сонгодог бичгийн хэлний -quγ-a, -küγ-e дагавар тод үсгийн дурсгалуудад ховор тохиолдож байна. Жишээ нь: Монгол Маань гамбумийн IOв талд nomuqadqaqay-a, тод эхийн 9а талд nomoγodxoxō, монгол эхийн I3а талд medeküγ-e , тод эхийн IIа талд medekü гэх зэргээр дээр дурдсан -quγ-a, küγ-e дагавар хэрэглэхээс аль болохоор зайлсхийсэн байна.

Сонгодог бичгийн хэлний -r-a , r-e дагавар тод үсгийн дурсгалын зүйлд огт тохиолдохгүй байна. Харин -r-a , -r-e дагаврыг -xā , -kē

хō kō дагавраар төлөөлүүлсэн явдал үзэгдэж байна. Жишээ нь: Монгол Маань гамбумийн 3а талд čečeg abur-a тод эхийн 2в талд cecec abxā монгол эхийн 9а талд uyidqar γarγar-a, тод эхийн 7в талд uyidxar γarxā гэх мэт.

Сонгодог бичгийн хэлний -rün ,-rün дагавар тод үсгийн дурсгалын зүйлд огт тохиолдохгүй байна. Жишээлэхэд монгол үсгийн Маань гамбумийн I2в талд üyiledür-ün гэхийг тод үсгийн Маань гамбумийн I0в талд üyiledbei гэж бичсэн байна.

Тод үсгийн дурсгал бичгүүдэд үйлт нэрийн -qsan , -qsen , -qson , -qsön, -qči , -xu , -xui , -kü , -küi дагавар элбэг тохиолдож байна. Жишээ нь: мо. bayiγuluγsan , то. bayiγouluqsan; мо. medegsen , то. medeqsen; мо. oruγsan , то. oroqson ; мо. nögčigsen , то. nöqčiqsön; мо. tedgügči, то. tedküqči ; мо. yabuγči, то. yabuqči; мо. toγtaγaqu, то. toqtōxu ; мо sedkikü, то. sedkikü; мо. asaraqui, то. asaraxui ; мо. teskü, то. teskü гэх мэт.

Тод үсгийн дурсгалуудад тохиолдож байгаа үйл үгийн дагаврыг монгол бичгийн хэлтэй харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

а. Үйл үгийн захирах хүсэх хэлбэр

	-γtun	-gtün	-γarai	-gerei	-γači	-geči	-y-a, -y-e	-suγai
	-qtun	-qtün	.	.	.	.	-ya, ye	-su

	-süγei	-γasai	-gesei	-γ, -g	-tuγai	-tügei	-γuǰai	-güǰei
	-sü	.	.	.	-tuγai	-tügei	.	.

б. Үйл үгийн цагийг заах хэлбэр

	-bai -bei -ba -be -bai -bei -boi -böi	-ǰuγui	-ǰügüi	-luγ-a -luγā -lai	-lüge -lügē -lei
	-n-a -n-e -nai -nei	-mui -müi -mui -müi	-mu -mü .	-yu -yü -yu -yü	

в. Нөхцөл үйл үгийн хэлбэр

	-ǰu -ǰü -ču -čü -ǰi -či	-γad -ged -i+γad -i+ged -ād -ōd -ēd -ōd -īd	-n -n	-bal -bel	



г. Үйлт нэрийн хэлбэр.



Тод үсгийн эртхэн үеийн дурсгалыг хожим үеийн зохиол, орчуулгатай харьцуулан үзэхэд үг зүйн талаар ялгавартай зүйл нилээд байгаа юм. Жишээлэхэд тод үсгийн эрт үеийн дурсгалд -muud, -müüd[III] дагавар нэг ч удаа тохиолдохгүй байхад хожим үеийн ном зохиолд маш элбэг тохиолдож байна.

Тод үсгийн эрт үеийн дурсгалд өгүүлэхүүний бие заах дагавар[II2] огт тохиолдохгүй байхад хожим үеийн бичиг зохиолд элбэг тохиолдож байна.

5. Тод үсгийн үгсийн сангийн

онцлог

Тод үсгийн дээр үеийн дурсгалын байдлыг үзэхэд Ойрдын нутгийн аялгууны үгс туйлын ховор[II3] тохиолдож байна. Тод үсгийн хожим үеийн зохиол орчуулгыг үзэхэд нутгийн аялгууны үгс өдий тэдий байгаа нь үгсийн сангийн талаар дээр үеийн дурсгалаас эрс ялгавартай бөгөөд Ойрдын аялгууг тусгасан нь илт мэдэгдэж байна.

Уйгаржин монгол бичигт үгийн эхэнд амьгүй бичиж заншсан цөөн үг байдгийг бид мэднэ. Тод үсгийн дурсгалуудад тэдгээр бичлэгийг өөрчлөн бичих болсон байна. Жишээлэхэд : мо. včir, то. očir; мо. tngri , то. tenggeri; мо. gsan, то. aqšin , мо. gkir, то. kir гэх мэт.

Бас дээр үеийн ярианы хэлэнд идэвхгүй болсон зарим үгийг ойлгомжтой үгээр сольж хэрэглэсэн байдал үзэгдэж байна. Жишээ нь: qomq-a гэдэг үгийг тод үсгийн дурсгалуудад ямагт bumba гэж бичсэн байна. Бас vivangirid, bosuγ гэдэг үгийг eši гэжээ. Монгол бичгийн хэлний ügegüy-e гэдгийг ügeyigi, ügei, aǰiraγsan гэдгийг zalaraγsan гэж бичсэн бай-

на.

Ер нь тод үсгийн алив нэгэн бичиг баримт ном зохиолыг уншаад тод үсгийн дурсгалын эрт үед холбогдох уу, эсвэл хожим үед холбогдох уу гэдгийг хялбархан мэдэж болно. Жишээ нь: "Хөх хуцын дом" гэдэг анагаах ухааны холбогдолтой судар нилээд эрт үед холбогдох нь мэдэгдэж байна. Энэ сударт

" [illegible] " (Xatou yara-bērzaxatanan ekelen ese tesküle ünegeni bāsu kökö sara-du abuqsani mün ünegeni ökü xoliǰi türkeküle edegekü) гэжээ. Энэ сударт монголын эртний сарын нэр "Хөхөө сар" гэж байгаа учраас нилээд эрт зохиогдсон ном байна гэж бидэнд мэдэгдэж байгаа болович бичсэн байдлаар үзвэл ойрдын нутгийн хүн ойрдуудад зориулан бичсэн гэдэг нь уншмагц тодорхой байна.

Энэ сударт " [illegible] "

(Nüür dēre ulān mengge sebege unaxuna kökö xucayin büküli cusu xoyor ayiγa arakilā xoliǰi bucalγād abči bayiǰi söi büri ürgülǰi türkeküne lab arilxu bui).

" [illegible] "

(Гаqca ebertü xoyini maxan xoron bui cērle)

Дээр дурдсан жишээнд [illegible] ayaγ-a гэхийг [illegible] ayiγa / Рамстедтийн халимаг герман толь бичиг 20-р талд āγɵ, neg āγɒ tsā ūxɒ/, [illegible] ariki-luγ-a [illegible] arakilā, [illegible] söni гэхийг [illegible] söi /Рамстедтийн халимаг герман толь бичигт 335-р талд sȫ, sȫ dülŋ jobbū / [illegible] qonin-u гэхийг [illegible] /Рамстедтийн халимаг герман толь бичиг 194-р талд хȫ,хȫn, хönē nōsŋ / гэх зэргээр зөвхөн ойрдын аялгуунд

байдаг үгээр бичсэн байна.

Энэ мэтээр зөвхөн ойрдын аялгуунд тохируулан бичсэн ном зохиол нь нийт монголд зориулан зохиосон ном судраас ихэд ялгавартай байгаа юм.

6. Тод үсгийн хувь заяа

Монголчуудын хэрэглэхээр оролдож байсан үсгүүдийн дотроос хамгийн удаан хэрэглэсэн / одоо ч зарим газар хэрэглэсээр байгаа / хамгийн их газар дэлгэрсэн үсэг гэвэл тод үсэг болох юм.

Тод үсгийг Ижил мөрний Халимаг, Баруун монголын Дөрвөд, Баяд, Мянгад, Захчин, Өөлд, Урианхай,Хошууд, Торгууд; Шинэжаан мужийн Иль Тарвагатай, Ховог Сайр, Бор тал, Баянгол зэрэг газарт нутаглан сууж буй Хошууд, Торгууд, Өөлд, Цахар, Алшаа, Эзэнэ голын газраа нутаглаж буй Торгуудууд хэрэглэж байсныг үзэхэд тод үсгийн дэлгэрсэн газар нутаг тийм ч бага газар биш билээ.

Үүнээс гадна Чуе голын орчмоор нутаглан суугч түрэг хэлтэн Тедингидууд тод үсгийг хэрэглэдэг байсан тухай академич Б.Я.Владимирцов бичжээ[117]. Үүний баталгаа болох нэгэн бичгийг Киргизийн шинжлэх ухааны академиас 1963 онд нийтлүүлжээ. Энэ бичигт Зарнак гэгч хүн, их Цагаан хааны амар мэндийг айлтгаж элч заран алба хүргүүлсэн тухай[118] дурджээ. /Тод үсгийн дэлгэрцийн зургийг хавсаргав/.

Тод үсэг зохиогдсон цагаас эхлэн Халимаг, Ойрд, нутагт шашин төрийн болон амины хэрэгт дэлгэр хэрэглэгдсээр байв.[119]

Одоо Зая бандидын орчуулсан 60 гаруй орчуулга- Эрдэнэ баатар хун тайжийн хүү Сэнгэ, түүний хатан Цэвээнжалмуу нарын дурдаж орчуулуулсан "Ламрим"-ын

судар[120], 1691 онд бичсэн Ачинхашгаас Цагаан хаанд бичсэн захидал, Галдан бошигт ханы элч Тобол хотоос орон нутгийн байгууллагад бичсэн захидал , Галдан бошигтоос 1691 онд Цагаан хаанаас тусламж гуйсан бичиг[121], бас 1724 онд Даржаа хэмээх элчээр Цагаан хаанд илгээсэн бичиг[122] , 1740-өөд оны үеэр Галданцэрэн хааны зарлигаар барлуулсан хэд хэдэн судар[123] 1708, 1719 онд Халимагийн Аюк ханы бичсэн захидал, Аюк ханы хүү Шагдаржавын бичсэн захидал[124], Шагдаржавын хүү Дондогдашийн үед Халимагт барлуулсан "Алтан гэрэл" хэмээх судар[125], орос хэлнээс орчуулж 1811 онд Петербург хотноо хэвлүүлсэн "Ахархан сургаал" нэртэй хүүхдийн өвчин анагаах бичиг[126], 1827 онд Петербург хотноо хэвлэн гаргасан цэцэг өвчний тарилга хийх заавар, хожим Халимагуудаас нийтлүүлж байсан сэтгүүл, 1940-өөд оны үед Шинэжаанд гаргаж байсан сэтгүүл[127], одоо Шинэжаанд хэвлэн гаргаж буй сонин зэрэг он цаг нь тодорхой бичиг баримт бидэнд байгаа болохоор тод үсгийн үсэг зүй, дүрэм , үгсийн санд ямар өөрчлөлт гарсныг мэдэж болох юм.

Он цаг нь тодорхой ийм бичиг баримт, ном судраас үзэхэд Зая бандидын зохиосон тод үсгийн дүрэм хэдий үе хүртэл хүчин төгөлдөр хэвээр байсан бэ гэдгийг мэдэж болохоор байна.

Ийм боломжийг үндэслэн тод үсгийн дурсгалыг хоёр үед хуваж болно. Үүнд: Нэгдүгээр үе нь 1648 оноос ХҮШ зууны 2-р хагас хүртэл, хоёрдугаар үе нь ХҮШ зууны 2-р хагасаас Халимагт 1924 он хүртэл, Шинэжаанд одоо хүртэл гэж тус тус үелж болно.

1648 оноос ХҮШ зууны 2-р хагас хүртэл буюу нэгдүгээр үед Зая бандидын зохиосон тод үсгийн дүрэм хэвээр байсан бөгөөд тэр үед холбогдох тод үсгийн дурсгалд Ойрдын аялгууны онцлог гэж дурдах зүйл

байхгүй юм.

ҮХШ зууны хоёрдугаар хагасаас 1924 он хүртэл Халимагт тод үсгийг хэрэглэсэн боловч энэ завсар нь үсэг зүй,авиа зүй, үг зүй, үгсийн сангийн талаар Халимагийн аялгууг бүрэн тусгасан халимагийн тод үсэг болжээ.

ХҮШ зууны хоёрдугаар хагасаас одоо хүртэл Шинэжаан мужийн монголчуудын хэрэглэж байгаа тод үсэг нь үсэг зүй, авиа зүй, үг зүй, үгсийн сангийн талаар жинхэнэ Шинэжааны Ойрдын аялгууг тусгасан тэдний тод үсэг болжээ.

Баруун монголд нутаглан суугч Ойрдууд тод үсгийг сайхан болтол хувийн хэрэгцээнд өөр зуураа хэрэглэсээр байлаа.

Зая бандидын зохиосон тод үсэгт tš -г ts -гээс, dž -г dz -гээс ялгаварласан үсэг байгаагүй бөгөөд зөвхөн i эгшиг болон i -гээс бусад эгшгийн өмнө орсноор ялгаж байсан тухай дээр дурдсан билээ.

Петербургт 1811 онд хэвлэгдсэн "Ахархан сургаал" гэдэг номын дотор tš -г -гээр /Зая бандидын зохиосон галиг үсгийн phya -гаар/ ts -г -гээр, dž -г -гээр /Зая бандидын зохиосон галигийн bya -гаар/, dz -г -гаар ялгаж тэмдэглэх оролдлого нэгэнт гарсан байжээ. Жишээ нь: phyangva / čangva /65-р талд/, arbavin usu-du phyanaosan čanaqsan /83-р талд/ kembyen kemčen /96-р талд/ гэх мэт.

<u>Халимагийн тод үсэг</u>. Үүнээс хойш Халимагт Зая бандидын зохиосон цагаан толгойн үсгийг дахин тодорхой болгож[128] өөрийн аялгуунаа тохируулсан байна. Энэ цагаан толгой нь:

Эгшиг

эхэнд	богино эгшиг								урт эгшиг							
дунд																
адагт																
галиг		a	e	i	o	u	ö	ü		a	e	i	o	u	ö	ü

Зая бандидын зохиосон тод үсгийн эгшигт хожим оруулсан өөрчлөлт бол зөвхөн урт ou, öü-г тэр үеийн аялгуунд тохируулан uu, üü болгон өөрчилснөөс илүү зүйл байхгүй байна.

Гийгүүлэгч

эхэнд								
дунд								
адагт								
галиг	n	ng	x	k	γ	q	g	k
эхэнд								
дунд								
адагт								
галиг	d	t	b	m	z	ǰ	c	č
эхэнд								
дунд								

адагт								
галиг	y	r	l	w	s	š	p f	pb

Зая бандидын зохиосон тод үсгийн гийгүүлэгчид хожим оруулсан өөрчлөлт бол ǰ-г -гаар / Зая бандидын зохиосон галиг үсгийн -bya /, č-г -гаар /Зая бандидын зохиосон галиг үсгийн -cha, p-ааг /Зая бандидын зохиосон галиг үсгийн pha / тэмдэглэжээ.

Энэ өөрчлөлт нь нэг талаар z / dž -гаас dž -г[129] ялгаж -гаар, ts / tš -гаас tš -г ялгаж -гаар тэмдэглэсэн байна. Нөгөө талаар соёлын холбоотой орос хэлнээс зээлдэн авсан үгийг тэмдэглэхийн тулд /б/ /в/ /п/ авиаг ялгаварлан тэмдэглэх шаардлагатай болсон байна.

Энэ үеэс эхлэн үг зүйн талаар Зая бандидын зохиосон дүрэм чухамдаа хэрэглэгдэхээ байж янз бүрээр бичих болжээ.

Үгсийн сангийн талаар ч орос үг, нутгийн яриаины үг орсон байна. Жишээ нь: дээр дурдсан "Ахархан сургаал" гэдэг номд /52-р талд/ zölon piyiba /зөөлөн пиво/, /96-р талд / stakan istakan /стакан/, /98-р талд / kürüški /кружка/, /129-р талд /cön častu /цөөн част/, /цөөн цагт/ гэх мэт. Цааш нь мөн номд бичсэн нь: /97-р талд /

"Nige stakān dabastai xayariyin šüüsündü xoyar uxur bal zuurči nige-misan örüün ölön elken dēn uuxu"

Үүнд нэг стакан /орос үг/ давстай хаярын /?/ шүүсэнд хоёр ухур /халбага/ бал зуурч нэгмөсөн өрүүн /өглөө/ өлөн элгэндээн уух гэсэн өгүүлбэр байна.

Мөн энэ үед холбогдох Торгууд ноён Баатар увшийн бичигт



"Dunasaki woyiska ataman-aska polkodu xaluun cusayin xayiral ügei yobaǰi dēdü yeke xani törö šaǰin-du čidalāran zütükükü bolnai bi " гэсэн байна. Үүнд Донского войска атманский полк гэх мэтийн орос үг орсон байна.

Бас Халимагийн "Марс хар" гэдэг үлгэрт

"Nükün aman dēre γarād Mars xara tere xoyoriyigi duuduǰi bayinai. Bābāγai köbüün xoyor xariu kürēd irnē." ne mendü mendü" kigēd "či xaγāsu yabulai kenē bābāγai či. kenē köbüün či" genei. Bābāγai kelenei " uridiyin xubēr čimalai xarγabā. ...Čimalai xarγād čimayigi nükünēsü γarγād abuba bi.Odō či tere xoyor zaluu bābāγai xoyorāsu öšögiyini abudaq arγa bayidaq" genei . " Yā bi mordād abuxu bi" Gindü caγān düü Erdeni xongγor mörnē deldü örüün čiqtü boro boqšidā bolǰi untunai"[131]

Энэ хэдэн өгүүлбэрээс үзэхэд нутгийн чанартай үгс нилээд тохиолдож байна. Жишээ нь: bābāγai[132] Энэ үг Халимагаас өөр газар тохиолдохгүй байна. Бас зөвшөөрөх сул үг ne[133] торгууд халимаг хоёроос өөр газар тохиолдохгүй байна. Энд örüün xarγabā[134] гэдэг үг тохиолдож байна. Энэ үг Ойрд, Халимагийн ярианы хэлэнд байхаас бус Зая бандидын орчуулгад огт тохиолддоггүй билээ. Үүнээс гадна xāγāsu , nükünēsü гэхийг тод үсгийн хуучин бичлэгт xamiγa-ēce , nüken-ēce гэж бичдэг. Энд čimalai гэж бичсэн байна . Гэтэл тод үсгийн хуучин бичлэгт čima-luγā гэж бичсэн байдаг юм.

Энд өгүүлэхүүний бие заах дагавар элбэг хэрэглэсэн байна. Жишээ нь: "čі... kene bābāγai či, " bi...abaxu bi гэх мэт.

<u>Шинэжааны тод үсэг</u>. Шинэжаанд Манж чин улсын үед тод үсгийг албан амины хэрэгт хэрэглэсээр байсан байна. Манж нар 1750-аад оны үесээр Зүүн гарын нутгийг байлдан эзлээд Иль тэргүүтэн газрын хэргийг шийтгэгч сайдад мөнгөн тамга[135] олгож байсан бөгөөд тэрхүү тамгын үгийг манж, тод, нангиад үсгээр бичжээ. Бас 1755,1758 онд Манж хаанаас байгуулсан хоёр хөшөөний үгийг тод үсгээр бичсэн байна.

Дараа нь 1827 онд Иль зэргийн газрыг ерөнхийлөн захирагч жанжинд мөнгөн тамга[136] олгосон бөгөөд түүний үсгийг манж, тод, араб, нангиад дөрвөн үсгээр бичжээ. Эдгээр бичээснээс үзэхэд Зая бандидын зохиосон тод үсэгт өөрчлөлт ороогүй байлаа. Өнгөрсөн зууны үед Шинэжаанд хэрэглэж байсан тод

үсэгт, үсэг зүйн ямар өөрчлөлт орсныг мэдэх баримт одоогоор бидэнд байхгүй байна.

1940-өөд оны үед Шинэжаанд гарсан "Дайныг эсэргүүцсэн таван жилийн ойн ухуулгын хөтөлбөр"[137] гэдэг дутуу нэг дэвтрийг Ховд аймгийн Булган сумнаас бид олж авсан билээ.

Энэ бяцхан товхимолын байдлаар үзэхэд Зая бандидын зохиосон тод үсгийн үсэг зүйд төдий л их өөрчлөлт оороогүй боловч хятад үг Шинэжааны Ойрдын нутгийн аялгууны үгс өдий төдий орсон байдал харагдаж байна. Жишээ нь:



"Pa ši si Gitiler itegemǰi zörgi-yigi orkād sülēn tala dayildaǰi oroqsan -ēce nāruu sülēni ulān cerigiyin kučin batu yedür bolōd Gitiler derimčin-dü kündü yeke cokilγa ögöbei "[138]

Үүнд фашист гэдэг үгийн хятад дуудлагыг баримтлан pa ši si / 法西斯 / гэж бичсэн байна. Бас Зөвлөлт гэдэг үгийг sülēn / 苏联 /гэж хятад үсгийн дуудлагын дагуу бичсэн байна.

Энэ "янагш" гэдэг үгийг nāruu, "идэр" гэхийг yedür гэх зэргээр тэр нутгийн аялгууны үгийг яаж хэлж байсан тэр хэвээр бичсэн байна.

Ийнхүү Зая бандидын зохиосон тод үсгийн дүрэм мартагдаж Бор тал, Тарвагатай, Баянгол, Иль зэрэг хэд хэдэн газрын хэд хэдэн янзын бичлэгтэй болсон[139] байна.

Шинэжаанд хувьсгал үүссэний дараа тод үсгийн хэрэгцээ их болж Шинэжааны монголчуудад зориулан

тод үсгээр сонин гаргах болсноос гадна сургуулиудад монгол хэл заан сургах болсон байна. Энэ үеэс нэгэнт замбараагүй болсон тод үсгийг журамлах, үсэг нэмэх зэрэг ажлыг тод үсэг мэдэх сэхээтэн нар хийж эхэлсэн юм. Энэ мэт ажлын нэг нь 1953 оны 6-р сард Үрэмч хотноо гарсан гэдэг ном юм.

Үүнд Зая бандидын зохиосон тод үсгийн ts/tš -гаас tš-г ялгаварлан -гаар, z/dž-гаас dž -г ялгаж -гаар тэмдэглэх болсон байна. Үүнээс гадна Зая бандидын галиг үсэгтэй байсан h, f -г нэмж оруулсан байна.

1953 онд монгол хэлний дүрэм хэмээх бичигт шинэчилсэн цагаан толгойг хойно сийрүүлбэл:

Эгшиг[140]

эхэнд	богино эгшиг							
дунд								
адагт								
галиг		a	e	i	o	u	ö	ü
эхэнд	урт эгшиг							
дунд								
адагт								
галиг		ā	ē	ī	ō	ū	ō̈	ṻ

Гийгүүлэгч[141]

эхэнд								

дунд								
адагт								
галиг	n	ng	x	k	γ	q	g	k
эхэнд								
дунд								
адагт								
галиг	d	t	b	m	z	j	c	č
эхэнд								
дунд								
адагт								
галиг	y	r	l	w	s	š	f	p

Үүнээс хойш 4 жилийн дараа 1957 оны 2-р сарын 9-ний "Шинэжааны өдрийн сонинд" "Шинэжааны уйгарын өөрөө засах орны ардын зөвлөлийн Уйгар, Хасаг Монгол, Шивээ, Узбек зэрэг үндэстний үсгийг өөрчлөх ба үсэггүй үндэстэнд үсэг зохиож өгөх тухай тогтоол нийтлэгдсэн юм.

Шинэжаан мужид нутаглан суугч Уйгар,Хасаг,Монгол, Киргиз, Шивээ, Узбек, Татар зэрэг үндэстний үсэг бичгийг слав үсэг болгон өөрчлөх, бас үсэг бичгийг үндэстэнд шинээр үсэг зохиохын ач холбогдлыг энэ тогтоолд чухалчилан дурдсан юм.

Тод үсгийг слав үсгээр өөрчлөх теслийг Шинэжааны өдрийн сонины мөн дугаарт хавсаргасан байна. Үүнд Үүнд:

слав үсэг	А	Б	В	Г	Д	Е	Ё	Ж	З	И	Й	К

тод үсэг												
слав үсэг	Л	М	Н	О	Ө	П	Р	С	Т	У	Ү	Ф
тод үсэг												
слав үсэг	Х	Ц	Ч	Ш	Щ	Ь	Ы	Ъ	Э	Ю	Я	
тод үсэг												

Энэ тогтоол нийтлэгдсэнээс хойш 3 хоногийн дараа 1957 оны 2-р сарын 12-ны Шинэжааны өдрийн сонинд "Үсэг өөрчлөх ажлыг идэвхтэй болгон төсөд /төсөр,хялбар/ алхамаар явуулъя" гэсэн тэргүүн өгүүлэл гарсан юм.

Энэ тэргүүн өгүүлэлд бичиг үсгийг өөрчилсэн явдал бол Шинэжаан мужийн алив үндэстний нийгэм журамт соёлыг зохиох хийгээд хөгжүүлэхэд маш их тусхэн ач холбогдолтой болохыг онцлон дурджээ.

1957 оны 3-р сарын 7-ны "Шинэжааны өдрийн сонинд " "Шинэжаан уйгарын өөртөө засах орны монгол хэлний эрдэм шинжилгээний хурал хуралдав" гэсэн зүйл нийтлэгдэв. 1967 оны 3-р сарын 7-ны өдрийн хуралдаан дээр Бат гэгч хүн "Монголын утга зохиолын хэлийг эзэмшихийн төлөө чармайн оролдоё" гэдэг сэдэвтэй илтгэл, Хятадын шинжлэх ухааны академийн цөөн тоот үндэстний хэл бичиг судлах хүрээлэнгийн монгол төрлийн хэл аялгуу судлах отрядын Ойрд аялгууг байцаан судлах дугуйлангийн дарга Чойжинжав "Одоо үеийн монголын нэгдмэл утга зохиолын хэл ба Ойрд аялгуу" гэдэг сэдэвтэй илтгэл тавив. Энэ илтгэлийн гол төлөвийг бид нөхөр Чойжинжавын бичсэн "Шинэжаан дугуйлангийн Ойрд аялгууг байцаасан дүгнэлт" /Үрэмч, Хөх хот.1957.6/ гэдэг

тайлангаас мэдэж болно.

Үүнээс хоёр жилийн хойно мөнөөхөн Чойжинжавын бичсэн "Ойрлын фонемын системийн тухай" гэдэг өгүүлэл Өвөр монголын "Монгол хэл зохиол түүх" сэтгүүлд нийтлэгдсэн юм. Чойжинжав энэ өгүүлэлдээ "Шинэжааны монголчууд, слав үсэг хэрэглэхээ зогсож одоо латин үсгээр өөрийн хэлдээ тохирсон бичиг үсгийг шинээр зохиох гэж байна. Тийм учраас Ойрд фонемын системийн тухай судлах явдал их шаардагдаж байна"[142] гэж бичжээ.

Шинэжааны монголчуудад слав үсэг хэрэглүүлэх шийдвэрээсээ няцаж латин үсэг хэрэглэх болсон нь дээрх өгүүллээс бидэнд тодорхой болж байна.Гэвч Шинэжаанд слав, латин үсгийн аль алиныг хэрэглээгүй тод үсгээ хэрэглэсээр байгаа юм.

Сүүлийн үед Шинэжаанд гарсан тод үсгийн сонин бичгээс үзэхэд зэргэлдээ хэлнээс орсон үг, нутгийн хэллэг олонт тохиолдох болж жинхэнэ Шинэжааны монголчуудын тод үсэг болсон нь илэрхий байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баруун аймагт нутаглан суугч Ойрдууд тод үсгийг албан хэрэгт хэрэглэж байсангүй. Зүүн гар улс Манж Чин Улсын харьяанд орсноос хойш тод үсэг аяндаа орхигдсон байна. Манж Чин Улсын үед 1767 онд баруун монголд тод үсгээр бичсэн албан ёсны ганц баримт бол Ховдын Шар сүмийн хөшөөний бичиг юм. Баруун монголд тод үсгийг албан хэрэгт хэрэглээгүй боловч амин хувийн хэрэгцээнд сүүл үе хүртэл хэрэглэсээр байв Түүгээр ч барахгүй Ойрдын сэхээтэн нар харь хэлнээс шашны болон нийтийн хэрэгцээний ном орчуулан монгол бичгээс уран зохиол болон бусад ном зохиолыг тод үсэгт хуулан бичиж байлаа.

Үүний нэг нь нангиад хэлнээс орчуулсан "Хатгах төөнөх тэргүүтнийг ихэд хураасан ном дэвтэр" гэдэг номын 4,6-р дэвтэр юм. Энэ хоёр дэвтрийг бид гэрэл зургаар нийтлүүлсэн[143] билээ. Энэ номд Ойрдын аялгууны үг хэллэг олонтой орсон нь илэрхий байна. Жишээ нь: ömörö xalyiqsan /П.2-р талд/, xōro xalyiqsan /П.3-р талд/, xoto /П.6-р талд/ /ходоод/, xālγan /П. 6-р талд/ /зам/, gesüni /П.6-р талд/ /гэдэсний/, keyisüni /П.6-р талд/ /хүйсний/ гэх мэт.

<u>Тод үсгийн зарим зүйлийг монгол бичигт хэрэглэх гэсэн оролдлого</u>. Хэдийгээр тод тод үсгийг өргөн дэлгэр хэрэглэхээ зогссон боловч тод үсгийн үсэг тэмдэг зэрэг аль хэрэгцээтэй зүйлийг уйгаржин монгол бичигт хэрэглэж байсан баримт зарим гар бичмэлээс гарч байна.

Улсын багшийн дээд сургуулийн багш нөхөр Төмөртогоо Сэлэнгэ аймгийн нэг хүнээс 40-өөд хуудастай гар бичмэлийг олж авсан байна. Энэ гар бичмэлийг нөхөр Төмөртогоо хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт бэлэглэсэн[144] юм. Энэ гар бичмэлд cēǰindēn ǰaγan-i noγitan arasu /6в талд/ zakā üyile bütēküyin tula /7в талд/ dotōdu γadādu /16а талд/ könön /21 а талд/ гэх мэтийн олон үг тохиолдож байна.

1968 онд хэл зохиолын хүрээлэнгээс Дундговь аймагт явсан шинжилгээний ангийнхны олсон

(Čoγ tu bayilduγan-ača teyin böged ilaγuγsan ündüsün-ü qaγan-i delgerenggüi tayiluγsan čoγtu ǰula kemekü-eče γutaγar bölug-ün delgerenggüi tayilburi) гэдэг гар бичмэлийн [145] 65в, 66а талд бичсэн зүйлд тод үсгийг монголтой холиж бичсэн байна. Жишээ нь:

/66-р талд/ (Üčüüken görösün-dü muu qān engke amuγuulang bolqu.amitan ǰirγaqu.teqši čaq sayin. üčüüken dayisun olon, zarliq zasaq yeke bolqu.qulγayiči olon bolqu.ebečin taqul üdei uridu yosōr bui).

1969 онд Ховд аймгийн орон нутаг судлах музейгээс тод үсгийн номын хөмрөгт шилжүүлэн авсан / Qotala tegüsügsen xan köbegün-ü tuγuǰi / гэдэг номд бас дээрх мэт зүйл тохиолдож байна. Жишээ нь: (ene nasun daγan qan-u coγ-iyar ǰirγan atala / /16а талд / / Ay-a yeke qān-ā tere čindamani erdeni-yi bi γuγur-a odsuγai) /18в талд/,

(Čimeg miqan-i tan-u idesügei kemen
Čidkür kümün-ü düri-ber qubilǰi irged,
Čiqul maγu γaǰar-a abču oduγad
Čokiǰu alabai čhā (zhā) caγas-i minu ebü iyilē)

Монгол бичигт тод үсгийн үсэг тэмдгийг хэрэглэж бичсэн ном одоогоор бидэнд энэ гурав байна.

Үүнээс гадна иймэрхүү ном хэд хичнээн байгааг бид мэдэхгүй байна. Бид тод үсгийн номыг хайж сурвалжлахын хамтад бас тод үсгийн үсэг,тэмдгийг хэрэглэн бичсэн уйгаржин үсгийн гар бичмэл барын номыг олж түүнд зохих судлагаа хийх ёстой юм.

Тод үсгийн зарим зүйлийг Буриадад хэрэглэх гэсэн оролдлого

Зая бандидын зохиосон тод үсгийг Буриадад "Торгууд үсэг" хэмээн нэрлэж байснаас гадна ихэд сонирхож байжээ.

Буриадын нэрт эрдэмтэн Сумади-раднаа буюу Лувсанринчен 1892 онд "Монгол үсгийн ялгалыг үзүүлэгч тодорхой толь" гэдэг нэртэй зохиолыг бичсэн байна. Энэ зохиолдоо тод үсгийн цагаан толгой,үгийг бичих жишээ тэргүүтнийг тодорхой бичжээ.

Цагаан толгойн эхэн хэсэгт Раднаабадраагийн зохиосон ойрдын Зая бандидын магтаалыг бага зэрэг өөрчлөн оруулсан байна.

(Erdemiyin usu bariqči baxaraqsan dotoro-ēce
Enerikü̈i yeke duun bükü züqtü duurisun .
Eši uxāni nomiyin xurayigi amitan dalai debeltüdü orouluqči
Erdem biligiyin üre öüskeqči Za ya pandida-du sögüdömüi)

Цаашид Зая бандидын намтар "Сарны гэрэл", Зая бандидын орчуулсан Сувашидаас унших жишээ оолгон оруулсан байна.

Бас Баргажин хийдийн шавь Цэ... нэрт[149] гэгч

1908 онд зохиосон "Монгол үсгийн өчүүхэн заавар шинэ толта товч цадиг-лугаа сэлт "[150] гэдэг зохиолд Зая бандидын зохиосон тод үсгийн "Эгшиг үсгийн дүр адил бус ба урт охорын ялгал тэмдгүүдтэй байнам" хэмээн давшилттай сайн зүйлийг тодорхойлон бичжээ.

Цааш нь уйгаржин монгол үсгээс үлгэр авч манж, тод үсгийг зохиосон тухай дурджээ. Тэгээд тэрхүү Цэ... нэрт монгол үсэгт цэг тэмдэг нэмж эгшиг үсгийг тодорхой болгосон байна.

Уйгаржин үсгийг ямар учраас тодорхой болгох гэсэн, ийнхүү тодорхой болгохыг юунаас үлгэр авсан зэргийг энд бичжээ.



(Edüge aldarsiγsan üsüg inu neres udqas-i toduraγulun bičiküi-dür neng moquγ-a boluγad endegürel-tei ba tögerel-tei tula deger-e ögülegsen Mongγol üsüg-eče γaruγsan Torγud ba Manǰu kelen-ü üsüg-üd-eče üliger ǰisiy-e abču qaγučin eke üsüg-i yekede ködelgel ügei ǰarim nigen em-e-yin temdeg ügei em-e ügüg-üd-tür temdeg talbiǰu eger endegürel arilγay-a)

хэмээн санал тавиад Монгол буриадын хийдийн лам нар хийгээд орос монгол сургуулийн багш нараас өөрсдийн зөвлөлгөөн өгөхийг хүссэн байна.

Бас буриадын аялгуунд тохируулан зохиосон Вагиндараагийн үсэг нь мөн л Зая бандидын зохиосон тод үсгээс үлгэр жишээ авсан үсэг байсан юм.

Ийнхүү Зая бандидын зохиосон тод үсэг нийт Монгол даяарт дэлгэрч чадаагүй болов ч түүний давшилттай чухаг зүйлс нь зөвхөн Ойрд, Халимагаар үл баран Халх Буриад хүртэл түгэн дэлгэрч байжээ.

Дүгнэлт

Зая бандид монгол бичгийг тодорхой болгох зорилгоор тод үсгийг зохиосон билээ. Энэ зорилгоо Зая бандид биелүүлсэн байна. Гэвч алив тодорхой бус бөгөөд нийтэд дэлгэрсэн үсгийг тодорхой болгох тутам тэрхүү бичгийн хэрэглэх хүрээ нь улам явцуу болдог ёсыг Зая бандид ойлгоогүй байжээ.

Иймэрхүү нэгэн жишээг үзэхэд Грекийн цагаан толгойгоос үндэслэсэн латин үсэг бол цөөн үсэгтэй. Гэхдээ эртний грек латин хэлэнд хүрэлцээтэй үсэг байв. Хожим энэ үсгийг авч хэрэглэсэн улс үндэстний хэлэнд мөнөөхөн грек үсэг нь дутмаг болжээ. Иймэрхүү бэрхшээлийг хэрхэн туулсан бэ гэвэл нэг-дүгээрт, нэг үсгээр олон авиа тэмдэглэх /жишээ нь с /ц/ үсгээр к, ц хоёр авиаг, s үсгээр з, с хоёр авиаг тэмдэглэх/ хоёрдугаарт, нэгэнт буй үсэгт тэмдэг нэмж болгох /жишээ нь с дээр ˇ тэмдэг нэмж ч авиаг, s дээр ˇ тэмдэг нэмж ш авиаг тэмдэглэх/, гуравдугаарт, алив тодорхой авиаг хэд хэдэн үсгээр тэмдэглэх / жишээ нь ш-ийг франц хэлэнд ch ; англи хэлэнд sh , польш хэлэнд sz , итали хэлэнд sc , герман хэлэнд sch гэх мэт/ аргаар даван туулсан байна.

Зөвхөн тод үсэг ч бус, ер алив үсэг, жишээлэхэд грек үсгийг хэдий тодорхой болгох тутам түүний нийтлэг чанар хэрэглэх хүрээ нь улам явцууран тухайн улс үндэстний бичиг болон хувирдаг ёс дээрх жишээнээс тодорхой байна.

Тод үсгийн дэлгэрэц төдий л их газар авахгүй

төлөв Зая бандидыг эсэн мэнд байхад мэдэгдэж байсан байна. Зая бандид Төвдөд очоод буцах замдаа 1652 онд Хөх нуурын хөвөө Шавартай гэдэг газар мөргөл тавьсан байна. Тэгэхэд Гүүш хааны хүү Далай хун тайж, Зая бандидтай уулзаж "Шашин амьтны тусын тул дээр /Зая бандидад Л-Б/ айлтгасан нь: ер монгол хэлтэнд Зөрчидийн богд хаанаас их /хүн/, үгүй, таны зарлигаас үл давахын тул хаанд монгол үсэг тэргүүтэн ном дэлгэрүүл хэмээн зарлиг болгох ахул сайн асанжээ хэмээн айлтгасанд ламын гэгээн мишээн үйлдэж чиний зөв боловч омогтой хаан амуй, хүрч /байж/ мэдэе хэмээн зарлиг болов. Тэр ч хааныг үл сүслэх илэрхий айлдсан мөн амуй хэмээн манд хойно зарлиг болов"[151] гэжээ.

Тэр үед /1652 онд / нэгэнт дэлгэрсэн уйгаржин монгол үсгийн тухай энд яриагүй нь мэдээж хэрэг. Ийм учраас тод үсгийг нийт монгол хэлтэнд дэлгэрүүлэх талаар Манжийн хаанаар хүчлүүлэх саналыг Далай хун тайж гаргаж байжээ. Гэвч Манжийн хаанд дургүй байсан Зая бандид энэ асуудлыг тэрхүү "омогтой хаанд" тавиагүй байна.

Ойрдын Зая бандид уйгаржин монгол үсгийг тодорхой болгож тод үсгийг зохиосноор энэ үсэг нийт монголын үсэг болсонгүй, харин хэрэглэх хүрээ нь явцуран Ойрдын үсэг,улмаар Халимагийн үсэг, Шинэжааны Ойрдын үсэг болон хувирсан байна.

Гуравдугаар бүлэг

ТОД ҮСГИЙН БИЧИГ ЗОХИОЛ

1. Тод үсгийн бичиг зохиолыг ангилах нь

Тод үсэг 300 гаран жил хэрэглэгдэхдээ олон төрлийн олон бичиг зохиолыг бидэнд үлдээсэн байна.

Тод үсгийн ном нь манай Улсын нийтийн номын сан, Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөг, Увс, Ховд аймгийн орон нутаг судлах музейд тус тус хадгалагдаж байгаагийн гадна,Увс, Ховд аймгийн зарим сумдын номын санд цөөвтөр боловч ном бас бий.

Зөвлөлт Холбоот Улсын Ленинград хот дахь Дорно дахиныг судлах салбар хүрээлэнгийн номын сан, Ленинград хот дахь , Ждановын нэрэмжит улсын их сургуулийн Дорно дахины хэл судлах факультетийн номын санд тод үсгийн нилээд олон бөгөөд сонирхолтой ном байгаа билээ.

Зөвлөлт Халимагийн архивт Аюк хан /1670-1724/, түүний хатан Дарамбала, хүү Шагдаржав нараас тод үсгээр бичиж Астраханд явуулж байсан захидал бичиг зэрэг албаны хэрэг хадгалагдаж байна.

Саяхан Германы монголч эрдэмтэн Хейссигийн нийтлүүлсэн "Монгол бичмэл, барын ном хийгээд газрын зураг"[152] гэдэг номын дотор Германд хадгалагдан буй монгол ном газрын зургийг жагсаан бичсэнээр үзэхэд энд тод үсгийн нилээд ном байгаа нь тодорхой болов.

БНХАУ-ын Шинэжаан Уйгарын өөртөө засах оронд утаглан сууж буй монголчуудад тод үсгийн сонин ном зохиол байгаа болов уу гэдэг горьдлого тасраагүй байна.

"Тод бичиг,дэлхий дахинд алдаршсан "Жангарын туух", "Гэсэрийн туух" мэт уран зохиолын болон Хятад,Төвд зэрэг хэлнээсорчуулсан "Тансан ламын туух", "Шидэт хүүрийн туух", "Саран хөхөө шувууны туух", "Бигармижид хан хөвгүүний туух" зэрэг өдий тэдий олон зохиолыг тэмдэглэж бидэнд уламжлан өгч байна"[153] гэж "Монгол хэл бичиг" өгүүллийн нэгэн дугаарт бичсэн байна.

Бас Шинэжааны өдрийн сонины 1957 оны 6-р сарын 8-ны өдрийн 68/901/ дугаарт "Манай Шинэжааны соёлын хөгжилтийг голчлон 1648 оны барагт ойрдын эрдэмтэн Зая бандидын зохиосон тод монгол үсгээр дамжуулж тэмдэглэж ирсэн байна. Жишээлбэл: Үүнээс мянга илүү жилийн урьд /зохиосон/ Гэсэрийн туух, ХШ зууны үед гарсан Монголын нууц товчоон /sic! /, ХҮ зууны үед гарсан Жангарын туух болон бас тусгаар олон туужнууд ч энэ үсгээр тэмдэглэгдэж ирсэн байна" гэж Батжав гэгч хүн бичжээ. Зөвхөн энэ хоёр баримтаар үзэхэд Шинэжааны монголчуудын гарт нилээд сонин ном судар байсан бололтой.

Гэвч Хятадад болсон соёлын хувьсгалын үр дүнд тэдгээр сонин ном судрын хувь заяа хэрхэн шийдвэрлэгдсэн болохыг бид мэдэхгүй байна.

Бидэнд байгаа тод үсгийн номыг тус улсын Увс аймгийн Дөрвөд,Баяд, Хотонгоос, Ховд аймгийн Мянгад,Өөлд, Захчин, Торгууд, Хошуд, Урианхай, Халхчуудаас, Баян-өлгий аймгийн монгол хэлтэй Урианхай нараас олж цуглуулсан юм. Бас ч Говь-алтай аймгийн Хөх морьт, Завхан аймгийн Их уул, Хөвсгөл аймгийн Рашаант, Архангай аймгийн Булган, Өвөрхангай аймгийн Хар хорин сум сангийн аж ахуйн дэвсгэр нутгаас цөөн боловч тод үсгийн ном олдож байсныг

тэмдэглэх хэрэгтэй. Үүнээс гадна тод үсгээр чулуу болон метал эдлэл дээр бичиж байсан байна. Үүнд: Тайхир чулууны бичээс,Ховдын Шар сүмийн бичээс /1767 он/, Зүүн гарыг түвшитгэж тогтоосон явдлыг Илийн газарт тэмдэглэн байгуулсан гэрэлт хөшөө чулууны бичээс /1755 он,1758/, Увс аймгийн орон нутаг судлах музейд хадгалан буй хутганы бичээс зэргийг бид мэдэж байна.

Одоо Улсын нийтийн номын сан, Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт давхардсан тоогоор 2000 ном цугларсан байна. Эдгээр номын нэг хэсэг буюу Улсын нийтийн номын санд хадгалагдан буй тод үсгийн номыг 1930-аад оны орчим цуглуулсан байна. Тод үсгийн номын нөгөө хэсэг буюу Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт хадгалагдан буй номыг 1965-1970 оны хооронд цуглуулсан байна.

Дурдсан хоёр хөмрөгт хадгалагдан буй тод үсгийн ном нь хэд хичнээн болох, түүний дотор ямар ямар ном буй болохыг үүний өмнө эрдэмтэд бичиж байгаагүй учир тоймыг хойно өгүүлэх юм.

Хоёр хөмрөгт байгаа бүх номыг нарийвчлан шүүн үзвэл давхардаагүй тоогоор 424 төрөл зүйл ном байна. Байгаа бүх ном зохиолыг дор дурдсан 15 ангид хуваагаад анги тус бүрд хэдэн ном байгаа, тэр нь хэдэн хувь эзлэхийг тодорхойлбол:

№	анги	тоо	хувь
1	Түүхийн анги	10	2,5
2	Намтар,шашин дэлгэрсэн түүх	21	5.5
3	Сургаал туужийн анги	43	10.3
4	Үсэг бичгийн анги	10	2.5
5	Сан тахилгын анги	38	8.9
6	Зурхай мэргэ төлгийн анги	67	15,8

7	Эм домын анги	35	8,5
8	Судрын аймаг	2I	5,5
9	Тогтоол тарнийн аймаг	52	I2,0
I0	Итгэл бодь мерийн аймаг	II	2,6
II	Үйлийн үрийн аймаг	5	I,2
I2	Шашин болон нийтийн зан үйлийн аймаг	20	5,0
I3	Уншлагын аймаг	44	I0,4
I4	Эш зарлигийн аймаг	22	5,4
I5	Тусгай анги	I4	3,3

2. Түүхийн анги

Тод үсгээр байгаа түүхийн хэрэглэгдэхүүнийг гаднах нэрээр нь үзвэл орон нутгийн түүх мэт боловч дотор нь гарч байгаа түүхэн үйл явдлаар нь орон нутгийн түүхийн хүрээнээс хальж гарсан зүйл байна.

« [illegible] »
154 « [illegible] »
« [illegible] »
« [illegible] » « [illegible] »
« [illegible] »
« [illegible] » « [illegible] »

зэрэг зүйл байгаа юм. Үүнээс "Сарны гэрэл" монголоор болон тод үсгээр нэгэнт нийтлэн судлагааны хүрээнд оруулсан хийгээд "Алтан эрхэн" гэдэг зохиолоос монголын түүхэнд холбогдох хэсгийг нэгдүгээр бүлэгт тоймлон дурдсан билээ.

Харин ч монголыг судлагч нарын сонорт хараахан хүрч амжаагүй байгаа зарим судар бичгийн тоймыг бид энд ярих болно.

Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт « [illegible] » « [illegible] » « [illegible] » хэмээх нэртэй хоёр гар бичмэл байна. Улсын нийтийн

номын санд « [illegible] » хэмээх нэртэй монгол үсгийн бичмэл буй. Энэ гурван ном үндсэндэ адил юм. Улсын нийтийн номын сангийн энэхүү бичмэлийн тухай шинжлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн, түүхч Х.Пэрлээ бичихдээ"Үүнийг I75I оны үед зохиосон бололтой. Зохиогчийн нэр мэдэгдээгүй. Энэ зохиолын нэр нь орон нутгийн түүх шинжтэй боловч, дотор нь бичсэн гол үнэтэй сонин түүхэн хэрэг явдал нь ар,өвөр Монголд холбогдох ХҮП-ХҮШ зууны үеийн мэдээнүүд байна"[I55] гэжээ.

"Дөрвөн ойрдын тууж" бичихэд "Сарны гэрэл", "Их дэлгэр түүх" гэгчийг ашигласан гэж зохиогч бичжээ. Дөрвөн ойрдын түүхэнд холбогдолтой " Их дэлгэр түүх" хэмээх сонин сурвалж бичиг байгаа нь бидэнд тодорхой болж байна.

"Дөрвөн ойрдын тууж" нь он дараалаар бичсэн эхлэл төгсгөл бүхий түүх бус I0 шахам хэсэг бусаг зүйлийг түүвэрлэн авч эвлүүлэн бичсэн байна.Гэхдээ үйл явдал нь ойрдын түүхэнд холбогдолтой буюу эсвэл ойрдын түүхэнд холбогдуулан бичсэн зүйл байна. Үүнд:

I. Адиша нь Торгууд хүн байсан[I56] түүнийг Тангадууд булааж авсан тухай.

2. Зүүн гар дөрвөн ойрдын яс омгийн ялгал. Үүнд: Чороос, Хошууд, Торгууд, Хойд,Жирэд [illegible] ? Шарс, Махас, энэ долоон омог нь Дөрвөн ойрдын ноёдын омог бөгөөд 72 омог албат буй гэсэн байна. Баг ойрдын дотор аль хошуу баруун гар болох,аль хошуу зүүн гар болох тухай бичжээ.

3. Дөрвөн ойрдын ноёд нэг нэг хүүгээ ванди болгосон тухай. Үүнд тод үсгийг I636 онд зохиосон

гэжээ.

4. Ойрдын болон ер нь түүхэнд холбогдолтой зохиолын тухай бичжээ. Үүнд "Сарны гэрэл", "Их дэлгэр түүх", "Үлгэрийн далай", "Далан хоёр хаан хөвгүүний туужь", "Богд Бигармижид хааны туужь" зэргийг энд өгүүлсэн байна.

5. Ойрдууд төмөр үхэр жилд алаг дааганы тооснооc дүрвэсэн тухай домог. Энэ домогт үнэний хувь буй юм. Төмөр үхэр жил буюу 1661 онд Хошуудын тайш Хөндлөн Увш 3000 өрх албатыг авч Зүүн гараас Ижил мөрөнд хүрэлцэн очсон тухай энд өгүүлж байна.

6. Амарсанаагийн тухай домог.

7. Тэмээн хар бөхийн тухай домог. Үүнд Жур эмгэний хүү их бяртай байсан учир " Тэмээн хар бөх" хэмээх цол авсан тухай домог байна.

8. Ойрдын Цэрэндондог нарын зэрэг ноёд Эрдэнэ зууг довтолсон тухай.

9. Манжийн хаанаас Зүүн гарын хаанд ирүүлсэн бэлгийн тухай.

10. Халимагийн Аюк хааны хүү Санжав албатаа авч Зүүн гарт ирсэн тухай . "Халимаг хаадын туужид" энэ тухай бичсэн нь

[illegible]

гэжээ.

11. Амарсанаагийн тухай домог. Энэ түүхэнд Амарсанаагийн тухай домог хоёр ч газар тохиолдож байна. Энэ домогт Амарсанаагийн баатарлаг явдлыг дурдаад Монголд Амарсанаа дахин нэг цагт ирж Манжийн дарлалаас монголын ард түмнийг чөлөөлнө гэдэг

санааг дурджээ. Энэ домог нь баруун монголоос Б.Я.Владимирцовын тэмдэглэж авсантай адил[157] байна.

Энэ зохиолын нөгөө нэг хувилбар манайд байна. Үүнд дээрхтэй зөрөөтэй зүйл бий. Энэ хувилбарт Дөрвөн ойрд гэгч юу болохыг тайлбарласан байна. Есүгэй их хаан тэргүүлэн дунд бага хаадууд байхад Дөрвөн ойрд гэгч байсан. Түүний нэг нь долоон хошуу халх дөрвөн аймаг, өвөр 49 хошуу; хоёрдох нь Хотон, Хасаг; гуравдах нь Золийд / [illegible] / хэмээх их орон байсныг долоон шарга морьтой шумнас ирж хөтлөөд далайд орсон; дөрөвдүгээр нь Зүүн гар,Дөрвөд, Торгууд, Хошуд, Хөх нуур, Алшаа, Бурууд, Хойд, Хүрүүд /Хүрээд [illegible] /, Цахар, Урианхай эдгээр нийлж Дөрвөн ойрд болно гэж бичжээ.

Тус хөмрөгт " [illegible] " хэмээх нэртэй бичмэл бий. Энэ түүхийг Шинэжааны Илийн газарт нутаглан суугч манж угсааны хүн бичсэн нь сонирхолтой. Зохиогч өөрийн тухай бичихдээ:

" [illegible] "

гэжээ. Энэ түүхийг Бадруулт төрийн 33-р он улаагчин хонин жил буюу 1907 онд бичжээ.

Энэ түүхэнд монголын хаадыг хятадаас гаралтай гэж бичсэнээс гадна ойрдын холбогдол бүхий явдал, тоо баримт байгаа юм. Энэ бяцхан түүхийн нэгдүгээр хэсэгт Ойрдод хожим үед болсон хэрэг явдал тухайлбал Г'алдан Бошигт, Амарсанаа, Даваач нарын явдлыг бичсэнээс гадна Зүүн гарын 24 отог тэдгээрийн зайсангуудын өрхийн тоо, жас, лам нарын тоо, 21 ангийн нэрийг тоочсон нь сонирхолтой. Эдгээрийг дүгнэж хэлэхдээ Зүүн гарт 24 отог, 9 жас, тайж нарын 21 ангид байх өрхийн тоо 20 түм илүү, бүгд хүн

ам 50 түм илүү гэсэн байна.

Мөнхүү номын хоёрдугаар хэсэгт Торгуудын гарлыг дурдаад Халимагийн Увш хан албатынхаа хамт Зүүн гарт 1771 онд ирсэн тухай бичжээ. Увш хан Халимагаас гарахдаа 3 түм 3 мянга илүү өрх, 16 түм 9 мянга илүү хүн байсан боловч Ильд ирэхэд 7 түм хүрэхтэй үгүйтэй хүн байсан гэжээ.Дурдсан тоо нь Халимаг хаадын туужид байгаа тоотой мөргөж байна.

Үүнээс гадна өвөр монголын багшийн дээд сургуулиас дармаллан гаргасан "Тод монгол хэлээр хэвлэсэн түүхийн материал" хэмээх эмхтгэлд тодийл сонирхол татууштай мэдээ байсангүй. Үүнд Халимаг хаадын туужийн сүүл хэсэг, Увш түмний туурвисан Дөрвөн ойрдын түүх, Их цаазын бичгийн зарим хэсэг зөрөг зүйл оржээ.

Увш түмний туурвисан Дөрвөн ойрдын түүх,Гаван Шаравын түүх, Халимаг хаадын туужийн зөрөг нь хэдийнээ монголч эрдэмтдийн мэдээжийн сурвалж бичиг болох тул энд дурдах хэрэггүй гэж үзэв.

Улсын нийтийн номын санд хадгалагдан буй Даваач ноёны бичиг, Дөрвөд ноёдын угийг бид гэрэл зургаар нийтлүүлсэн бөгөөд Даваач ноёны бичгийн тухай судлагааг "Шинжлэх ухааны академийн мэдээ" сэтгүүлд нийтлүүлсэн билээ[158].

3. Намтар, шашин дэлгэрсэн түүхийн анги

Энэ ангид номын товч бүртгэлийн 0011-0032 -рт орсон 22 ном байна. Үүнд





зөрөг зохиолыг бид бурхан хийгээд бурхан шашны зүтгэлтэн нарын намтрын хэсэгт оруулав. "Бурхны 67 төрлийн үе хэмээх зохиол нь 314 хуудас бүхий гар бичмэл юм. Энэ зохиол нь 100 бүлэгтэй байхаас сүүлийн 67 бүлэг нь бидэнд олдоод байна. Нэр бүхий намтруудаас бидэнд хамгийн сонирхолтой нь



болно. Энэ ном 6 бүлэгтэй ихээс их зохиол бөгөөд Зонховын үйл амьдрал цөмийг шүлэглэн бичсэн байна. Энэ зохиолын тахилын хэсэг төгсөөний дараа :



гэж эхэлжээ. Энэхүү намтрыг уран зохиол, яруу найргийн дурсгалын хувьд цаашид сайтар судлан үзэх нь чухал юм.



зөрөг зохиолыг бид шашин дэлгэрсэн түүхийн ангид оруулж байна.



гэдэг хоёр номд монголын түүхийн холоогдол бүхий зүйл буй. "Чухал хэрэгт" гэдэг бичмэлийн 39а талд "Бурхан гаслангаас нөгцөөд гурван мянган хоёр зуун тавин жил нөгцөхүйд зүүн зүгийн Монголын оронд урьд буяны үр боловсорсон хүчтэй тэнгэрийн заяасан Чингис хаан бүх оронд эрх учруулан усан морин жилтэй хорин гурван жил хаан ор бариад, гал гахай жил намрын эхэн сарын арван хоёрт, жаран зургаан насанд огторгуйд өөд болов. Түүний хоино улам өгөөдэй

хаан, хан ор зургаан жил болов. Хүлүг хаан хан ор зургаан сар барив. Мөнх хаан хан ор есөн жил барив. Цэцэн хаан модон гахай жилтэй, эр, төмөр бичин жил дөчин зургаанд хаан ор бариад гучин зургаан жил хан ор барин модон морин жилийн тэргүүн сарын хорин хоёрт наян хоёр насанд огторгуйд өөд болов. Өлзийт хаан арван гурван жил хан ор барив. Хүлүг хаан хан ор дөрвөн жил барив. Буянт хаан хан ор есөн жил барив. Гэгээн хаан хан ор гурван жил эзлэв. Есөн төмөр хаан хан ор таван жил эзлэв. Арчиваг хаан хан ор дөчин хоёр хоног барив. Ринченбал хаан хан ор нэг сар барив. Тогоон төмөр хаан эм усан тахиа жил хан оронд суугаад эцэст эр шорой бичин жил наймдугаар сарын хорин найманд хаан орноос хөөгдөв. Эм модон Эрхэт хаан ор аван хан ор зуун дөчин жил Монгол барив. Арван таван хааны үе болон хаан тэдэн ч цорж Саж ач авгаас тэрүүлж Дээш оюут буян хүртэл өглөгийн эзэн болон бурхан шажныг эзлэн хүндлэн үйлдэв" гэжээ.

Нөгөө хоёрдох бичмэлд Чингис, Өгөөдэй, Гүвээ / ? /, Мөнх, Хувилай, Өлзий, Хүлүг, Буянт, Гэгээн, Төмөр, Ранзуг / ? /, Хүшлэй, Заяат, Радна Шар / ? /, Тогоон төмөр хаад хэдий хугацаанд хаан ширээнд суусан тухай, Гүүш хааны тухай, таван өнгө улсын тухай дурджээ.

Монголын түүхийн талаар дурдсан нэр бүхий сударт буй зүйл нь ерийн зохиолд байдаг баримт тул сонирхол татмаар онцгой зүйл энд үгүй байна.

4. Сургаал, тууж, бичиг үсгийн анги

Тод үсгийн номын товч бүртгэлийн 0033-0075 -рт сургаал туужийн ангид орох ном зохиолыг бүрт-

гэн авсан юм.

Энэ ангилалын нэгдүгээр хэсэг болох сургаалын хэсэгт



зэрэг зүйл байна. Үүнд монгол эхээс тедийлөн зөрөөгүй буюу монголоос тод үсэгт буулгасан



Чойжамц гэцлийн орчуулсан



, Түшээт хааны зарлигаар 5-р Далай ламын зохиосон



буюу хэмээх



зэрэг зохиол байна.

Бас ч монгол эхээс зөрөөтэй буюу Ойрдод орчуулсан тодорхой баримт бүхий зохиол ч бас байна. Үүний нэгэнд



орно. "Субашидийг Цүүхэр дурдсан ёсоор Зая бандид Намхайжамц орчуулсан байна. Зая бандидын орчуулсан "Субашид" бол Сономгараагийн дараагаар монгол хэлэнд орчуулсан орчуулга болох юм. Орчуулгын байдлыг үзвэл үг найруулгын хувьд Сономгараагийн орчуулгатай ойр байна.

Энэ зүйлд холбогдох



хэмээх сургаал байгааг дурдсан билээ. Энэ судар бүрэн болон дутуу нийт гурван хувь байгаа юм. Энэхүү зохиолын зарим хэсэг нь хойд насыг номлосон боловч ард олны аж төрөх, ёс суртахууны зохистой сургаалыг цөөн мөр шүлгээр өгүүлжээ. Жишээлэхэд:

[illegible]

гэжээ.

"Эрдэнэ төрийн шащдиртай" төстэй "Мөнх бусын сургаал " хэмээх бичмэл буй. Энэ сургаалыг гарын доор буй монгол бичмэлүүдээс шүүгээд мөн судар оруулж элдэв хувилбарыг олсонгүй. Энэ сударт

[illegible]

гэх мэтчилан сургажээ.

Энэ ангилалын хоёрдугаар хэсэг болох туужийн бүлэгт [illegible] [161] [illegible] -ий зарим бүлэг. Гэсэрийн зарим бүлэг, "Үлгэрийн далай", "Саран хөхөө", "Мялын намтар", "Чойжид дагинын тууж", "Манухарын тууж", "Сайн Магадын тууж", "Монголын увш хун тайжийн тууж", "Хар үхэрт хөдөөний тууж" зэрэг 30 гаран ном байна.

Эдгээр ном зохиолын заримыг монголоос тод үсэгт буулган бичсэн байна.Жишээлэхэд: 323 хуудас бүхий

Бигармижид хааны намтар, Арж Борж хааны намтар, Хэсэнэ хааны намтар гэдэг гурвалж зохиол бүрэн байна. Энэ гурвуулан өөр ном болов Бигармижид хааны явдал, түүний эрдэнийн ширээн дэхь 32 модон хүний үлгэр гардаг юм.

Бас [illegible] хэмээх хуудас бичмэл буй. Үүнийг мөн л монголоос хуулан бичжээ. Тэгэхдээ монгол эхийн төгсгөлийн үг үүнд дутуу байгаагийн гадна зарим зүйлд ойрд аялгууны үгийг нөхөн оруулсан байна.

Тус хөмрөгийг 290-р тэмдэгтэд [illegible] нэртэй хоёр өөр гар бичмэл буй. Үүний тэргүүн хэсэгт I-I3- р бүлэг, дэд хэсэгт I4-25-р бүлэг буй. Тод үсгийн бичмэл шидэт хүүрийг I928 онд Улаанбаатар хотноо хэвлэсэн монгол эхтэй тулган үзэхэд бүлгийн тоо, агуулга тохирч байгаа боловч үг үсгийн зөрөөтэй.

[illegible] гэдэг ном бидэнд ганц хувь бий. Үүний төгсгөлийн үгэнд "Зарлигт хун тайж орчуул" гэсэнд Бандид гүүш монголын аялгуунд орчуулсан гэж бичжээ.

Гэвч Ойрдод орчуулсан нь тодорхой мэдэгдэж байгаа хэд хэдэн зохиол байна. Үүнд: [illegible] буюу "Үлгэрийн далай" Бодичаръяа Авадарагийн төгсгөлийн бүлэг. [illegible] буюу Чойжид дагины тууж, [illegible] зэрэг зохиол байгаа юм.

Тод үсгийн [illegible] судар буюу "Үлгэрийн далай" бол Улсын нийтийн номын санд нэг хувь, хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт нэг хувь, Ленинград хот дахь Дорно дахины

судлах хүрээлэнгийн салбарт нэг хувь, Германд 2 хувь байгаа нь мэдэгдэж байна. Дэлхий дахины томоохон номын сан хөмрөгт дурдсан судар таваас дээш байхгүй байгааг үзэхэд тод үсгийн ховор дурсгал бичгийн нэг болох юм. Ийм ч учраас бид тод үсгийн "Үлгэрийн далай" гэрэл зургаар нийтлүүлсэн[162] билээ. "Үлгэрийн далайн" төгсгөлийн үүнээс үзэхэд "Гомбо ноёныг өөд болсонд" Зая бандид орчуулсан гэжээ. Гомбо ноён бол Дөрвөдийн Далай тайшийн 5-р хүү бөгөөд Дөрвөн ойрдын түүхэнд гардаг нэртэй хүний нэг мөн. Гомбо ноёны нас барсныг "Сарны гэрлээс " хөөн үзвэл 1655[163] он байна. Ийм учраас Зая бандид "Үлгэрийн далайг" 1655 онд орчуулсан гэж үзэж болох юм.

Тод үсгийн "Үлгэрийн далайг" монгол эхтэй тулган үзвэл тод эх 51 бүлэгтэй, монгол эх 52 бүлэгтэй.

Манай тооллын XII зууны үед Энэтхэгийн зохиолч Шантидэвагийн зохиосон "Бодичаръяа Авадара" буюу [illegible] гэдэг судрыг Зая бандид орчуулсны 10-р бүлгийг төгсгөлийн үгийн хамт ойд "Сундуй" дотроос санхан оллоо. Шантидэвагийн энэ алдарт зохиолыг 1305 онд Чойжи-одсэр монгол хэлнээ орчуулж түүний дараа 1312 онд тайлбар зохиол хэвлэж гаргасныг бид мэднэ. Чойжи-Одсэрийн тэр орчуулгыг 1748 онд Гүүш Гилгийн далай дахин хянаж хэвлүүлжээ.

Ойрдын Зая бандид 1650-аад оны үед Бодичаръяа Авадараг орчуулсан нь түүний намтар "Сарны гэрлээс" тодорхой. Ингэхээр Бодичаръяа Авадараг монгол хэлнээ орчуулсан хоёрдохь хүн бол Ойрдын Зая бандид мөн юм.

Зөвлөлт Холбоот Улсын нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов 1917 оны 4-р сарын 25-нд А.В.Бурдуковт бичсэн захидалдаа "Усиленно занимаюсь Бодисатвачарьяватарой, приготовил текст для печатния с тибетско-монгольским словарем", "Еще раз буду очень просить Вас поискать Бодисатвачарьяватара на тодо или по монгольски"[164] гэжээ.

Академич Б.Я.Владимирцов 1929 онд Ленинград хотноо нийтлүүлсэн Бодичаръяа Аватарагийн монгол орчуулгын оршилд "Имеются сведения о том, что Zaya pandita перевел Bodhicaryāvatāra на ойратский калмыцкий язык /XVII в/, но дох сих пор, несмотря на усиленные поиски как у поволжских калмыков,так и у ойратов Северо-Западной Монголии, перевода этого обнаружить не удалось"[165] гэж бичжээ.

Бодичаръяа Авадараг Сономсо болон Ойрдын ноён Дайчин дурдсанд Зая бандид орчуулжээ. Сономсо нь хошуудын Цэцэн ханы /Очирт тайж/ хатан, Галдамбаагийн эх Пунцагдулма Пунцагролма, Ойрдын ноён Дайчин хэмээх нь Хоо өрлөгийн хүү Шүхэр дайчин нар мөн бололтой.

Ойрдод орчуулсан орчуулгын нэг бол [illegible] "[illegible]" болно. Мялын туужийг монголчууд хэдэнтээ орчуулсны анхны нь Хөх хотын гүүш цоржийн орчуулга /1618 онд/ болно. Түүний дараах орчуулга бол Зая бандидын орчуулга юм. Бид мөн зохиолын 147 хуудас бүхий бичмэл эхийг Ховд аймгаас олж авсан билээ. Мялын туужийг орчуулж өгөхийг Үхэрэй баатар тайж хэмээх хүн Зая бандидаас хүсчээ. Мялын туужийг орчуулахад бичээч Цүлтэмжамц үнэсэн самбарт, Алдар бичээч цаасанд тус тус бичжээ.

Зая бандидын орчуулгаас ихэд дэлгэрсэн зохио-

лын нэг бол [illegible]
бутуу Чойжид дагинын тууж болно. Энэ зохиолыг Намхайринчен цорж хэмээх хүн хүссэн ёсоор Зая бандидаас орчуулж Раднаабадра / Сарны гэрлийг зохиогч/ үнэсэн самбарт бичиж, Уран хонжин /Ойрдын хүн/ цаасанд хуулан бичжээ. Зая бандидын энэ орчуулгыг Буриадад монгол үсгээр бичсэн[166] байна.

Зая бандидын энэ орчуулгаас дахин төвд хэлнээ орчуулсан бичмэл бидэнд олдсон юм. Энэ бичмэлийн төгсгэлийн үгэнд "Цорж Намхайринчен дурдаж Зая бандид орчуулсан орчуулгыг Раднаабадраа бичсэн Чойжид дагинын тууж Монгол үсгээр элбэг болов монгол үсэг мэдэх хүн хоёрыг дээр төвд эх тэр нутагт үл олдохын тул монгол бичмэлээр эх хийж төвд хэлнээ орчуулсан"[167] гэжээ.

Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт "Сайн Магадын тууж" нэртэй нэгэн дутуу гар бичмэл буй. Бас "Сайн Магадын тууж" нэртэй өөр нэг орчуулга Ленинград хот дахь Дорно дахины судлах салбар хүрээлэнгийн номын хөмрөгт буй[168]. Энэ ном угаас профессор Голстунскийн ном байсан бололтой. Ленинградад хадгалагдан буй энэ туужийг Ойрдод / Халимагт ?/ орчуулжээ. Үүнийг Халимагийн Аюк хаан /1670-1724/, түүний эгч Доржравдан /Хошуудын Цэцэн хааны бага хатан/ нар дурдсанд

Олон хүн сонсоход сайхан болгохын тул
Үгийн эхний үсэгнүүдийг холбоон
Урт ахрыг оюуны хирээр Бандид цорж хэмээх
зассан

гэж төгсгэлийн үгэнд дурджээ. Үнэхээр ч "Сайн Магадын тууж" нь 66 бадаг 264 мөр шүлэг байгаа юм.

Хэл зохиолын хүрээлэнд хадгалагдан буй "Сайн Магадын тууж"-ийн эхний хэсэгт

[illegible]

Ленинград хотод буй мен туужид:

[illegible]

гэх зэргээр шүлэглэсэн байна.

Тус хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгийн 443-р тэмдэгтэд [illegible] нэртэй бичмэл буй. Үүнийг хэдийд хэн орчуулсныг бид тогтоож чадсангүй. Юу болов академич Ц.Дамдинсүрэнгийн нийтлүүлсэн "Зуун билигт" оруулсан Урадын гүүш Цоржийн орчуулгаас өөр юм. Ушаандар хаан Мандари хатан хоёр хөвгүүдээ дагуулан явж байтал олон гуйлгачин ирж юм гуйсныг монгол эх бичигт бичсэн нь :

[illegible]

[illegible]

гэжээ.

Тод үсгийн эхэд:

[illegible]

гэжээ.

Ушаандар хааны туужийн монгол, тод үсгийн эхийг харьцуулан судласан судлагааг монголч эрдэмтэн Н.Н.Поппе нийтлүүлсэн билээ[169].

Тод үсгийн уран зохиолын номын чухам юуг нь монголоос хуулсан, юуг нь жинхэнэ ойрдод орчуулсан буюу зохиосон болохыг тодорхойлох явдал бол монголын уран зохиолын түүхийг судлахад чухал зүйл болно.

Үсэг бичгийн ангид холбогдох номыг товч бүртгэлийн 0076-0085-рт бүртгэсэн бөгөөд эдгээрээс бидний сонирхлыг татаж байгаа [illegible]

зэрэг номын тухай хоёр, дөрөвдүгээр бүлэгт тодорхой дурдсан тул энд давхардуулсангүй.

5. Сан тахилгын анги

Сан тахилгын ангид хамаарах зүйлсийг товч бүртгэлийн 0086-0124-рт бүртгэсэн 39 төрөл зүйл ном байна.

Сан тахилгын зүйлийн нэг хэсэг нь тэнгэр, нөгөө

хэсэг нь гал, гуравдахь хэсэг нь газар усны сан тахилга, дөрөвдүгээр хэсэг нь шашны холбогдолтой бөгөөд сан тахилгын ихэнх зүйлс нь бөө мөргөл, бөөгийн аман зохиолтой учир холбогдолтой хэмээн үзэж болно. Жишээ нь: [illegible] -д

[illegible]

гэх зэргээр бичсэн байна.

Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгийн 461-р тэмдэгтэд [illegible] хэмээх нэртэй төдий л элбэг тохиолддоггүй судар буй. Үүний эхэн хэсэг нь:

[illegible]

гэж урнаар хэлжээ. Цааш нь гучин алд зэлийг татуулж хур далт азарга хурдан гүйдэлт агтны буян хишиг, дечин алд зэлийг татуулж дэл ихт азарга, дэлэн ихэт гүүний буян хишгийг гуйсан байна. Бас газар ус тахихад цагаан морь,цагаан хонь нэгээс илүүг алж, малын зүлд, хар сээр, малын ясыг түлнэ гэжээ.

Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт [illegible] хоёр байгаа нь ерөнхийдөө монгол эхтэй адил юм. Зуун билигт байгаа мөнхүү сангаас зөрөөтэй зүйл тод үсгийн эхэд үзэгдэж байна. Жишээ нь:



гэжээ.

Тус хөмрөгт [illegible] нилээд хэд байгаа боловч бидэнд урьд олдсон, хэвлэгдсэн сангаас илүү сонин үгтэй тийм зүйл тохиолдсонгүй.

Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт [illegible] хэмээх 3 хувь байна. Энэ сангийн үгэнд баруун монголын нутгийн аялгууны үг бий.



хэмээн урин залж эхлээд цааш нь бууг ариулах тахихад зориулсан нилээд олон мөр шүлэг байгаа юм.



Үүнд "нэвт" гэхийг "эвт" , замгийг "маш" гэх зэрэг нутгийн аялгууны үг байна.

Тус хөмрөгт [illegible] судар нийт 7 хувь байна.Энэ сударт шашны нөлөө их байгаа боловч зарим хэсэгт бөөгийн аман зохиолын зүйл байгаа бололтой.

" Хурдан цагаан зааныг унасан
Хурц бэлэг билигийн илд барьсан.
Гурвант цавчивал үл даагдах
Гучинт харвавал үл тусах" Их богдыг тахин залбирсан байна. Үүнд:





гэсэн байна.

Уг зохиолын утгаар үзэхэд хуяг илдийг эрхэмд үзэж, түүнийг бат бэх байх болтугай хэмээн ерөөн даатгаж байсан монголын эртний аман зохиол бололтой.

Тус хөмрөгт байгаагийн 2 нь /70,315-р тэмдэгтэй/ монгол сударт бараг адил. Харин 553 /89/-р тэмдэгтэд бүртгэгдсэн судрын сүүлийн хэсэг өөр зүйл байна. Энэ бичгийг хуучин монголоор бичсэн ямар нэг эхээс хуулж бичсэн нь бичлэгийн байдлаар мэдэгдэж байна. Жишээ нь:





гэх зэргээр бичсэн байна.

Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт газар усны санд нилээд байгаагийн ихэнх нь Ойрд, Баруун монголын газар нутагтай холбогдолтой байна. Жишээ нь:



хэмээхэд Алтайн нуруу, Хан хөхий,Сутай Дарви уулын нэр гарч байна. хэмээх бичмэлд Хан хөхий, Хархираа, Улаангом,Эмил, Тарвагатай, Зайр Бор тал, Хаш, Хүнгэс, Зулдас,Тахис, Тэсхэл нуур, Шар бэлгэн, Хар тал, Хөх усан, Богд аглаг уул, Торхлиг, Тагна, Усва буюу Увс, Хяргас нуур, Гилбэн Түлбэн, Завхан, Хүнгий, Хар Аргалант, Хар нуур, Шинэ усан, Өндөр Хөхүй, Арван гурван Алтай, Гучин гурван Хөхий богд, Эрчис, Ховог, Сайр,Өлгий нуур, Бөхүүнэ, Шар хар ус, Ёлын шил, Ялгайт зэрэг уул усны олон нэрийг тоочиж байна.

хэмээх нэртэй 460-р тэмдэгт бичмэлд Алтайн хаан, Богд алаг уул, Эмил, Бор тал,

Иль, Булган, Цэнгэл, Өрөнгө, Цагаан гол, Индэрт, Бумбат зэрэг газар усны нэрийг дурджээ. Энэ бичмэлийн дотор орсон зарим газар нь Ховд аймгийн Булган сумын нутаг болно.

Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгийн 69-р тэмдэгтэд бүртгэгдсэн 4 хуудас бичмэл буй. Энэ зохиол нь Хасагийн бөө мөргөлтэй холбогдолтой юм. Энэ бичмэлийн эхний хэсэг нь:



гэх зэргээр дурдсан байна.

Цаашид [illegible] зэрэг нилээд олон сангийн зүйл байгаагийн ихэнх нь шашны агуулгатай юм.

Энэхүү ангид орсон зүйлийг дахин нарийвчлан

судалж нийт монголын холбогдолтой нь юу болох, зөвхөн орон нутгийн чанартай сан тахилгын зүйл юу болохыг ялган салгаж тодорхойлох нь чухал юм.

6.Зурхай, мэргэ төлгийн анги

Зурхай, мэргэ төлгийн ангид холбогдох нилээд олон судар байгааг товч бүртгэлийн 0I25-0I9I -рт бүртгэсэн 67 төрлийн ном байна. Эдгээр судрын дотроос зурхайн хэсэг нь цөөн бөгөөд мэргэ төлгөд холбогдох бага сага зүйл нь олон юм.

Энэ ангид холбогдолтой номуудын дотроос хамгийн том нь [illegible] хэмээх судар ажээ. Үүнд 7 гариг, 28 одны зураг тэргүүтнийг гоц сайхан зурсан юм. Ер нь энэ мэт зураг бүхий хуудас бүгд 44 байна. Энэ зохиол нь 45,7 х 9,7 см. хэмжээтэй цааснаа бичсэн I79 хуудастай I0 бүлэгтэй ном юм. Үүнийг Даш гэдэг хүн дурдсанд Бандид цорж гэгч орчуулжээ.

Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгийн 86I/ 8/, 932 /I6/-р тэмдэгтэд [illegible] гэдэг хоёр бичмэл буй бөгөөд энэ хоёр нь нэг ном болов хоёр өөр орчуулга болно. Энэ бичмэлд бүгд 47 төрөл зүйлийг гариг одтой тохиолдуулан үзэх бүлэгтэй. Ойрдын Зая бандидын орчуулсан номын жагсаалтанд "Зурхайн зуун үзэл" гэдэг ном байгаа болов дурдсан хоёр бичмэлд монгол хэлнээ орчуулсан төгсгөлийн үг байхгүй байна. Ийм учраас энэ хоёр өөр орчуулга чухам хэний орчуулга болохыг олж тогтоож чадсангүй.

Бас [illegible] нэртэй I7 хуудас ном байгаа бөгөөд үүний I-р зүйл нь: [illegible]
2-р зүйл нь: [illegible]
3-р зүйл нь: [illegible]

4-р зүйл нь:
5-р зүйл нь:
6-р зүйл нь:
7-р зүйл нь :
8-р зүйл нь:
9-р зүйл нь:
I0-р зүйл нь:
II-р зүйл нь:
I2-р зүйл нь:

Энэ номд сар, жил, жаран жилийн байдал хийгэ
байгалийн алив үзэгдэл нь хүн, мал, тариалан, ца
төрийн байдалд хэрхэн нөлөөлөхийг дурдсан ном юм.
Үүний төгсгөлийн үг дутуу учраас чухам хэн дурдса
хэн орчуулсныг тогтоох баримжаа олдсонгүй.

Тус хөмрөгт буй « » гэдэг нэртэй 49 хуу-
дас бүхий бичмэлд олон зүйлс үзэхийг зааса байна
Энэ судрыг Эрх гэлэн, Маш багш хоёр дурдсанд Ба
дид цорж хэмээх орчуулсан бололтой
« » гэдэг 30 гаруй хуудастай
бичмэл манайд буй. Энэ номын утга нь алив хүний
үхсэнийг гариг одон лугаа тохиолдуулан үзээд шалт
гааныг тодорхойлж байгаа юм. Жишээ нь:

гэх мэтчилэн тэрхүү үхсэн хүний "үгээр" болгон
зохиожээ.
хэмээх хоёр бичмэл тус хөмрөгт буй. Эхний бич-
мэлд нар, сар хиртэх, нар сар хиртэхийн шинж
байдал цагийг мэдэх гэх зэрэг зүйл буй."Эрдэнийн
зул хэмээх зурхай" нь зөвхөн нар, сар хиртэх ту-
хай өгүүлж,түүнийг бодож олох тооны нилээд арга
хэрэглэхийг заажээ. Энэ номын " " хэмээх
хэсэгт :

гэх зэргээр тодорхойлон бичжээ.
" " гэдэг ном нь "нар сар хаах
зэрэг", "Барих хэмжээ", "Өнийн /удааны/ хэмжээ",
"Цагийн хэмжээ", "Барих зүг", "Өнийг үзүүлсэн нь"
зэрэг нилээд олон бүлэгтэй зохиол юм.

Тус хөмрөгт 625 /347/-р тэмдэгт бичмэлд үзлэг,
домын зүйл орсон байна. Үүнээс бидний сонирхлыг
татаж байгаа буюу угсаатны зүйлд холбогдолтой гэж
үзсэн зүйл нь" " хэмээх нэртэй үз-
лэг юм. Үүнд бүгд 67 зүйлийн ёр, түүнд хэрэглэх
дом тэргүүтнийг заажээ. Энэ номын I0-р зүйлд
" " 67-р зүйлд
гэжээ.

Зарим литийн зүйлд монголын түүхийн холбогдолтой мэдээ сэлт байдгийг бид мэднэ.

[illegible] буюу 1913 оны Литэд Чин улсын хаад тер барьж байсан оныг тодорхойлсноос гадна Дервед аймгийн холбогдолтой мэдээ бий. "Арван гуравдугаар гал туулай жил доторхи усан тахиа жилд /1753/ Тэнгэр тэтгэгчийн арван наймдугаар онд Дервед арван зургаан аймаг ноёд /Манжид/ орсон", Арван дерэвдүгээр гал туулай жилийн доторхи шороо барс жилд буюу 1818 онд Цэцэн ван нас барж Гунгааноров хаан ширээнд суусан, Тер гэрэлтийн 9-р он шороо үхэр жил 1829 онд Гомбожав хэмээгч хаан ширээнд суусан, Бадаргуулт тер хааны 10-р онд буюу 1884 онд ван Гомбожав нас барсан, Бадаргуулт терийн 12-р он буюу 1886 онд Соднамжамц хаан ширээнд суусан. "Сайтор гарсан 15-р гал туулай жилийн доторхи темер гахай жилд /1911/ Олноо ергегдсен хаан терийн алтан ширээнд заларсан ... Олноо ергегдсений хоёрдугаар он усан хулгана жилд 1912 онд энэ еглегийн эзэн их ноён чин ван Үнэн зоригт хаан хэрхэм дэвшсэн, бас хүрэн жолоо шагнасан, мен жилд тергүүн зэрэг тайж Аюурзана бэйс хэргэм дэвшсэн, бас хоёр нүдэн отгоор шагнав. Хатан Панмад Номын дарь цол ергемжлен шагнасан, мен онд Үнэн зоригт хааны тамга, чуулган даргын тамга, засаг тамга шинэчлэн халж шагнав" гэх зэргээр тоочин бичсэн байна.

Тус хемрегт мэргэ телгенд холбогдох олон ном байгаагийн дотор 9 зоос, 5 зоосны судар, шооны судар, Гэсэр хаан, Зуу Адишаагийн мэргэ, телег зэрэг зүйл байна. Эдгээрээс нилээд сонирхолтой нь далны судар мен.

Тус хүрээлэнгийн хемрегт [illegible] хэмээх нэртэй тедий л элбэг байдаггүй нэг бичмэл бий. Энэ бичмэл таван зүйлтэй бегеед эхний зүйлд далны мэргэ хэрхэн үүссэн домог байна.

Эрт цагт ариун сүүнээс цагаан енгет олон хонь далайд ус уухаар одов. Тэдгээр хонь еерийн дүрсийг далайн усанд туссаныг үзээд ижил маань байна хэмээн майлалдан еед уруу гүйж явахад их Лусын хаан үзээд:

"Адгуусны аймагт терел бегеетел
Асар сүүнээс цагаан енгет
Ийм нэгэн хонь белгее" хэмээн магтан

олон хонины евчин тахлыг ершеж хонины даланд нэгэн билиг цацав гэсэн домогтой. Тийм учраас дал мэргэн болдгийн шалтгаан энэ юм. Цаашид энэ сударт хонины дал таван янз байдаг. Үүнтэй уялдуулан хонины зүс, үс ямар байдаг зэргийг дурдсан. Энэ сударт "Хонийг адилтган үзэх", "Хонины далын дээр эзнийг билигдэн үзэх", " Далны хайс /тогоо/ үзэх" зэрэг сонирхолтой бүлэг бий. Үүнээс гадна Улсын нийтийн номын санд [illegible] гэсэн нэртэй бичмэл буй. Энэ бичмэлд далны нилээд олон зураг буй юм. Уг номыг Зүүн гарт зохиогдсон тухай мэдээ тегсгелийн үгэнд тохиолдож байна. "Зүүн гар ноёд олноор дурдсан нүүрт" зохиосон /зохиогчийн нэргүй / гэж бичсэн байна.

Энэхүү зурхай, мэргэ телгийн ангид орсон зарим бичиг судрыг зевхен хэл бичиг, ном зүйн хувиар судлаад зогсох бус одон орон, тоо бодлого, түмэн бодисын ухааны мэргэжилтэн нар нарийвчлан судлан үзэж бидний евег дээдэс дурдсан, ухааны талаар тухайн үедээ хир зэргийн мэдлэгтэй байсан, юуг шинээр нээсэн, юуг хаанаас уламжлан авсан, ямар чиглэлийг

баримтлаж байсан зэргийг ялган салгах нь чухал болж байна.

7. Эм домын анги

Монголчууд эрт дээр цагаас эхлээд анагаах ухааны орчин үеийн арга эмчилгээг хэрэглэх хүртэл янз бүрийн арга хэрэглэж байснаас гадна янз бүрийн зохиолыг туурвих, орчуулах зэргээр түүхэн үе шатыг өнгөрүүлсэн байна.

Анагаах ухааны эрдэмтэд ардын эмнэлэг болон монгол, төвд эмнэлгийн талаар зохиол судлагааны зүйл гаргасан боловч тод үсгээр байгаа анагаах ухааны ном зохиолын талаар судлагаа шинжилгээ хийсэн зүйл одоо хүртэл гараагүй юм.

Улсын нийтийн номын сан, Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт эм домын холбогдол бүхий 35 төрлийн ном байгаа нь давхардсан тоогоор 46 ном буй. Эдгээр номыг дотор нь ардын эмнэлэгт холбогдолтой зүйлс, төвд хэлнээс орчуулсан, хятад хэлнээс орчуулсан, орос хэлнээс орчуулсан зохиол хэмээн ангилж болно.

Ардын эмнэлэгт холбогдох зүйлст,хавсаргасан товч бүртгэлийн 02I3, 02I4, 02I5, 02I6, 02I7,02I8, 02I9,0220,022I,0222 зэрэг дугаар орж байгаа юм. Үүнээс нэн сонирхолтой нь [illegible] юм.Энэ номын дотор хөх хуцын эвэр, элэг, цөс, зүрх,тархи, яс, мах, өөх зэргээр I3 төрлийн өвчнийг анагаах тухай дурдсан байна. 225-р тэмдэгт номын сүүл хэсэгт ардын эмнэлгийн холбогдолтой хэдэн сонин зүйл буй. Үүнд "Сүүний ашгийг өгүүлэхүй", "Туулайн бие дэх эм", "Үнэгний бие дэх эм","Багваахайн бие дэх эм", "Хөх үхрийн бие дэх эм", " Хар үхрийн бие дэх эм" гэсэн гарчиг буй. Алив өвчин эм-

гэгийг мал адгуусны гаралтай эмээр эмчилбэл сайн гэх буюу эрдэнэ гэжээ. Жишээ нь: "Халуун хүйтэн хийд эм эс зохихул үргэлж үхрийн сүү уувал сайн" гэх буюу "ходоодонд идээ /идсэн юм/ тогтож өвчин болсноор халуу оргиод шингэн ядахад хар үхэр, хар хонины сүү хольж уувал сайн" гэжээ.

Ардын эмнэлэгт холбогдолтой зүйлсийг нууцалдаг ёс байсан болов уу гэдэг баримт 225-р тэмдэгт номын төгсгөлийн үгнээс олдож байна. Дээдэснүүдийн амны увдисыг бичигт бичих ёс үгүй болов ч өчүүхэн сайн санаагаар хөтлөгдөж, ер амны увдисын зүйлийг далдлаж нууж бичдэг ёсон бүхийг тэвчээд тарнийн үсэг хийгээд эмийн найрлагыг ... өөрийн мэдсэнээс өчүүхэн ч орхилгүй мэдэх хэлээр монгол хэлэнд буулгасан" гэж бичсэн байна. Бас ардын эмнэлгийн холбогдолтой зүйлийг түүвэрлэн бичсэн [illegible] гэдэг ном буй.

Зая бандид I650-I662 оны хооронд эмийн дөрвөн үндэс буюу [illegible] гэдэг дөрвөн боть номыг дөрвүүлэнг орчуулжээ. Тэдгээр дөрвөн боть номоос бидэнд "Язгуур үндсэн" , "Хойд үндсэн" хоёр нь байгаа юм. "Язгуур үндсэн" 6 бүлэгтэй, "Номлохуйн үндсэн" 3I бүлэгтэй, "Увдисын үндсэн" 92 бүлэгтэй, "Хойд үндсэн" 25 бүлэгтэй, бүгд I54 бүлэгтэй. Бидэнд одоо 3I бүлэг нь тод үсгээр олдоод байна.

Бас "Язгуур үндэснээс" хэсэглэн авсан өөр нэг орчуулга байгааг Чойжиндаш гэдэг хүний дурдсанаар нэг хүн орчуулжээ.Үүний нөгөө талаар "Хойд үндсэн" гэдэг номыг зүүн гарын хаан Галданцэрэнгийн үед буюу I74I-I742 оны орчим барлажээ.

"Эмийн дөрвөн үндэсний" нэмэлт болох "Лхан-

тавын" өөр нэгэн орчуулгыг олж авсан билээ. Энэ судрыг хэдийд хэн гэгч орчуулсныг тодорхойлох баримт бидэнд тохиолдсонгүй.

Тус хөмрөгт нэг хоёр хуудас эмийн жор нилээд олон байгаа юм. Эмийн жороос хамгийн их нь Улсын нийтийн номын санд хадгалагдан буй [illegible] гэдэг жор юм. Үүнд эм найруулах олон жор байгаа нь сонирхолтой юм.

Бас хятад хэлнээс орчуулсан [illegible] IV, VI дэвтэр буй. IV дэвтэр нь 81 хуудастай 18 зурагтай. VI дэвтэр нь 128 хуудастай II зурагтай юм. Энэ дэвтэрт зүү тавихад хэрэглэх 9 зүү, түүний хэмжээ, зүү тавих цэг, хэдийд зүү тавьж болохыг заасан цаг хугацааг гаргасан байна. Үүнийг Ойрдод орчуулсан болохыг түүний хэл найруулгаас мэдэж болно.

Хуучин бичиг дурсгалын зүйлд орос хэлнээс орчуулсан ном маш ховор юм. 1960 онд Хөвсгөл аймгийн Рашаант сумаас 153 хуудастай нэгэн дармал номыг Улсын нийтийн номын сангийн ажилтан нар олж авчээ. Энэ ном нь [illegible] гэдэг нэртэй,хүүхдийн өвчнийг анагаах тухай ном байв. Нэгдүгээр дэвтэр нь 217 бүлэгтэй, хоёрдугаар дэвтэр нь 84 бүлэгтэй.

Энэ хоёр дэвтэрт өвчний шинж тэмдэг, тэр өвчин ямар шалтгаанаар үүсэх, хэрхэн эмчлэх тухай тодорхой дурджээ. Мөнхүү хоёр дэвтрийн хавсралт болгож эмийн ургамлын орос монгол хадмал нэрийг ард нь жагсаасан байна.

Энэ номыг Иосиф Камнечук гэгч зохиож "Титуларный советник болоод квалер Микулай Лебедев"

гэдэг хүн орчуулж 1811 онд хэвлэн гаргасан байна.

Европ зүгийн анагаах ухааны номыг монгол хэлнээ орчуулсны анх нь энэхүү " Ахархан сургаал" байж ч магадгүй.

8.Бурхан шашны холбогдолтой судар

Тус хөмрөгт хадгалагдан байгаа номын 42,1 хувь нь буюу 175 ном нь бурхан шашны холбогдолтой зүйл юм. Үүнийг дотор нь бид судрын аймаг,тогтоол тарнийн аймаг, итгэл бодь мөрийн аймаг, уншлагын аймаг, эш зарлигийн аймаг зэрэг 7 ангид хуваасан билээ.

Судрын аймгаас [illegible] "Pañcarakşā" тогтоол тарнийн аймгаас [illegible] итгэл бодь мөрийн аймгаас [illegible] зэрэг томхон судрууд байна. Эдгээр хөлгөн судрын ихэнхийг Зүүн гарт орчуулсан юм.

Ойрд нутагт шарын шашин ихэд дэлгэрч ном судрыг хуулан бичиж тахих болсноос гадна зарим хүмүүс буяныг бодож тухайлсан номыг олон хувь бичиж тараах ёс байжээ. Тийм ч учраас зөахөн манай хөмрөгт [illegible] зэрэг ном 26-80 хувь хүртэл буй.

Энэ бүлэгт орж байгаа ном судар бол бүхэлдээ шашны агуулгатай болохын дээр шүтлэг, уншлага, шашны дотоод зан үйл, шашны ёс суртахуун, үйлийн

ур боловсрох, хойд нас зэргийг номлосон байна. Ийм учраас агуулгын хувьд монголын уран зохиолд шууд холбогдолгүй бөгөөд онц сонирхолтой зүйл ч байхгүй. Гэвч монголчуудын хэл, бичгийн 300 жилийн дурсгалынх нь хувьд нарийвчлан судлах нь чухал юм.

х х х

Алив ангилалд орж болмооргүй буюу уранхай тасархай хэсэг бусаг зүйлс, тод үсгийн зүйлд холбогдох монгол бичмэл, гэрэл зураг, Шинэжааны хожим үеийн хэвлэл зэрэг зүйлийг тусгай ангид оруулсан болно.

9. Тод үсгийн барын ном

Монголч эрдэмтдийн зарим нь ойрд тод ном огт барлаж байгаагүй. Зарим нь барлах анхны оролдлого гарч байсан, зарим нь барын ном тун цөөхөн байсан гэх зэргээр зохиолдоо бичжээ.

Бидэнд одоо бэлхнээ барласан хэд хэдэн ном байгаа учраас дээр дурдсан саналаас ойрдод тод монгол ном огт барлаж байгаагүй гэдгээс бусад саналыг зөвшөөрөн хүлээх хэрэгтэй юм.

Тод монгол барын номын талаар монголч эрдэмтдийн урьдын судлагааны товчийг энд өгүүлье.

Нэгдүгээрт: Б.Лауфер "Монголын утга зохиолын төлөв" гэдэг зохиолдоо Халимаг буюу Ойрдод монгол ном барлаж байгаагүй бололтой. Тийм ч учраас барын ном огт үзэгдсэнгүй, зөвхөн гар бичмэл судар л тохиолдож байлаа[170] гэжээ.

Хоёрдугаарт, нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов, мөнөөхөн Б.Лауферийн "Монголын утга зохиолын төлөв" гэдэг номын орос орчуулгын ор-

шилд Зөвлөлт Холбоот Улсын Азийн музейд тод үсгээр барласан хоёр ном байгаагаар үзэхэд ойрдууд ном барлахыг оролдож байжээ[171].

Гуравдугаарт, Монголч эрдэмтэн Хейссиг "Монгол гар бичмэл барын ном хийгээд газрын зураг" гэдэг зохиолдоо Ленинград хотноо буй барын хоёр ном, мөн барласан мэдээ бүхий нэг ном /253-р/, барласан номын дутуу тасархай хуудсыг /ЕВ, 405, НЕЕ, II06-I8, НЕЕ, II06-20; НЕЕ, II06-I6/ тоолоод одоогоор мэдэгдэж байгаа тод монгол барын ном долоон ширхэг байна[172] гэжээ.

Деревдүгээрт, Академич Ринчен өөрийнхөө зохиолуудад тод монгол барын номын тухай онцлон тэмдэглэсний[173] дотроос "Нангиадаас орчуулсан ойрдын орчуулга" гэдэг өгүүлэлд тод монгол барын ном 7 буюу 8 байгаа нь мэдэгдэж байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь манжийн үеэс өмнөх үед холбогдох[174] гэжээ.

Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгт одоогоор бэлхнээ байгаа барын ном I2 байгаагаас гадна барласан мэдээ бүхий ном 2 байна. Бид барын зарим ном судрын барласан он цагийг ойролцоо буюу тодорхой аль нэгэн хэмжээгээр олж тогтоохын тулд барласан тухай мэдээ бүхий төгсгөлийн үгийг бүтнээр нь сийрүүлэн авъя.

I. "[illegible]" барын хүрээ 42,7 х I0,9 см. хэмжээтэй, 382 хуудастай. Хэл зохиолын хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгийн 592 /I/ 455-р тэмдэгтэй. 2 хувь.

Энэ судрыг барласан тухай төгсгөлийн үгийг хойно сийрүүлье.

[illegible]

гэжээ Барласан тухай төгсгөлийн үгэнд " Найман мянгат" судрыг Галданцэрэн хааны зарлигаар усан нохой жил хэвт даруулсан тухай тодорхой мэдээ байгаа учраас энэ судрыг чухам хэдийд барласныг хялбархан олж болох юм.

Галданцэрэн хаан I695 онд төрсөн бөгөөд I745 оны эцэс юм уу I746 оны эхээр нас барсан байна. Галданцэрэн хааныг эсэн мэнд байх хугацаанд усан нохой жил ганц удаа тохиолдож байгаа бөгөөд энэ нь I742 онд байна.

Тийм учраас "Найман мянгат" судрыг I742 онд барласан гэж үзэх бүрэн үндэстэй байна.

2. [illegible] барын хүрээ 38 х 8,6 см. хэмжээтэй, I20 хуудастай. Хэл зохиолын хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгийн III-р тэмдэгтэй I хувь.

Алтан гэрлийн судрыг барласан тухай төгсгөлийн үгийг хойно бүтнээр нь сийрүүлбэл:

[illegible]

Барласан тухай энэхүү төгсгөлийн үгнээс үзвэл уг судрыг Зүүн гарт бус Ижил мөрний Халимагт барла-

сан байна. Учир нь энд дурдсан Рабжамба Лувсан, олны эзэн ойрдын ноён Дондовдаш буюу Дондогдаш нь халимагийн хүн юм. Голстунский I880 онд нийтлүүлсэн "I640 оны монгол ойрдын цаазын бичиг, Галдан хун тайжийн нэмсэн зарлиг, жич халимагийн Дондогдаш хааны үед Ижил мөрний халимагт зориулж зохиосон хууль цааз" гэдэг зохиолын тайлбарт Рабжамба Лувсан, Дондогдаш хааны тухай дурдсан байна.

Рабжамба Лувсан бол Ижил мөрний халимагийн тэргүүн лам байсан бөгөөд Дондогдаш хааны хамт Ижил мөрний халимагт зориулсан хууль цааз зохиоход оролцож байжээ. Алтан гэрлийн судар барлуулахыг Рабжамба Лувсан дурдсан бөгөөд Дондогдаш хаан болон Дэжид хатан нар барлуулсан байна. Дондогдаш бол Шагдаржавын ахмад хүү бөгөөд Аюк хааны ач болох хүн юм. I74I оны 7-р сарын 3I-нд халимагийн хаан ор залгаж I757 оны 3-р сарын 2I-ний өдөр албан ёсоор халимагийн хаан өргөмжлөгджээ. I76I оны I-р сарын 2I-ний өдөр нас барсан байна. Дэжид хатны тухай тодорхой мэдээ хараахан олсон үгүй. "Нийтийн их эзэн хатан Дэжид" гэж байгаагаар үзвэл, Дондогдаш хааны эх байж магадгүй.

Энэ "Алтан гэрлийн" судрыг I74I-I76I оны хооронд лавтай барласан гэж үзэхэд болохоор байна.

3. [illegible] Хоёр хувь нэг нь 44 х I2,7 см.хэмжээтэй. 92 хуудастай. Тус хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгийн I02-р тэмдэгтэй. Нөгөө нь 47,8 х I9,2 см. хэмжээтэй. 93 хуудастай. II2-р тэмдэгтэй. Аль алиныг хулсан үзгээр улаан, хар бэхээр

бичсэн бичмэл. Барласан тухай төгсгөлийн үгийг хойно бүтнээр нь сийрүүлбэл:



Энэхүү төгсгөлийн үгнээс үзвэл уг номыг Галданцэрэн хааны зарлигаар, хэсэг лам нар эх бичгүүдтэй тулган шүүж төмөр тахиа жил монголоор хэвт даруулсан гэж байна.

Төмөр тахиа жил бол Галданцэрэн хааны эсэн мэнд байсан үед ганц удаа тохиолдож байгаа бөгөөд энэ нь 1741 он юм. Дээр хоёрдугаарт дурдсан Алтан гэрлийг 1741- 1761 онд барласан лавтай мэдээгээр үзвэл хорин жилийн хугацаанд Алтан гэрлийн судрыг хоёр удаа барласан гэж үзэж болохоор байна. Нэгдүгээр бар буюу 1741 онд барласан Алтан гэрлийг Зүүн гарт, хоёрдугаар бар буюу 1741-1761 оны хоорондбарласан Алтан гэрлийг Ижил мөрний халимагт тус тус барласан байна.

Ийм ойрхон хугацаанд нэг судрыг хоёр дахин барласан учрыг олоход хэцүү болов нэг талаар Зүүн гарт барласан Алтан гэрлийн бар маш цөөн хувь байж болох юм. Нөгөө талаар Зүүн гарын хаант улс, Ижил мөрний Халимаг хоёрын хоорондын харилцаанд төвөгтэй шалтгаан байсан учраас Алтан гэрлийг тэндээ барлах болсон байж магадгүй юм.

4. 
Барын хүрээ 53,5 х 11 см. хэмжээтэй 69 хуудастай, хэл зохиолын хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгийн 3-р тэмдэгтэй нэг хувь.

Энэ сударт барласан тухай төгсгөлийн үг байхгүй учраас чухам хэдийд барласныг хэлэхэд бэрхтэй юм. Гэвч цаасны байдлаар үзвэл мөн л 1740-өөд оны үед барласан болов уу гэж үзмээр байгаа юм. Бас энэ судрын хэсэг нь болох эмийн дөрвөн үндэсний "Язгуур үндсэн", "Увдисын үндсэн" зэргийг барласан эсэхийг харуулах баримт үгүй байна.

5. 
Барын хүрээ 31,5 х 7,0 см. 25 хуудастай. Хэл зохиолын хүрээлэнгийн 644 /537 тэмдэгтэй. Төвд, тод монгол хадмал бар.

Энэ номыг орчуулсан болон барласан тухай төгсгөлийн үг байхгүй учраас чухам хэн орчуулсан, хэн барлуулсан гэдгийг тодорхойлох нехцөлгүй байна. Цаасны байдал бичгийн хэвийг үзвэл хожим үеийнх болов уу гэж бодогдмоор байна.

6. 
Барын хүрээ 19,2 х 4,9 см. 55 хуудастай. Яг үүний ижил барын судар академич Ринченгийн хувийн номын санд 1 хувь, Улсын нийтийн номын санд 2, тус хөмрөгийн 1,2-р тэмдэгтэд 2 хувь буй.

Энэ судрыг барласан тухай төгсгөлийн үг байхгүй болов ч цаасны байдлаар сүүлийн үед барласан гэдэг нь мэдэгдэж байгаа юм. Энэхүү барыг Дөрвөдийн сүүлийн Төгөс хүлэг ханы өргөөнд сийл-

сэн болох тухай академич Ринчен бичсэн байна[175].

7. [illegible]

Барын хүрээ 19,5 х 4,5 см. 56 хуудастай. Энэ сударт барласан тухай төгсгөлийн үг байхгүй Үүний ижил хувь Ленинград дахь Дорно дахиныг судлах салбар хүрээлэнд буй.

8. [illegible]

33,5 х 13,0 см хэмжээтэй. 26 хуудастай. Увс аймгийн орон нутаг судлах музейд хадгалагдан буй.

Тус хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгийн 6[в], 9, 10, 183, 413, 482 /18/, 638 /47/-р тэмдэгт "Таслагч очир" судар нь дээр дурдсан барын судраас хуулсан төгсгөлийн үгтэй байна. Барласан тухай төгсгөлийн үгийг хойно сийрүүлбэл:

[illegible]

Энэхүү төгсгөлийн үгнээс үзвэл мөн л Галданцэрэн хааны зарлигаар хэсэг лам нар эх бичгүүдтэй тулган шүүж төмөр тахиа жил буюу 1741 онд монголоор хэвт даруулсан байна.

9. [illegible] Дорно дахиныг судлах Ленинград хотын салбар хүрээлэнгийн гар бичмэлийн хөмрөг Mong.xyl.C.320,inb.1961, n 757 тэмдэгтэй 20 хуудастай. 1966 онд Ленинград хотод

байх жавшаанд энэ барыг үзсэн бөгөөд 1966 оны намар уг номын гэрэл зургийн хальсыг Азийн улс тумнийг судлах Ленинград хотын салбар хүрээлэнгээс бэлэглэсэн билээ. "Дарь эхийн магтаалын" барласан тухай төгсгөлийн үгийг хойно бүтнээр нь сийрүүлбэл:

[illegible]

Энэхүү төгсгөлийн үгнээс үзвэл өглөгийн эзний хатан Содномдулма хэвт сийлүүл гэсэн зарлигаар урд Рабжамба Зая хутагтын гэгээн хервүүлснээс хойш бичээч тэргүүтэн эндүүрсэн бүгдийг эх бичгүүдтэй тулган шүүгээд хэвт даруулсан гэсэн мэдээ байна. Тэгээд өглөгийн эзэн хан хатан улс

бүгдийн санасан хэрэг улам түргэн бүтэхийг ерөөсөн байна.

I0. [illegible] Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгийн 937/5/ -р тэмдэгтэй ганц хувь, I2 хуудастай. Дан хар бэхээр барласан. Барын хүрээ 22,3 х 8,4 см. Барласан тухай төгсгөлийн үг байхгүй.

II. [illegible] Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгийн 938/I/-р тэмдэгтэй. Ганц хувь, 5 хуудастай. Дан хар бэхээр барласан, барын хүрээ, 22,I х 6,8 см. Барласан тухай төгсгөлийн үг байхгүй.

I2. Тарни. Сийлсэн мод нь Увс аймгийн орон нутаг судлах музейд буй. Модноос буулгасан дардас нь хэл зохиолын хүрээлэнд буй. Барын хүрээ 38,5 х 5,7 см.

I3. Номын хөнжил. Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөг I068-р тэмдэгтэй. Ганц хувь. Барын хүрээ. I03,5 х 62 см.

I4. [illegible] 55 х I0 см. хэмжээтэй, 40 хуудастай гар бичмэл тус хүрээлэнгийн тод монгол номын хөмрөгийн 637 /46/-р тэмдэгтэй. Энэ номын орчуулсан хийгээд барласан тухай төгсгөлийн үг нэг учраас бүгдийг хойно сийрүүлье:

[illegible]

Төгсгөлийн үгнээс үзвэл энэ номыг Шаравжамц гэдэг хүн Галданцэрэн хааны зарлигаар орчуулсан байна. Тэгэхдээ Рабжамба хутагт буюу Зая бандид болон Мэргэн лам хоёрын хөрвүүлснийг дагаж модон хулгана жил орчуулж барт сийлсэн тухай мэдээ байна. Модон хулгана жил гэдэг нь I744 онтой тохирч байна.

Зүүн гар, халимагт хэдий үеэс эхлэн тод монгол ном барласан болохыг тодорхойлоход хэцүү боловч олдсон барын ном, тэдгээрийн төгсгөлийн үгнээс үзвэл ихэнх номыг Галданцэрэн хааны үед барласан байна.Дээрх үед тод монгол номыг гараар дам дам хуулан авч байсан байж болох юм. Ингэж гараар хуулан авч байсны баримтыг Зая бандидын намтраас олж болно. Зая бандидын намтарт: "Тэр намар ч Сэнгээ урьд хутагтын гэгээн сэрүүн цагт таны орчуулсан номыг цөм салгаж авсу хэмээн ам авснаа санаж, луу жилийн /I664 он/ намар хэлмэрчийг бичээчтэй залж хэлмэрчээр Галсан, орчуулган бичээч Гэлэн, хурдан бичээч тэргүүтэн есөн бичээчээр бичүүлэв"[I76] гэжээ.

Нөгөө талаар Галданцэрэн хааны үед барласан "Найман мянгат", "Таслагч очир", "Алтан гэрлийн" төгсгөлийн үгэнд "Равжамба хутагтын гэгээн хөрвүүлснээс завсарт бичээч тэргүүтний эрхээр үлэгсэн тасрагсан эндүүрэгсэн бүгдийг" эх бичиг, тайлбар зэрэгтэй тулган шүүж барласан гэж байна. Мөн тэр үед барласан болов уу гэж үзэж байгаа "Дарь эхийн" магтаалд "Рабжамба Зая хутагтын гэгээн ариун хөрвүүлснээс завсарт бичээч тэргүүтний эрхээр эндүүрсэн бүгдийг зассан"гэж байна.

Үүгээр үзвэл Галданцэрэн хаанаас өмнө Ойрдод номыг гагцхүү бичээч нар гараар сийрүүлэн бичсээр ирснийг нягтлан шүүж гэдгийг тодорхойлон дурдаж байгаа бололтой.

Ойрдод тод монголоор барласан ном угаас цөөн болохоос гадна бидэнд уламжлагдаж ирсэн нь бүр цөөн тэдий боловч Монголын соёлын үнэт өв болон үлдэх юм.

Дөрөвдүгээр бүлэг

ОЙРДЫН ЗАЯ БАНДИД БОЛОН ТҮҮНИЙ ШАВЬ НАРЫН ОРЧУУЛГА

"Сарны гэрэлд" Зая бандидын өөрийн нь орчуулсан I77 ном, гурван шавийн нь нэмж орчуулсан 37 номын нэр байгааг бид сайн мэднэ[I77]. Гэвч тэдгээр орчуулгаас одоо бидний үе хүртэл хэд нь хадгалагдаж ирсэн, хэдийд хэн хэний дурдсанаар Зая бандид орчуулсан бэ, хэн хэн гэгч хүмүүс Зая бандидын хамт ажиллаж байв гэдэг асуудлыг тайлах явдал бол зөвхөн Зая бандидын намтрын бүдэг бүдэгхэг хэсгийг тодруулах тэдийгөөр зогсохгүй, ХҮП зууны үеийн Дөрвөн ойрдын түүхийн зарим баримтыг аль нэгэн хэмжээгээр сэлбэхэд нэмэр болох юм.

I. Зая бандидын орчуулга

Зая бандидын намтар "Сарны гэрэлд" барс жилээс барс жилийн хооронд буюу I650-I662 оны хооронд орчуулсан номын нэрсийг дурдсан байна. Үүгээр баримт болгон Зая бандид ном орчуулах ажлаа I650 оноос эхэлсэн гэж үзэж болохгүй юм. Учир нь зарим номын төгсгөлийн үгнээс үзэхэд I650 оноос өмнө, тод үсэг зохиохоос ч өмнө орчуулсан лавтай баримт гарч байна.

"Банчин хутагтын тууж" гэдэг номын төгсгөлийн үгэнд :



бичсэн гэжээ[178].

Энэхүү төгсгөлийн үгэнд бичсэн зүйлийг баримтлан уг номыг орчуулсан он цагийг тогтож болохоор байна. Хангай хаанд байхад буюу Засагт ханы нутагт явж байхдаа уг номыг дунд нь ортол орчуулж, Харийн нуур, Зоргол хайрханы өмнө байхдаа буюу Түшээт хааны өргөөнд байхдаа номынхоо орчуулгыг үргэлжлүүлэн, Цэцэн ханы өргөөний гадна байхдаа мөн номыг орчуулж дуусгасан тухай дурдаж байна. Зая бандид, Засагт хан, Түшээт хаан, Цэцэн ханд залагдан яваад буцсан он бол 1642 онтой тохирч байгаа учраас "Банчин хутагтын тууж" гэдэг номыг 1642 он буюу тод үсэг зохиохоос 6 жилийн өмнө орчуулсан байна.

"Эцгийн номын" төгсгөлийн үгэнд :



гэжээ[179].

Усан хонин жил бол Зая бандидын амьд ахуй хугацаанд ганц удаа тохиолдож байгаа нь 1643 онтой тохирч байна.

"Маань гамбүмийн " төгсгөлийн үгэнд:



гэжээ[180].

Усан хонин жил 1643 онтой тохирч байгаа учраас он дамжуулан 1643-1644 онд Маань гамбүмийг орчуулсан байна.

Ингэхлээр бид Зая бандидын орчуулга хийж эхэлсэн үе бол 1650 он бус 1642 оноос эхэлсэн гэж үзэх бүрэн үндэстэй байна. Зая бандид нь 1661 оны намраас хойш ном орчуулаагүй болов уу гэж бодогдмоор баримт "Сарны гэрэлд" гарч байна. 1661 оны намар Баатар хун тайжийн хүү Сэнгэ, хатан Цэвээнжалмуу хоёр " Бадмасамбоваагийн туужийг" орчуулж өгнө үү гэж элч заран хадаг морь илгээсэнд Зая бандид татгалзан нэгдүгээрт, өвчтэй, хоёрдугаарт нас өндөр болж үхэх ойртож байгаа учир бясалгал үйлдье гэж хэлээд тэр хоёрын хүсэлтийг хүлээж аваагүй[181] байна.

Ийм учраас Зая бандидын ном орчуулсан хугацааг "Сарны гэрэлд" барс жилээс барс жил хүртэл буюу 1650-1662 оны хооронд гэж дурдаж байгаад шүүмжлэлтэй хандах хэрэгтэй юм.

Гадаад дотоодын номын хөмрөгүүдээс Зая бандидын орчуулга хэд байгааг шүүн үзвэл 60 гаруй байна. Эдгээр номын нэрийг хойно жагсаавал:

№	номын нэр	хаа хадгалагдаж буй	
1	[illegible]	Улаанбаатар хотод 3	Л27.
2	Pañcarakṣā	мөн 4	
3	[illegible]	мөн 5	Q246
4	[illegible]	мөн 6 (illegible) →	Q1.
5	[illegible]	мөн	B132(1)
6	[illegible]	мөн 9	
7	[illegible]	мөн 10	B63

номера по списку Ратнайхадры

8	[illegible]	МӨН	11
9	[illegible]	МӨН	8
I0	[illegible]	МӨН	12
II	[illegible]	МӨН	14
I2	[illegible]	МӨН	15
I3	[illegible]	МӨН	16
I4	[illegible]	МӨН	18
I5	[illegible]	МӨН	19
I6	[illegible]	МӨН	23
I7	[illegible]	МӨН	74
I8	[illegible]	МӨН	24
I9	[illegible]	МӨН	25
20	[illegible]	МӨН	27
2I	Таван төрөл [illegible]	МӨН	30-34
22	[illegible]	МӨН	40
23	[illegible]	МӨН	41
24	[illegible]	МӨН	42
25	[illegible]	МӨН	43
26	[illegible]	МӨН	44
27	[illegible]	МӨН	45
28	[illegible]	МӨН	46
29	[illegible]	МӨН	48
30	[illegible]	МӨН	50

3I	[illegible]	МӨН	54
32	[illegible]	МӨН	57
33	[illegible]	МӨН	87
34	[illegible]	МӨН	88
35	[illegible]	МӨН	89
36	[illegible]	МӨН	89
37	[illegible]	МӨН	120
38	[illegible]	МӨН	97
39	[illegible]	МӨН	63
40	[illegible]	МӨН	178
4I	[illegible]	МӨН ученики	22
42	[illegible]	МӨН ученики	28
43	[illegible]	МӨН	
44	[illegible]	МӨН	38
45	[illegible]	МӨН	13
46	[illegible]	МӨН	124
47	[illegible]	МӨН	58
48	[illegible]	МӨН	184
49	[illegible]	МӨН	51
50	[illegible]	МӨН	
5I	[illegible]	МӨН	56
52	[illegible]	МӨН	47
53	[illegible]	Ленинградад	70
54	[illegible]	МӨН	122
55	[illegible]	МӨН	17

56	[illegible]	мөн	
57	[illegible]	мөн	
58	[illegible]	мөн	80
59	[illegible]	мөн	
60	[illegible]	мөн	53
61	[illegible]	мөн	123
62	[illegible]	мөн	114
63	[illegible]	мөн	107
64	[illegible]	мөн	125
65	[illegible]	Улаанбаатарт	67

2.Зая бандидад ном орчуулахыг дурдагсад

Халх дөрвөн ойрдод шарын шашин дэлгэрүүлж эхлэсэн Зая бандидын ажил үйлс нь тийм ч амар хялбар бүтээгүй байна. Зая бандидын хамгийн сүрхий дайсан бол эрт дээр цагаас монголчуудын шүтэж ирсэн бөө мөргөл байв. Тэрхүү бөө мөргөлөөс эгэл жирийн хүмүүс тийм ч амар салахгүй зуурал-дсаар байжээ. Бөө мөргөлийг I640 оны хуулиар хязгаарлаж алив онго тахигсад, бөө удган залагсдыг малаар торгох болсон байна. "Хэн үзсэн хүн онгод тахигсдын нь онгодыг түлэн морь хонийг ав. Бөө удганыг удгалуулагчнуудаас морь аваад бөө удганы нохойн баасаар ут хэмээн тунхаг тарааж хамаг бүг дийг цагаан зүгт ..."[I82] Зая бандидыг зүглүүлсэн гэж намтарт нь дурдсан байна.

Гэвч Зая бандидын үйлст шамдан туслаж байсан ойрд, халхын ихэс ноёд, хатад, лам нар цөөнгүй

байжээ. Бурхны алив хөлгөн судар ном зохиол орчуулуулахыг хүсэгчид нь Халх, Ойрдод шарын шашин дэлгэрүүлэхэд эд бариц, үзэл санааны гүн туслалцаа үзүүлж байсан хүмүүс гэж үзэж болно.

Зая бандидаас ном орчуулуулахыг хүсэж байсан хүмүүсийн нэрсийг хойно жагсаавал:

орчуулгын дугаар	Ном орчуулуулахыг дурдсан хүмүүс
I	Ачит цорж, Чагнаадорж
2	Чагнаадорж
3	Ахлай Алдар
4	Кишкив, Цэвээн цэцэн тайж
5	Дарь эх тэргүүтэн олны дурдсанд
6	Хөндлөн Увшийн 6-р хүү Батмөнх тайж
7	Ачит цорж
8	Дарь Увшинз
9	Намуцэрэн
I0	Ахлай Алдар
II	Ахай Увшинз Ролмажамц
I2	Жодва
I3	Тайш
I4	Тарзан банди
I5	Ахай Чүүкэр
I6	Жодва
I7	Очирт тайж,Тайш ахай,Жодва
I8	Сэртүг, Ачит цорж
I9	Гомбо ноён өөд болсонд Ламжав Увшинз
20	Хөндлөн Увшийн 6-р хүү Батмөнх тайж, Ойрдын тэгс хувьтан олны дурсгалд
2I	Эрхчүүдийн хувьтан дурдсанд

22	Эзэн ахай засагт номын хан
23	Өөрийн шавь Намхайринчен , Мэргэн оточ өөлд?
24	Ачид цорж тэргүүтэн дурдсанд
25	Тайш ахай
26	Алдар бичээч Омбо
27	Далай дархан цорж
28	Чагнаадорж
29	Далай тайшийн 5-р хүү Гомбо ноён
30	Ачит цорж, Очирт тайж, Тайш ахай
31	Намхайринчен
32	Шарав гэлэн
33	Сэнгэ
34	Ачит цорж
35	Авлай Баатар
36	Авлай Баатар
37	Ачит цорж
38	Эрхчүүд гэлэн Данзанжамц, тайж Омбо, Аюуш тэргүүтэн олны дурдсанд
39	Жодва
40	Дархан цорж
41	
42	Лоорой гэлэн
43	?
44	Алдар зайсан
45	Ахай Чүүкэр
46	Аюуш
47	Ойрд Дамба Онбо
48	Рабжамба Содва
49	Очирт тайж
50	Сономсо, Дайчин

51	Ахай Чүүкэр
52	Үкэрэй баатар тайж
53	Марза Эрдэнэ хиа
54	Даржаа гавж
55	Хонжин лам
56	Олны дурдсанд
57	Сонин уран бичээч Үйзэн
58	Дархан цорж
59	Цэцэн хун тайж
60	Дэмч Гунгаашарав
61	Аюуш
62	Данзансамбуу
63	Бодисуг хатан
64	Очирт тайж
65	Аюуш

Дээр дурдсан хүмүүсээс хамгийн олон ном орчуулуулахыг хүссэн хүн бол Ачит цорж байна.

3.Дурдагсадыг түүхийн сурвалж бичгээс хайсан нь

Зая бандидаас ном орчуулуулахыг хүсэгчид нь Зүүн гар улсын түүхэнд хир зэргийн үүрэг гүйцэтгэж байсан хүмүүс вэ гэдгийг гарын доор буй түүхийн сурвалж бичгээс хайж тодорхойлохыг оролдъё.

1. Ачит цорж. Энэ хүн 1,7,18, 24,30,34,37-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэхүү Ачит цорж гэгч хүн Зая бандидтай ойр дотно байсан хүн болох нь "Сарны гэрлээс " тодорхой мэдэгдэж байна. "Тэр өвөл /1652/ Цэцэн хан, Бурдыг оруулж ирэв. Тэр явдалд Галдамба ч арван долоотойдоо Янгир хааныг чичсэн ажээ. Эхийн тухай / Цэцэн ханы эх Гүнж хатан, Л-Б/ зуун хөвгүүн цуглуулснаас тавин хөвгүүнийг нь хутагтад / Зая

бандидад, Л-Б/ банди болгов. Бусдыг нь Ачит цорж тэргүүтэн бус ламд өгөв"[183] гэжээ.

" Ер лам барьсан их лам нар олон буй боловч ламд үнэн сүжгээр тэгссэн бөгөөд ламын номын үйлийг дэлгэрүүлэгч нь Ачит цорж мөн болно"[184] гэжээ.

2. Ахлай алдар буюу Алдар зайсан.Энэ хүн 3, 10, 44-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна.

Энд дурдаж байгаа Ахлай алдар буюу Алдар зайсан нь Зүүн гарын түүхэнд гардаг Алдар тайж гэдэг хүн мэн болов уу гэж таамаглаж байна.1655 онд Зая бандидыг " Алдар тайж залж их сүжиглэн хүндлэхүйн үүднээс ном ч олныг буулгаж аван сүжиглэн тахихын тул гэгээний хувцасыг бүрнээ авч, 300 адуу, 30 тэмээ ергөн, ахуй их сүжиглэн үйлдэв"[185] гэжээ. Үүгээр үзвэл бичиг үсэгтэй боловсронгуй хүн байсан бололтой.

3. Кишкив, Цэвээн цэцэн тайж. Энэ хоёр хүн 4-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүсчээ. Энэхүү Кишкив Цэвээн цэцэн тайж хоёрын тухай товч боловч мэдээ "Сарны гэрлээс"олдож байна. "Хүрээг Кишкив, Цагаан цэцэн тайж /Цэвээн цэцэн тайж/гурван хүүхэд залж Ураг Мунцаг гэдэг газар өвөлжив"[186] гэжээ. Кишкив, Цэвээн цэцэн тайж хоёр Зая бандидыг залсан оныг хөөн үзвэл 1654 онтой тохирч байна.

4. Даръ увшинз буюу Даръ эх. Энэ хүн 5,8-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Даръ увшинз, Даръ эх хоёр нэг хүн бололтой. Даръ увшинз бол Хоо өрлөгийн охин, Эрдэнэ баатар хүн тайжийн хатан юм. Эрдэнэ баатар хүн

тайж Даръ увшинзаас гадна 8 эхнэртэй байсан байна. Оросын архивын баримт бичигт "Даръ убасалча" гэж тэмдэглэсэн байна[187].

1643 онд оросын элч Ильич гэгч Эрдэнэ баатар хүн тайжийн өргөөнд очиход Эрдэнэ баатар хүн тайж өөрөө байсангүй, Киргиз, Хасагийн эсрэг аян дайнд мордсон байжээ. Гэвч түүний их хатан Хоо өрлөгийн охин Дара-Уба-Залча оросын элчийн бэлгийг хүлээн авсан гэж Сибирийн түүхийг бичсэн Фишер дурдсан[188] байна. Энэ хатны нэрийг бас Юм Агас гэдэг. Эхлээд Хошуудын Цүүкэрийн хүү Эрдэнэд өгсөн боловч хожим нь Эрдэнэ баатар хүн тайжтай суужээ. Юм Агас хатан 1687 онд нас баржээ[189].

5. Батмөнх тайж. Энэ хүн 6,20-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энд дурдаж байгаа Батмөнх тайжийн тухай тодорхой мэдээ олдохгүй байна. Үг орчуулгын тегсгөлийн үгэнд Хөндлөн увшийн 6-р хүү гэсэн байна. Тэрхүү Хөндлөн увшийг Ахай хатны таван барсын нэг Хөндлөн Увш буюу Хөндлөн Дүүрэгч байж магадгүй гэж таамаглахаас өөр зүйлгүй. Хөндлөн Увш буюу Хөндлөн Дүүрэгч 16 хүүтэй байсны 6-р нь Гэвж ноён, 7-р нь Мөнх гэдэг нэртэй байсан тухай " Илтгэл шашдирт" дурдаж [illegible] байна. Увш Түмэний бичсэн " Дөрвөн ойрдын түүхэд" Дүүрэгч Увш буюу Хөндлөн Дүүрэгчийн хөвгүүдийг тоочсон байна. Үүнд Колебе Далай Увш, Увш хун тайж, Дорж Эрх дайчин зэрэг хөвгүүд байсан тухай дурдаж[191] байна.

6. Намуцэрэн. Энэ хүн 9-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энд нэр гарсан Намуцэрэнгийн эцэг бол Хоо өрлөгийн хүү Шүхэр дайчин юм. Энэхүү Шүхэр дайчингийн 3-р хүү бол Намуцэрэн

мөн. Намуцэрэн, Зая бандид хоёр ойр дотно явсан хүмүүс бололтой. 1655 онд Зая бандидыг их бага ноёд дараалан залж байсан тухай "Сарны гэрэлд" дурдаж байна. Тэрхүү их ноёдын тоонд Намуцэрэн орж байна. " Түүнээс аван Зай хүртэл Огжодба, Мэргэн тайж тэргүүтэн, Гомбо Илдэний хөвгүүд, Санжин, Намуцэрэн тэргүүтэн их ноёд хийгээд Шарав Омбо, Цэрид, Цолом тайж тэргүүтэн өчүүхэн ноёд тасралтгүй залж цай цав тэргүүтэн бариц их багын зэргээр ахуй их үйлдэн, энэ хойдын цагаан буяны хөрөнгийг цацав"[192] гэж бичсэн байна.

7. Ахай увшинз Ролмажамц. Энэ хүн II-р ном орчуулахыг Зая бандидаас хүссэн байна. Ахай увшинз Ролмажамц буюу Дулмажамц гэдэг хүний тухай гарын доор буй хэрэглэгдэхүүнээс мэдээ олдсонгүй. Гэвч Хань ноён Хонгорын их хатан "Таван барын" эх Ахай хатан мөн байж ч болох юм.Хэрэв энэ тааманглал зөв болох аваас Ахай хатны "Таван барс"[193] буюу таван хүүгийн ахмад нь Байвгас баатар, түүний өргөмөл хүү Зая бандид учраас ураг төрлийн холбоотой болох юм.

8. Жодва. Энэ хүн I2,I7,39-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэхүү Жодовын тухай тодорхой мэдээ бидэнд олдохгүй байна. Харин Хөх нуурын Жодва баатар байж магадгүй. Жодва баатар бол Эрдэнэ баатар хүн тайжийн хүү, Сэвданжалын эцэг болох хүн.

9. Тайш ахай. Энэ хүн I3,17,16,30-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэхүү Тайш ахай гэгч чухам ямар хүний хатан болохыг тодорхойлж чадсангүй. Энэ хатан I644 оны хавар нас барсан тухай Сарны гэрэлд бичиж байна. Үүнд:

"... Хааны хатан Тайш Биж хэмээх газар нас нөгцөөнд тэр тухай ерөөл аван гэгээнийг залахаар Бодидар өрлөг Бэчин жилийн / I644/ өвлийн сүүл хоринд хүрч ирэв"[194] гэж дурдсан байна.

I0. Тарзан банди. Энэ хүн I4-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэхүү Тарзан бандийн тухай тодий л тодорхой бус мэдээ орчуулсан зарим номын төгсгөлийн үгнээс олдож байна. Жишээлэхэд Сундуйн судрыг үргэлжлүүлэн орчуулахад энэ хүн оролцож байжээ. Сундуйн төгсгөлийн үгэнд "хоёр хэлт Тарзан гэлэн" гэж бичиж байгаагаар үзэхэд сайн орчуулагч байсан байна. Бас "Эрдэнийн сан Сувашидын " тайлбарыг орчуулсан байна.

II. Ахай Чүүкэр. Энэ хүн I5,45,5I-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэхүү Ахай Чүүкэр буюу Чүүкэр Увш бол Дөрвөн ойрдын түүхэнд гардаг нэртэй хүний нэг юм. Чүүкэр хошуудын хүн, Эрдэнийн эцэг[195] Ахай Чүүкэр буюу Чүүкэр Увшийн тухай мэдээг "Сарны гэрлээс" шүүн үзвэл: I65I онд Хөх нуурт байж байгаад Зая бандидын хамт Барибүн хийдэд очиж байжээ. I662 оны хавар Чүүкэр увш Төмөр цорго гэдэг газар хаваржиж байсан байна. I664 онд хошуудын Цэцэн ханы хатан Пунцагдулма, хүү Галдамбаагийн хамт Чүүкэр Увшийнд зочлон очиж байжээ. I676 онд хошуудын Цэцэн ханы талд явж Галдан бошигтод цохигдсон[196] байна.

I2. Очирт тайж. Энэ хүн I7,30, 49,64-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Очирт тайж бол хошуудын хүн. Байвгас баатар хэд хэдэн хатантай байсан бөгөөд түүний их хатан Гүнжээс төрсөн хүү бол Очирт тайж болно. Очирт тайж чухам

хэдэн онд төрсөн нь тодорхойгүй боловч Г.С.Лыткин 1605-1614 оны хооронд төрсөн болов уу гэж бичсэн байна.

Очирт тайжийн үйл явдлыг "Сарны гэрлээс" хөөн үзвэл: 1639 оны өвөл Тарвагатайн Харвагайд өвөлжиж байхад Зая бандид Төвдөөс ирж тэнд өвөлжиж байжээ. 1640 оны " Их цаазыг" тогтооход оролцож байсан байна. 1642 онд Очирт тайжийнх Бугас гэдэг газар өвөлжиж байжээ. 1644 онд Лавшийн Хар тал тийш нүүсэн байна. 1646 онд Дөрвөд, Хөндлөн Увш,хоёр тайжид / Цэцэн хан, Баатар хун тайж/ цэрэглэв. 1647 онд Очирт тайж, Илийн Талгарт өвөлжиж байжээ. 1647 онд Очирт тайж Зая бандидтай уулзаад дараа нь Төвдөд явахаар шийдвэрлэсэн байна. 1650 онд Очирт тайж, дархан Эрдэнэ хун тайж гэгчтэй уулзаж дотно бололцсон байна. 1652 онд Очирт тайж Хар тал гэдэг газар өвөлжиж байв. Энэ жил Очирт тайжийн эх Гүнж хатан нас барсан байна. Мөн онд Очирт тайж Бурдыг оруулж авсан байна. Энэ үед хүү Галдамба нь 17 насанд хүрсэн байна.1653 онд тэр Төвдөд яваад 1655 онд тэндээс буцаж ирсэн байна. 1657 онд Зүүн гар, баруун, зүүн хоёр хэсэг болж баруун талыг Очирт тайж тэргүүлж, зүүн талыг Авлай тэргүүлж байжээ.1658 онд Зая бандид Очирт тайжийнд ирэхэд Очирт тайжийн хатан Цунцагролма зуур хоногийн газар, тайж өөрөө удийн газар угтаж авч байсан байна. 1660 оны намар Боом гэдэг газар Очирт тайж, Авлай хоёрыг эвлэрүүлэхийг оролдсон боловч бүтэмжгүй болсон байна. 1661 оны өвөл Очирт тайж Хайрт голыг гатлаж нүүгээд мөн оны зуны тэргүүн сарын 3-нд Очирт тайж, Авлай хоёр тулж Авлайг ялсан байна. 1665 оны өвөл Очирт тайж Хөх усан

гэдэг газраас Төвдөд явсан байна. 1666 онд Очирт тайжид Далай лам Цэцэн хан гэдэг цол олгож байжээ.Мөн онд нутагтаа буцаж иржээ. 1667 онд Цэцэн ханы хүү Галдамба нас барсан байна. 1671 онд Цэцэн хан Дайчин Дүүрэгч, Дорж Дайчин нарыг оруулж авсан байна. 1675 онд Цэцэн хан Галдан бошигтод цэрэг мордуулав. Мөн онд Цэцэн хан Хар Борхиног хэмээх газар өвөлжсөн байна. 1676 оны эхээр Галдан бошигтын цэргээс Цэцэн хан завдан зугтан гарсан байна. Мөн онд Цэцэн хан өвчтэй байсан байна. 1676 оны өвөл Цэцэн ханы өргөө Эрчист өвөлжив. Тэр оны өвлийн дунд сард Шар бул гэдэг газраас Цэцэн ханыг Галдан бошигт олзлон авсан байна. 1680 оны өвөл Бор талд Цэцэн хан нас барсан байна[197].

13. Сэртүг. Энэ хүн 18-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэхүү дурдсан Сэртүгийн тухай мэдээ сурвалж бичигт маш ховор тохиолдож байна. 1657 оны өвлийн тэргүүн сард Авлайн сүмийг амилуулахад "Хутагтын гэгээн, Даян цорж, Сэртүг цорж /Ачит цоржийн нэр биш байгаа?/ тэргүүтэн мянга дүүрэн хуврагууд"[198] байсан тухай "Сарны гэрэлд" дурдсан байна.

14. Гомбо ноён. Энэ хүнийг нас барсанд зориулж 19-р номыг Зая бандид орчуулжээ. Энд дурдаж байгаа Далай тайш, түүний хүү Гомбо ноён нар бол Ойрдын түүхэнд гардаг нэртэй хүмүүс юм. Далай тайш бол Дөрвөдийн хүн. Далай тайшийг түүхэнд "Баатар тайш", "Далай баатар" гэж нэрлэх нь буй. "Дөрвөдийн өвөг нэр Борнагал, Зүүн гарын өвөг Исэмүн дархан ноёнд ах дүү болно. Борнагалын хүү Эшингэй тайжаас гурван үе уламжилж Далай тайшид хүрч ирээд долоон хүү төрөв"[199] гэж илтгэл шас-

дирт бичжээ. Далай тайшийн долоон хүүгийн ахмад нь Минжүү, 2-р нь Чойн, 3-р нь Тойн, 4-р нь Омбо, 5-р нь Гомбо, 6-р нь Даян тайш, 7-р нь Торхон /Дорхон ?/ тайш эдгээр болно[200].

Гомбо ноён чухам хэдэн онд төрснийг магадлах баримт бидэнд олдсонгүй. Харин 1655 оны хавар нас барсан байна. Энэ тухай "Сарны гэрэлд" бичсэн нь "Тэр хавар Дөрвөд Гомбо ноён нас нөгцсөнд хүрээг залж ерөөл буян номыг ахуй их үйлдсэнд дээд номын рашаанаар ханган үйлдэв"[201] гэжээ.

15. Эрхчүүдийн хувьтан. Энэ бүлэг хүмүүс 21-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. гэж бичжээ. "Эрхчүүд" гэдэг үгийг зарим эрдэмтэд дөрвөлжин бичгийн дурсгалын зүйлд байдаг " erke'ud " гэдэг үгтэй холбож байна. Тод үсгийн ном орчуулуулахыг хүсэгчдийн дотор "Эрхчүүд гэлэн Данзанжамц" гэдэг хүний нэр тохиолдож байна. Бас "Маань гамбум" гэдэг номын төгсгөлийн үгэнд "Эрхчүүдийн равжамба цорж Зая бандид орчуулсан" гэж байна. Зая бандидын яс нь хошууд,отог нь гөрөөчин, гөрөөчний дотор Шангас гэж өөрийн намтарт тодорхой байдгийг бид сайн мэднэ[202]. Ийм учраас "Эрхчүүд" гэдэг үг овог уу, эсвэл дээдэс, язгуур-тан гэсэн утгатай үг үү гэдгийг нягтлан үзүүштэй.

16. Ахай Засагт номын хан. Энэ хүн 22-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Ахай Засагт номын хан бол Гэрсэнз Жалайр хүн тайжийн угсааны хүн. Гэрсэнзийн ахмад хүү Ашихай, түүний хүү Лайхур, түүний хүү Сувади. Энэхүү Сувадийн үед "Засагт хан" хэмээн өргөмжилжээ. Энд дурдсан Ахай Засагт номын хан бол Сувади мөн. Сувади бол 1640 оны "Их цааз" зохиоход оролцож байсан байна.

Засагт хан, Зая бандидад элч илгээн залсанд Халхын Засагт ханаас Түшээт хаан, Цэцэн хан залж 1641-1642 оны үед явсан байна. Тэгээд Засагт хан, Зая бандидыг "Хоёр гурван жил манай дээр суу" гэсэнд татгалзаж Ойрд нутагтаа буцсан байна. Засагт хан 1642 онд "Эцгийн ном Пачойг орчуулж хайрла" гэж бичээч Нанс гэдэг хүнийг дагуулж бараа болгон явуулсан байна[203]. Тэгээд Зая бандид, Засагт ханы хүссэн ёсоор 1643 оны 6-р сард Эцгийн номыг орчуулж дуусгасан байна. Зая бандид тод үсгийг зохиохоос 5 жилийн өмнө орчуулж монголоор бичсэнийг хожим тод үсгээр буулгасан байна.

17. Намхайринчен, Мэргэн оточ. Энэ хоёр хүн 23, 31-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэ хоёрын тухай сурвалж бичгүүдэд ямар ч мэдээ олдохгүй байна. Харин энэ номын төвд орчуулга, буриад барын төгсгөлийн үгэнд цорж Намхайринчен гэсэн байна. Зураач Намхайринчен, цорж Намхайринчен хоёрын аль нь зөв болохыг одоогоор тодорхойлж чадахгүй байна.

18. Алдар бичээч, Омбо. Энэ хоёр хүн 26-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Алдар бичээч, Омбын тухай тодорхой мэдээ бидэнд олдохгүй байна. Ер нь Зая бандидын дэргэд байсан шилдэг бичээч мөн бололтой. 1643-1644 онд "Маань гамбумийг" Зая бандид орчуулахад Алдар бичээч, Омбо нар үнэсэн самбарт буулган авч байснаар үзэхэд тэр үед л лав байсан хүмүүс байна.Түүнээс гадна Алдар бичээч, Омбо нар "Мялын тууж", "Банзрагч", "Үлгэрийн далай" зэрэг номыг үнэсэн самбар болон цаасанд бичиж байжээ.

19. Далай дархан цорж. Энэ хүн 27,40,58-р

ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Далай дархан цорж буюу Дархан цоржийн тухай мэдээ гарын доор байгаа хэрэглэгдэхүүнд тедий л элбэг тохиолдохгүй байна. Юу ч гэсэн Зая бандидтай ойр дотно байсан, бас ч Эрчист тусгаар сүмтэй байсан хүн юм. Энэ тухай бичсэн зүйлийг "Сарны гэрлээс" сийрүүлбэл: "Тэр бичин жилийн /1644/ зун Очирт тайжийнд /Зая бандид Л-Б/ өөд болон зуссанд, тэнд Эрчисийн сүмд Дархан цорж залав. Хог-сали Бахнагаас хайдагаар Очирт тайжийн Лавшийн хар тал тийш нүүв. Хүрээ Дархан цоржийн сүмд тэнд өөд болж тэнд өвөлжив"[204] гэжээ.

20. Шарав гэлэн. Энэ хүн 32-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Шарав гэлэнгийн тухай "Сарны гэрэлд" хоёр ч мэдээ буй. 1689 онд Ноён гэлэн гэдэг хүн 58 хүнийг алсан тухай "Сарны гэрэлд" өгүүлжээ. Үүний дотор Шарав гэлэн орсон байна. Ингэхлээр Шарав гэлэнг 1689 онд алагдсан болов уу гэж үзэж болмоор байна.Хэдэн том лам нар нийлж олон хүнийг алсан тухай эхлээд Ноён гэлэнд, дараа нь ханд өргөсөн хоёр бичгийн эхэд Шарав гэлэнгийн тухай дурдсан байна. "Шарав гэлэнгийн амийг алах юу вэ?" "Энэ Ноён гэлэн зөвтэй, зөвгүй, Шарав гэлэн, Тарва гавж хоёр гэцэл чавганц, банди хүүхэд, найж нар / хүүхнүүд. Л-Б/ тэргүүлэн тавин найман хүнийг алав"[205] гэжээ.

21. Сэнгэ. Энэ хүн 33-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Сэнгэ ноён бол Баатар хун тайжийн тавдугаар хүү бөгөөд Сэнгийн дүү буюу Баатар хун тайжийн 6-р хүү бол Галдан бошигт мөн. Баатар хун тайж 1634-1643 онд Зүүн гар улсын хаан ширээнд сууж байгаад нас барсны дараа Сэнгэ хаан ширээнд суугаад удаагүй байтал ах нартаа хорлогджээ. Энэ явдлыг дүү Галдан мэдмэгц Төвдөөс Зүүн

гарт эргэж ирээд атаатнаа дарж 1671 онд хаан ширээг эзэлжээ. Сэнгэ бол Зая бандидтай их дотно байсан тухай "Сарны гэрэлд" тэмдэглэсэн байна. Сэнгийн эцэг баатар хун тайж нас барсны дараа Зая бандид Сэнгэтэй уулзсан байна. Сэнгэ бол нэгдүгээрт их ноён, хоёрдугаарт сүжигтэй, гуравдугаарт, төрөл садны холбоотой гэж үзээд Зая бандид, Сэнгийг дотночилон хүндэтгэсэн байна. Сэнгэ ч Зая бандидыг хүндлэн орчуулсан номыг бүрнээр нь буулгаж авна гэж амлажээ.

1661 онд хошуудын Цэцэн хан, Авлай хоёр байлдахад Цэцэн ханы талд орж Авлайтай байлдаж байв. Мөн онд Авлайг буулгаж авсны дараагаар Авлайгаас авсан юмыг дутагдуулалгүй цөм бүрэн эргүүлж өгсөн учир Сэнгэ үнэнч гэж нэрд гарчээ. 1661 онд Сэнгэ түүний хатан Цэвээнжалмо хоёр Бадмасамбоагийн туужийг орчуулж өгнө үү гэж Зая бандидаас хүсч хадаг, морь хүргүүлж байжээ. 1662 оны зун Зая бандидыг Төвдөд явах замд Үсэг саамал /Сүү саамал/ гэдэг газар Сэнгэ өргөөндөө урьж тэнд 12 хоног саатуулж ном сонсох лам нарт цав манж барих, хувцас түгээх зэргээр буян үйлдсэн гэж бичжээ. Түүний нөгөө талаар 100 агтыг Зая бандидад өргөж байжээ. 1664 онд Сэнгэ, Зая бандидын орчуулсан номыг буулган авахуулахаар 9 хүнийг явуулж байжээ[206]

22. Авлай баатар. Энэ хүн 35,36-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Авлай баатар хошуудын хүн. Байвгас баатрын хүү. Байвгас баатрын бага хатан Сайхан Чүү хатнаас төржээ. Авлай баатар өөрийн ах Очирт тайж буюу Цэцэн хантай 30 шахам жил тэмцэлдсэн юм. Ах дүү хоёрыг тэдний хүүхдүүд

эвлэрүүлэхийг оролдож байснаас гадна Зая бандид хүртэл түүнд оролцож байжээ. Авлай баатрын үйл явдлыг "Сарны гэрлээс" хөөн үзвэл:

1639 онд Зая бандид Авлайнд очиж байсан байна. 1646 онд дөрвөд Хөндлөн увш, Баатар хун тайж Очирт тайж хоёртой тулалдахаар завдаж байхад Авлай баатар 4000 цэрэгтэй очиж эвлэрүүлж байжээ. Мөн онд Авлай Шар тохойд өвөлжсөн байна. 1648 онд Авлай баатар Зуйд, Зая бандидтай хамт өвөлжиж байв. 1650 онд Зая бандид Авлайнд ирэхэд Авлайн өргөө Хөөргийн голд байжээ. Авлай тэгэхэд хятадтай түмэн агтны худалдаа хийгээд, түүний эд мөнгийг Зая бандид өргөв. 1653 онд Зая бандидын хүрээ Төмөр цорго гэдэг газар Авлайн дээр өвөлжлөө. 1657 онд Зүүн гар хоёр анги болоход зүүн талыг Авлай тэргүүлж байв. 1660 оны намар Боом гэдэг газар Очирт тайж, Авлай хоёр Зая бандидын өмнө уулзсан байна. 1661 онд Авлай, Очирт тайж хоёр тулалдаж Авлай ялагдсан байна. Авлай бүслэлтээс гарч Бөкүүний голд буусан байна. 1668 онд Авлай урагш нүүсэн байна.

1671 онд Авлай дөрвөд Хөндлөн увштай нийлж Даян тайш, торгууд Дайчинг идээд Зайд өвөлжив. Тэнд өвөлжиж байхад Аюк Ижил мөрнөөс цэрэгтэй ирж Авлайн цэргийг дарав. Үүнээс өөр мэдээ "Сарны гэрэлд" байхгүй байна[207].

23. Эрхчүүд гэлэн Данзанжамц, Тойн Омбо, Аюуш. Эдгээр хүмүүс 38-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. 1655 онд дээр дурдсан нэр бүхий хүмүүсээс Тойн Омбо, Аюуш хоёр Зая бандидыг залж байсан тухай мэдээ "Сарны гэрэлд" байгааг хойно сийрүүлбэл: "Тэндээс бас /Зая бандид. Л-Б/ өөд болон, завсарт тойн Омбо, Аюуш ноён хоёр залж бариц

ахуй их үйлдэв"[208] гэжээ.

24. Аюуш. Энэ хүн 46, 61, 65-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Аюушийн тухай тодорхой мэдээ бидэнд олдохгүй байна. 65-р номын төгсгөлийн үгэнд дурдсанаар бол Аюуш Дөрвөдийн хүн бололтой. Бас 1655 онд Аюуш, Зая бандидыг урьж байжээ[209].

25. Сономсо, Дайчин. Энэ хоёр хүн 50-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энд дурдаж байгаа Сономсо бол Пунцагролма /Пунцагдулма/-гийн нэр мөн гэж Г.С.Лыткин бичсэн байна[210]. Сономсо, Пунцагролма Пунцагдулма хоёр, нэг хүний хоёр нэр гэж тааварласан нь зөв ч байж магадгүй. Баатар хун тайжийн охин Пунцагролма бол хошуудын Цэцэн ханы хатан, Галдамбын эх юм. Сономсо буюу Пунцагролмын үйл явдлыг "Сарны гэрлээс" хөөн үзвэл: 1654 онд Хөх усан хар тал гэдэг газраас Галдамба Сономсо /буюу Пунцагролма/ хоёр Дайчинд золгохоор ирж байсан байна. 1658 онд Зая бандид, Цэцэн ханы өргөөнд ирэхэд ханы хатан Пунцагролма тэргүүтэн зуур хоногийн газар угтаж авч байсан байна. 1666 онд Пунцагролма хатан Зая бандидын хойд дүрийг өөр дээрээ авъя гэж хүсэлт тавьж байсан байна.

Нөгөө Дайчин бол Торгуудын Хоо өрлөгийн хүү Шүхэр дайчин юм. Шүхэр дайчин 1640 оны "Их цаазын бичиг" тогтооход оролцож байжээ. Хоо өрлөг 1644 онд нас барсны дараагаар Ижил мөрний Халимагийн ноён болжээ. 1645 онд Зая бандидыг Шүхэр дайчин залж[211] байжээ. 1654 онд торгууд Дайчин, Авлайнд зочилж байжээ. 1655 онд Москвад Дураал, Цэрэн зэрэг элч илгээн оросын Алексей Михайлович хаанд

үнэнч байхаа илэрхийлсэн[212] байна.

26. Үкэрэй баатар тайж. Энэ хүн 52-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Үкэрэй баатар тайжийн үйл явдлыг "Сарны гэрлээс" хөөн үзвэл: 1646 онд Зая бандидыг өргөөндөө залж номын авшиг /эрх/ авч байжээ.1659 онд Үкэрэй дайчинг нас барахад Зая бандид хүрэлцэн очиж хойдохыг нь үйлдэж байжээ. Үкэрэй дайчин лав л хоёр хүүтэй байсан нь мэдэгдэж байна. Нэг хүү Билигт гэлэн гэгч 1662 онд Зая бандидыг өвчтэй хүнд байгаа учрыг Лхасад очиж мэдэгдэхээр элч болж явжээ. Нөгөө хүү Өнчин гэгч 1676 онд хошуудын Цэцэн ханы талд орж Галдан бошигттой байлдаж[213] байжээ.

27.Даржаа гавж. Энэ хүн 54-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энэхүү Даржаа гавжийн тухай бага сага мэдээ "Сарны гэрэлд" байна. Зая бандид 1650 оны намар Хөөргийн голоос Төвдөд явж зам зуур Булингар гэдэг газар өвөлжсөн байна.Тэгэхэд гавж / хожим Райчүн номын хан хэмээх цолтой болсон/ Ойрдыг зорин явж байгаад Булингарт Зая бандидтай учирч тэнд хамт өвөлжсөн байна. "Тэнд Даржаа гавжид, /Зая бандид, Л-Б/ Рабжамба цорж хэмээн цол дуудан өргөж дэвсгэр, түшлэг, жанч, гэр уналга-нуудыг ч хайрлав"[214] гэжээ. Тэгэхлээр Даржаа гавж, "Рабжамб цорж", "Райчүн номын хан" гэдэг хоёр цолтой байна. Зая бандидыг нас барсны дараагаар түүний шавь гурван хүн 37 ширхэг ном орчуулсан жагсаалт "Сарны гэрэлд" байдгийг бид тодорхой мэднэ. Үүний нэг орчуулагч нь Рабжамба цорж буюу Даржаа гавж байсан юм.

28. Хонжин лам. Энэ хүн 55-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Энд дурдаж байгаа

Хонжин ламын тухай тодорхой мэдээ олдохгүй байна. Хошуудын Цэцэн хан Төвдөд явах гэж отог отгоос түмэн агт татаж хятадад худалдахаар 1646 онд туулгаж " Монголын Хонжин ламаар тэргүүлүүлж нэг зуун хүнийг одуулав"[215]гэж "Сарны гэрэлд" дурдсанаас өөр мэдээ олдохгүй байна.

29. Бодисүг хатан. Энэ хатан 63-р ном орчуулж өгөхийг Зая бандидаас хүссэн байна. Бодисүг хатны тухай "Сарны гэрэлд" бичсэн нь Торгууд, Авлайн нагац нар, Буянт Бодисүнгийн хүү /1657 онд Зая бандидыг Л-Б / залж ерөөл аван, ном сонсон их барицнуудыг өргөв[216]гэж байна. Авлайн эхийн талыг хөөн үзвэл, Хоо өрлөгийн хатан юм уу тэдний ойр төрлийн хүмүүс байж магадгүй.

Зая бандидаас ном орчуулж өгөхийг хүсэгчдийн дотроос 1, 2, 28-р ном орчуулж өгөхийг хүссэн Чагнаадорж, 19-р ном орчуулж өгөхийг хүссэн Лоорой, 47-р ном орчуулж өгөхийг хүссэн Омбо, 48-р ном орчуулж өгөхийг хүссэн Рабжамба Содва, 53-р ном орчуулж өгөхийг хүссэн Марза Эрдэнэ хиа, 57-р ном орчуулж өгөхийг хүссэн бичээч Үйзэн, 59-р ном орчуулж өгөхийг хүссэн Цэцэн хун тайж, 60-р ном орчуулж өгөхийг хүссэн Дэмч Гунгаашарав, 62-р ном орчуулж өгөхийг хүссэн Данзансамбуу нарын тухай мэдээг сурвалж бичгээс олсонгүй.

4.Зая бандидын дэргэдийн бичээч нар

Зая бандид богино хугацааны дотор өдий олон ном хэрхэн орчуулсныг бид сонирхон үзэх болно.Зая бандидын дэргэд монгол, тод үсэгт мэрэгжсэн олон сайн бичээч нар ажиллаж байсныг орчуулсан номын

төгсгөлийн үгнээс мэдэж болно.

Зая бандид ном орчуулахдаа төвд эх бичгийг хараад монголоор дуудахад хурдан бичээч тэр доор нь үнэсэн самбарт бичиж авдаг байжээ. Дараа нь бас нэг бичээч цаасанд хуулан бичдэг байсан байна. Жишээ нь "Хутагт их тонилсоны зүгт дэлгэрүүлэгч" гэдэг номын төгсгөлийн үгэнд :



гэжээ.

Зая бандидын орчуулга бүхэнд, үнэсэн самбарт бичсэн хүний нэр, цаасанд бичсэн хүний нэр байдаггүй. Ер нь хэмжээгээр томхон сударт үнэсэн самбар, цаасанд бичсэн хүний нэр заавал байгаа юм. Зая бандидын дэргэд хэн хэн гэгч бичээч байсныг дээр нэр дурдсан 65 номын төгсгөлийн үгнээс бид шүүн үзье.

Орчуулгын дугаар	Үнэсэн самбарт бичсэн	Цаасанд бичсэн
I	Цүлтэмжамц	Далай Омбо
2	Омбо	Ойрдын уран Хонжин
3	Мэргэн гүүш Цүлтэмжамц	Гэндэн-самбуу
4	Раднаабадраа	Гэндэн-самбуу, Чойжамц
I9	Ухаант гүүш Цүлтэмжамц	Омбо

22	Олгонуудын Үйзэн бичээч Дархан Нанс, Ойрдын уран Хонжин	
23	Үйзэн дархан Нанс,Уран Хонжин	
24	Олгонууд отогтой Огторгуйн гэрэл лам, Ойрдын уран Хонжин	
27	Алдар бичээч,Омбо Уран Хонжин	тойн Чойжамц
28	Олгонууд горлос Данзанжамц	Уран Хонжин
30	Олгонууд Огторгуйн Гэрэл увш, Ойрдын уран Хонжин	
3I	Раднаабадраа	Уран Хонжин
36	Цүлтэмжамц	Уран Хонжин
38	Уран Хонжин	Лувсан-жамба
50	Раднаабадраа	Цээ бум
52	Цүлтэмжамц	Алдар бичээч

Дээр дурдсан I6 номыг үнэсэн самбарт болон цаасанд буулган бичигсдийн дотор олонт нэр гарч байгаа хүн бол Цүлтэмжамц, уран Хонжин хоёр байна. Бас эдгээр бичээч нарын дотор ойрдын хүн ч байна. Олгонуудын хүн ч байна. Ийм учраас Зая бандидын дэргэд зөвхөн Дөрвөн ойрдын сайн бичээч нар цугларсан бус, Засагт хан аймгийн Олгонууд хошуудаас хүмүүс байсан нь лавтай байна.

Дээр нэр дурдсан бичээч нараас хожим нь биеэ дааж ном орчуулсан зохиосон нь нилээд байна.

5.Зая бандидын орчуулгын тогтолцоо

Зая бандид өдий олон ном орчуулахдаа гартаа

тохиолдсон элдэв номыг шүүрэн авч орчуулсангүй байна. Зая бандид орчуулга хийж эхэлсэн үеэс нэр томьёо ёгт нэрийн тайлбар зэрэг чухал хэрэгтэй лавлах хэрэглэгдэхүүн гаргажээ. Бидний мэдэж байгаагаар "Ёгт нэр", "Ёгт нэрийн тайлбар" хоёрыг орчуулснаас "Ёгт нэр" буюу [illegible] гэдэг ном бий. Энэ ном Ленинград хот дахь Дорно дахиныг судлах хүрээлэнгийн номын хөмрөгт хадгалагдаж[219] буй. "Егт нэр" гэдэг номыг дотор нь ангилан үзвэл, эхлэлийн үг, ёгт нэрийн жагсаалт, Зая бандидын орчуулсан төгсгөлийн үгээс бүрэлдэнэ.

Эхлэлийн үгэнд яруу найргийг үзэсгэлэнтэй охин лугаа зүйрлүүлж, түүнийг чимэг болон өнгөөр сайхан болговч егт үг хэрэглэхгүй бол тэр охин сохор мэт. Ийм учраас ойр зуурын хэрэгтэй зүйлийг энд дурдана гэжээ.

Ингээд бурхнаас эхлэн эзэн хааныг хүртэл 83 үгийн ёгт нэрийг жагсаажээ. Жишээлэхэд зөвхөн наранд 46 ёгт байна.

Эцэст нь Марза Эрдэнэ хиа гэгч хүн дурдсанаар Зая бандид орчуулсан байна. Зая бандид өөрийн орчуулсан энэ толь бичгийн ёгт нэрийг туштай хэрглэж байсан баримт тодорхой үзэгдэж байна. Жишээлэхэд Зая бандидын орчуулсан Сувашидийн 418-р оадагт:

Сономгараагийн орчуулганд:

Цахар гэвш Лувсанцүлтэмийн орчуулганд:

Энэхүү гурван үеийн орчуулганд төвдийн [illegible] гэдэг үгийг Зая бандид [illegible] гэж орчуулсан байхад Сономгараа, Лувсанцүлтэм нар " [illegible] " гэж орчуулжээ.Зая бандид бол ёгт үгийн дурдсан толь бичигт [illegible] гэснээс нэгдүгээрийг авч орчуулсан байна. Энэ толь бичгийг

баримтлан Зая бандид болон түүний шавь нарын орчуулгыг тогтоож болох юм.

Зая бандид бол бурхны номыг нийтэд дэлгэрүүлэхэд чухал хэрэгцээтэй төрөл зүйл бүхнээс орчуулах зорилго тавьж түүнийгээ биелүүлсэн байна. "Сарны гэрэлд" энэ тухай өөрийн нь хэлсэн үгийг тэмдэглэсэн байна. "...авах гээхийн зүйлийг үзье гэх бол "Ламрим", "Пачой" тэргүүлэн авах гээхийн зүйл олныг орчуулав. Богдсын туужны зүйлийг үзэхийг дурлавал, "Бурхны тууж", "Бучой", "Мялын тууж" тэргүүтэн олныг орчуулав. Бүтээлийн зүйлийг үзэхийг дурлавал "Гүнриг', "Цэвэгмид","Нууц хураангуй", "Ямандага", "Дөрвөн догшид" тэргүүтэн бүтээлийн аргын зүйл их бага олныг орчуулав. Галба тогтсон, бурхан өөд болон, ном номлосон хаадын үеүүдийг мэдэхийг дурлавал "Номын гарлага", "Чухал хэрэгт" ба "Үгний сан" тэргүүтэн олныг орчуулав. Бурхны зарлиг орчуулсныг уншихыг дурлавал , "Найман мянган шүлэгт", "Алтангэрэл", "Тарвачэнбо", "Банзрагч" тэргүүтэн их бага зарлигийн зүйл олныг орчуулав"[222] гэжээ. Ер нь Зая бандидын нийт орчуулгыг 6 ангид хуваж болохоор байна. Үүнд:

а/ Хүн яаж явах ёстой вэ гэдгийг заасан зүйл буюу авах гээхийн сургаал.

б/ Дээдсийн намтрын зүйл

в/ Бурхныг урих, бүтээхийн зүйл.

г/ Шашин дэлгэрсэн түүх

д/ Бурхны зарлигийн зүйл

е/ Нийтийн номын зүйл буюу анагаах ухаан, зурхай, дуун ухаан зэрэг зүйл.

Зая бандид зарим номыг гүйцэд орчуулж амжаагүйг хожим шавь нар нь гүйцээж орчуулсан байна[223].

6.Зая бандидын орчуулгын байдал

Хуучны ном зохиолын орчуулгыг хянан үзвэл хоёр янз бөгөөд нэг нь уг эх бичгийг үгчилэн орчуулсан орчуулга, нөгөө нь чөлөөтэй орчуулсан орчуулга байна.

Зая бандидын орчуулгын нийт байдлыг анхааран үзвэл эх бичгийг үгчилэн орчуулсан орчуулга мөн байна. Жишээлэхэд Зая бандидын орчуулсан "Эрдэнийн сан сувашидийг" Цахар гэвш Лувсанцүлтэмийн орчуулгатай харгуулан үзвэл:

20-р бадаг



224

20-р бадаг. Цахар гэвш Лувсанцүлтэмийн орчуулга:



Цахар гэвш энэ дөрвөн мөрийг монгол шүлгийн байдалд оруулж толгойг холбохын тулд гэдэг үгсийг хэрэглэсэн байна. Тэр ч байтугай төвд эхийн 3-р мөрийг 4-р мөрт оруулж орчуулсан байна.

35-р. Зая бандидын орчуулга:





35-р бадаг. Цахар гавш Лувсанцүлтэмийн орчуулга:

Энэ дөрвөн мөр шүлгийг монгол шүлгийн байдалд оруулахын тулд Цахар гэвш Лувсанцүлтэм гэсэн үгсийг нэмж ойлгомжтой болгон чөлөөтэй орчуулсан байна.

Зарим төвд үгийг үгчилэн орчуулсан байдал Зая бандидын орчуулгаас үзэгдэж байна. Жишээ нь Сувашидийн 2-р бадагт төвдийн гэдэг үгийг "Зүү аваач" гэж үгчилэн орчуулжээ. Гэтэл бусад орчуулганд "Соронзон гүр" гэх буюу "соронзон"гэж орчуулсан байна.

7. Зая бандидын шавь нарын орчуулга

Зая бандид өөрөө өдий олон ном орчуулснаас гадна өөрийн шавь нарыг ном орчуулахад заан сургасан байна. Зая бандидын намтар "Сарны гэрэлд" түүний гурван шавь Эрх цорж /Огторгуйн ялгуусан бэлэгт буюу Намхайжалцан/, Рабжамба цорж /Даржаа гавж/, хэлмэрч сойвон /Раднаабадраа/ нарын орчуулсан 37 ном байгааг бид сайн мэднэ.

Зая бандидын шавь нарын орчуулгаас одоо бидний гарт цөөн төдий нь мэдэгдэж байна. Бид нэгдүгээрт Раднаабадрааг дурдах хэрэгтэй. Энэ хүний нэр хэд хэдэн эх бичгүүдэд хэд хэдэн янзаар то-

хиолдож байна. Нэг нь бидний сайн мэдэх хэлмэрч Сойвон, нөгөө нь зүгээр Сойвон, гуравдахь нь Сойвон сайн эрдэнэ /Ринченсамбуу/ гэж байна. Үүнээс хойш энэ хүнийг бид заншсан ёсоор Раднаабадраа гэж нэрлэе.

Раднаабадраа хэдэн онд төрснийг бид мэдэхгүй юм. Юу ч атугай 1691 он хүртэл эсэн мэнд байж "Сарны гэрэл"гэдэг сонин намтрыг бичиж дуусгасан байна. Сарны гэрэлд өөрийн нь тухай гарч байгаа хэсэг бусаг мэдээг бид шүүрдэн үзье.

1645 онд Зая бандидыг Ижил мөрөнд хүрэлцэн очиход тэнд Раднаабадраа өөрөө очоогүй болохоо бичиж[225] байна.

1661 онд Зая бандид, Авлайнд морь, тэмээ хүргүүлж мэндийг мэдүүлэхээр Раднаабадрааг Эрчист илгээж[226] байжээ.

1662 онд Зая бандидыг дагаж Төвдөд явсан[227] байна.

1670 онд Раднаабадраа, Далай ламтай уулзсан тухайгаа өөрөө бичсэн нь: "Хэлмэрч аль вэ хэмээн /Далай лам. Л-Б/ зарлиг болон асуусанд, хэлмэрч би болой хэмээмэгц, чи Раднаабадраа бус буюу хэмээн зарлиг болсон нь тодорхой буй"[228] гэжээ.

Энд дурдаж байгаа мэдээнээс бидний сонирхол татаж байгаа нэг зүйл гэвэл Раднаабадраа төвд хэлэнд онцгой сайн байснаар нэрд гарч, түүнийг Далай лам хүртэл сайн мэдэж байсан нь дээрх баримтаас тодорхой байна.

1676 онд цэргийн хөл болж хийдийн мал сүргийг албадан авах, хулгах, булаах зэрэг элдэв зүйл болоход Дайчин Нанс, Үйзэн Нанс тэргүүтэн нэр хүндтэй шавь нар хэлэлцэн ханд барих заргын бичгийг

Раднаабадраагаар явуулсанд Зайрын Усан хужир гэдэг газар хүрч ханд /Галдан бошигт ?/ хүргэж өгч байжээ[229].

1689 онд Ноён гэлэн гэгч 700 гаруй лам нарыг цэрэгт дайчлан мордоход Раднаабадрааг мөн яв гэж тушааж хүн илгээсэнд учраа хэлж яваагүй учраа бичсэн[230] байна.

Раднаабадраа "Сарны гэрэл" гэдэг зохиолоо хэрхэн яаж бичсэн, хэний дурдсанаар бичсэн тухайгаа уг номын төгсгөлийн үгэнд бичсэн[231] байна.

Раднаабадраагийн хийсэн бүтээлийн талаар хэсэг бусаг мэдээг зарим номын төгсгөлийн үгнээс олж болохоор байна. 1664 оны үед орчуулсан "Найман мянган шүлэгт" гэдэг номыг үнэсэн самбарт бичиж авсан байна. Бас "Чойжид дагинын тууж", "Бодичарьяа авадара" гэдэг хоёр номыг мөн л үнэсэн самбарт бичиж байжээ. Үүгээр үзвэл Раднаабадраа бол сайн бичээч байжээ гэж мэдэгдэж болохоор байна.

"Гэгээн толь" гэдэг номын төгсгөлийн үгэнд:



гэж бичжээ. Үүгээр үзэж Раднаабадрааг ганц энэ ном орчуулсан гэж хэлж болохгүй юм. Учир нь,дээр дурдсан 37 номоос нилээдийг Раднаабадраа орчуулсан болов уу гэж таамаглах үндэс бидэнд бий. Цааш нь "Ялгуун төгсөн үлэсэн чадагч эрхтийн зохиол товчийн тедий өгүүлсэн үзсээр туст маш баясгалан

лугаа сэлт сүсгийн өдөр болгооч зүүн зүг ургахуй" гэдэг номын төгсгөлийн үгэнд:



гэжээ.

Энд бичсэнээр Раднаабадраа энэ номыг хянан шүүсэн байна.

Эцэст нь хэлэхэд Раднаабадраа бол сайн бичээч, сайн хянагч, орчуулагч, түүхч байсныг дээрх баримтаар нотлож болно.

Хоёрдугаарт. Дээр дурдсан гурван шавийн нэг нь болох Эрх цоржийн тухай бага сага зүйлс олдож байна.

"Гарсан сайн галбын их хөлгөний судар" гэдэг номын төгсгөлийн үгэнд:



гэсэн байна.

Бас "Сундуйн " төгсгөлийн үгэнд:



Тэгэхлээр "Сарны гэрэлд" хэдэнт гардаг Эрх цорж гэдэг хүний жинхэнэ нэр нь Огторгуйн ялгуусан билигт буюу Намхайжалцан гэдэг болж байна.

Эрх цоржийн тухай мэдээг бид "Сарны гэрлээс" түүвэрлэж үзье.

Энэхүү Эрх цорж бол дээр дурдсан 37 ном орчуулагчдын нэг нь мөн[232].

1661 онд Авлай, Цэцэн хан хоёр эвдрэлцэж

тулалдах байдал илэрмэгц тэднийг эвлэрүүлэхээр илгээсэн дээдэс лам нарын элчийг Эрх цорж тэргүүлж явжээ[233].

1669 оны зун Эрх цорж тэргүүлэн Зая бандидын хойд дүртэй уулзахаар яваад улмаар 1670 онд Зууд /Лхасад/ өвөлжиж 1671 онд Ойрд нутагт буцан иржээ[234].

1686 оны хавар Эрх цорж Ноён гэлэнд баригдаж алуулахад хүрч байв[235].

1690 онд Далай ламаас Эрх цоржид Эрдэнэ дархан цорж хэмээх цол хайрлав[236].

Мөнхүү "Сундуйн" хоёрдох төгсгөлийн үгэнд:



гэжээ. Үүнээс өөр энэ хүний орчуулсан ном бидэнд одоогоор олдсонгүй.

Гуравдугаарт, Зая бандидын дэргэд Цүлтэмжамц гэдэг сайн бичээч байсныг бид дээрх хүснэгтээс мэдэж байна. Энэ хүн "Хутагт их тонилсоны зүгт дэлгэрүүлэгч", "Банзрагч", "Хутагт дээд алтан гэрэл", "Мэдээтэй мэдээгүйг ялгагч", "Рашааны зүрхэн найман үет нууц увдисын үндэснээс дөрөвдүгээр хэсэг хойд үндсэн", "Мялын тууж" гэдэг ном зохиолыг үнэсэн самбарт буулган бичсэн байна. Бичээч Цүлтэмжамц "Сургаалын үе сувд эрхэ"[237] гэдэг номыг Бошигт дайчингийн зарлагаар орчуулжээ. Бас "Молон тойн эхээ тамаас гаргасан судар"[238]-ыг Авлайн эх Сайхан Чүү хатны зарлигаар орчуулсан байна.

Дөрөвдүгээрт, "Хутагт охь савын зохиол" гэдэг номыг хошуудын Авлай баатрын зарлигаар Эрх ялгуусан бэлэгт далай буюу Ванжилжамц гэдэг хүн орчуулжээ. Энэ хүний тухай тодорхой мэдээ бидэнд огт тохиолдсонгүй. Уг номыг Зая бандидын дэргэд байсан Уран Хонжин үнэсэн самоарт бичсэн болохоор тэр үеийн орчуулга болох нь тодорхой юм.

Тавдугаарт, "Ялгуун төгсөн үлэгсэн чадагчийн эрхтний зохиол товчийн төдий өгүүлсэн үзсээр туст маш баясгалан лугаа сэлт сүсгийн өдөр болгогч зүүн зүг ургахуй" гэдэг номын төгсгөлийн үгэнд:



Энэ Дайчин Нансын тухай мэдээ сурвалж бичигт маш ховор тохиолдож байна. "Сарны гэрэлд" гурван ч Нанс буй. Нэг нь Үйзэн Нанс, нөгөө нь Дайчин Нанс гэж буй. Үүнээс гадна Засагт хан "Эцгийн ном" орчуулж өгнө үү гэж Зая бандидтай хамт бичээч Нанс гэдэг хүнийг явуулсан гэж буй[239]. "Эцгийн номын" төгсгөлийн үгэнд энэ хүнийг "Олгонуудын Үйзэн бичээч Дархан Нанс" гэжээ. Бас "Хөвгүүн ном" буюу Бүчойг бичсэн бичээч мөн л "Үйзэн Дархан Нанс" гэж байна. Ингээд үзвэл Үйзэн Нанс, Дайчин Нанс, Дархан Нанс ийм гурван өөр хүн байгаа бололтой. Үүнээс бидний сонирхож байгаа Дайчин Нанс буюу хэлмэрч Дайчин Нанс 1662 онд Зая бандидын хамт Төвдөд явжээ[240].

1676 онд хоёр Нанс /Дайчин Нанс, Үйзэн Нанс / зөвлөж заргын бичиг үйлдэж Раднаабадраагаар ханд хүргүүлж[241] байжээ. Үүнээс хойш Дайчин Нансын тухай тодорхой мэдээ сарны гэрэлд байхгүй байна. Нөгөө Үйзэн Нанс нь 1691 оны зуны тэргүүн сарын 13-нд Тэсийн Улаан байшин гэдэг газар Ноён гэлэн хэмээгчид алагджээ[242].

Зургаадугаарт, "Ламрим"[243] хэмээх номын төгсгөлийн үгэнд:



/ Баатар хун тайжийн 5-р хүү/ дайсныг дарагч/ гэсэн байна.

Юу ч гэсэн Зая бандидыг нас барснаас хойш Баатар хун тайжийн тавдугаар хүү Сэнгэ, түүний хатан Цэвээнжалмуу хоерын зарлигаар Даги гэлэн гэгч орчуулсан бөгөөд энд "Рабжамба Заяын эцэс шавь" гэснээр үзэхэд маргаангүй шавь нарын орчуулсан номын нэгэнд оруулж болно. Энэ Даги гэлэнгийн тухай бидэнд ямар ч мэдээ сурвалж бичгээс олдсонгүй.

Долоодугаарт, "Хутагт их хурсан эрдэнэ охийн тогтоол", "Байлдаанаас тийн ялгуусан хэмээх үндэсний хааны агуй их тайлбар Цогт зул", "Тархуу үр" гэдэг гурван номыг Бандид цорж гэдэг хүн орчуулжээ. Бас ойрд Доржравдан /Цэцэн ханы бага хатан, Үд агас ч гэдэг/, Аюк хоёрын зарлигаар "Сайн Магадын тууж" гэдэг номыг засаж орчуулсан

байна. Энэ номын төгсгөлийн үгэнд "Олон хүний сонсоход сайхан болгохын тулд үгийн эхэн үсэгнүүдийг холбон урт охорыг оюуны чинээгээр Бандид цорж зассан" гэж бичжээ.

"Цогт зул" гэдэг номын төгсгөлийн үгнээс Бандид цоржийн тухай бага сага мэдээ гарч байна. Үүнд:



гэсэн байна. Ингэхлээр энэ хүн монгол хэл сайн сурсан төвд хүн гэдэг нь тодорхой юм. Бандид цорж Зая бандидын дэргэд байсан эсэх талаар тодорхой мэдээ байхгүй боловч Зая бандидын дараахан түүхийн давцан дээр гарч ирсэн Доржравдан, Аюк /эгч дүү хоёр/ хоёр дурдсан болохоор мөн л тэр үеийн хүний орчуулга гэж үзэв.

x x x

ДҮГНЭЛТ

ХҮП зууны үеийн монгол даяарт бөө мөргөл зонхилж байв. Хязгаарлагдмал, орон нутгийн чанартай байсан бөө мөргөлтэй шаргуу тэмцэл явуулж, Зая бандид, зурхайн зуун үзэл, гариг одны тохиол зэрэг зурхайн ном, рашааны зүрхэн найман үет нууц увдисын үндсэн зэрэг анагаах ухааны холбогдолтой зохиол, найман мянган шүлэгт, билиг бармидын зэрэг гүн ухааны зохиол, олон номын үндсэн үзгийн ялгал, ёгт нэр, ёгт нэрийн тайлбар зэрэг хэл бичгийн холбогдолтой зохиол, мэдээтэй мэдээгүйг ялгагч судар буюу үлгэрийн далай, Эрдэнийн сан Сувашид зэрэг уран зохиолын ном, таван сахъяа, их

тонилсоны зүгт дэлгэрүүлэгч зэрэг бурхны шашны ном орчуулжээ.

Зурхай, анагаах ухаан, гүн ухаан, хэл бичиг түүх, уран зохиол, бурхан шашны холбогдолтой өдий төдий олон зохиолыг монгол хэлэнд орчуулсан ойрдын Зая бандидын үйл ажил бол тэр үедээ дэвшилттэй зүйл байв.

Үүгээрээ тэр үеийн Халх долоон хошуу,ялангуяа Дөрвөн ойрдыг орон нутгийн чанартай бөө мөргөлийн явцуу хүрээнээс гаргаж эртний соёлт Энэтхэг,Төвдийн соёлын өргөн хүрээнд татан оруулсан учраас Ойрдын Зая бандидыг ХҮП зууны үеийн монгол дахины соёлын зүтгэлтэн гэж зохих ёсоор үнэлж байгаа юм.

Эш татсан ном зохиол

I. Зая бандидын намтар "Сарны гэрэл"-ийг 1690 онд зохиосон гэж К.Ф.Голстунский үзсэн боловч намгарч буй үйл явдлыг он цагаар үзвэл 1691 он буюу Цагаагчин хонин жил бичиж дуусан байна.

2.Тухайлан хэлбэл " Boγda Nayiǰi toyin dalai Mañzusri-yin domuγ-i todurqay-a geyigülügči cindamani erke kemegdekü orusiba" гэдэг намтарт иймэрхүү зүйл буй.

3.Radnabhadr-a " Rabǰamba zay-a bandida-yin tuγuǰi saran-u gerel kemegdekü ene metü bolai" Corpus Scriptorum Mongolorum, Tom V.Fasc.2.Улаанбаатар 1959 он, Академич, доктор Ринчен оршил бичиж нийтлүүлсний дотор монголоор бичсэн "Сарны гэрлийг" халх Зая бандидын номын санд хадгалагдаж байсан тухай бичсэн байна. Энэ номыг хойшид "Сарны гэрлийн монгол эх" гэж товчлов. Бас академич Ц.Дамдинсүрэн "Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив" гэдэг номд "Сарны гэрлийг" хэсэгчлэн авч оруулаад орчуулсан номын монгол нэрэнд төвд нэрийг хавсаргасан нь маш чухал зүйл байв.

4.Biography of Caya pandita in Oirat Characters, Corpus Scriptorum Mongolorum. Tom.V.Fasc.2-3.Ulan-Bator. Энэ тод үсгийн сонин сурвалж бичгийг Ховд аймгийн Манхан·сумын "Баясгалант амьдрал" нэгдлийн гишүүн Ж.Ванчиг, Д.Түвдэн нар 1963 онд Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын хөмрөгт бэлэглэсэн юм. Хойшид энэ номыг "Сарны гэрлийн тод эх" гэж товчлов.

5.Энэ "Сарны гэрлийг" монголч эрдэмтэн А.Бурдуков 1910 онд баядын Нацаг бэйсээс авсан байна. А.В. Бадмаев "Зая бандита" калмыцкое книжное изд-во, Элиста. 1968. 15-р талд. "Среди рукописей с биографией Зая-Пандиты лучшей является та, которая была найдена Бурдуковым в Северо-Западной Монголии" гэж Б.Я.Владимирцов "Монголын нийгмийн байгуулал" гэдэг зохиолдоо дурдсан байна. Мөн зохиолын 18-р талд.

6.Энэ "Сарны гэрлийн" төгсгөлийн үгэнд "Под полковник хошуд ноён Цэрэнжав Туменовийн эрсэнээр Шар манжийн Нялх гэлэн эл туужийг алтаар бичив" гэсэн байна. А.В.Бадмаев "Зая Пандита" калмыцкое книжное издательство, Элиста.1968. 19-р талд.

7.К.Ф.Голстунский "Монголо-ойратские законы 1640 года, дополнительные указы Галдан-Хун тайджия и законы составленные для Волжских калмыков при Калмыцком хане Дондук-Даш" Спб. 1880.

8. Энэ орчуулга Зөвлөлтийн Шинжлэх Ухааны Академийн Дорно дахиныг судлах хүрээлэнгийн дорно дахиныг судлагчдын архивт хадгалагдаж байсныг Халимагийн эрдэмтэн А.В.Бадмаев оршил бичиж "Калмыцкие историко-литературные памятники в русском переводе" Элиста. 1969 гэдэг эмхтгэлийн 159-200-р хуудсанд сийрүүлэн нийтлүүлсэн байна.

9. Сарны гэрлийн тод эх. 6а талд.

10. Калмыцкие историко-литературные памятники в русском переводе. Элиста. 1969. 164-р талд

11. Сарны гэрлийн монгол эх.18-р талд

12. Калмыцкие историко-литературные памятники

в русском переводе. Элиста. 1969. 173-р талд.

13. 1604 онд "Энэ жил Ойрд хутагтын гэгээн зургаан сүүдэр зооглов" гэж Алтан эрхэнд бичсэн байна. 32в-33а талд.

14. Рабжамба ཤ་ཀ་ཧ་ཨ, номд "Маш хязгаар-гүй" гэсэн утга бүхий цол. Номыг гүнзгий мэдэж Рабжамба цолыг авна.

15. Сарны гэрлийн тод эх 3а талд.

16. Сарны гэрлийн монгол эх 7-р талд.

17. И.Я.Златкин.История Джунгарского ханства. Москва. 1964. 177-178-р талд.

18. Сарны гэрлийн монгол эх 7-р талд

19. Мөн зохиолын 8-р талд.

20. Мөн зохиолын 8-р талд

21. Очерк истории Калмыцкой АССР. /Москва. 1967/ гэдэг номын 76-р талд Зая бандидыг Ижил мөрөнд 1647 онд очсон гэдэг нь ташаарсан бололтой. Зүй нь 1645 онд байваас зөв мэт.

22. Зая бандид болон түүний дагалдагсдыг Халимагт зочлон очиход тэдэнд бүгд 20000 адуу өргөл барьцанд өгч байсан байна. Сарны гэрлийн монгол эх 9-р талд.

23. Мөн зохиолын 11-р талд

24. Мөн зохиолын 11-р талд

25. Мөн зохиолын 11-р талд

26. Мөн зохиолын 12-13-р талд

27. Мөн зохиолын 12-р талд

28. Мөн зохиолын I3-р талд

29. Мөн зохиолын I7-р талд

30. 320 лет старокалмыцкой письменности 2I-39-р талд.

3I. Сарны гэрлийн монгол эх. I8-р талд

32. Мөн зохиолын I9-22-р талд

33. Мөн зохиолын 22-23-р талд

34. Мөн зохиолын 23-р талд

35. Мөн зохиолын 24-р талд

36. Мөн зохиолын 24-р талд

37. Мөн зохиолын 25-р талд

38. Мөн зохиолын 26-р талд

39. Мөн зохиолын 26-р талд

40. Мөн зохиолын 26-27-р талд

4I. Мөн зохиолын 27-30-р талд

42. Мөн зохиолын 32-33-р талд

43. Энэ асуудалтай холбогдох сонин өгүүллийг Зөвлөлтийн түүхч доктор И.Я.Златкин бичсэн байна. И.Я.Златкин Зая пандита как политический деятель. "320 лет старокалмыцкой письменности" гэдэг эмхтгэлийн 2I-39-р талд

44. К.Ф.Голстунский "Монголо-Ойратские законы I640 года, дополнительные указы Галдан-хун тайджия и законы, составленные для Волжских калмыков при калмыцком хане Дондук-даши". Санктпетербург. I880 г. 2-р талд. Мөн зүйлийн орчуулга: "Если какой либо человек, разрушивший это правление /т.е установленный порядок/, побьет /людей/и разграбить

большой аймак народа, то Монголы и Ойраты должны соединиться и, оставивший только его самого /разорителя/, все прочее /имущество/ его взять: половину отдать остающимся /от раззорения/, остальное разделить пополам". Мөн зохиолын 35-р талд

45. К.Ф.Голстунский Монголо-ойратские законы. 3-р талд. Уг зүйлийн орчуулга: "Если к Монголом и Ойратом придет неприятель, должны дать известие; кто из главных смежные князей, услыхав /получив/ такое известие, не придет /против неприятеля/, с того взять /в штраф/ сто панцырей, сто верблюдов и тысячу табуна; если не придеть /кто/из малых князей, взять десять панцырей, десять верблюдов и сто табуна /лошадей/ мөн зохиолын 35-р талд

46. К.Ф.Голстунский Дурдсан зохиолын 4-р талд. Орчуулга нь: "Кто увидить или услышить о значительном неприятель и не сообщить, того, изгнавший с потомков, убить, раззорить" мөн зохиолын 37-р талд

47. И.Я.Златкин История Джунгарского ханства. Москва. I964. I76-I77-р талд.

48. Мөн зохиолын I77-р талд

49. I/ Түмэн Дарын хошуу, 2/Баян Дарын хошуу, 3/Урианхай хошуу, 4/ Дэлдэн хөндлөнгийн хошуу, 5/ Түшээт хааны хошуу, 6/ Цэцэн ханы хошуу,7/Дариганга хошуу, эдгээр долоон хошуу болно.

50. "Хэл зохиол" сэтгүүл. VI боть, I-I3-р дэвтэр, I37-р талд

5I. К.Ф.Голстунский Монголо-ойратские законы I640 года, Санктпетербург. I880, I8-I9-р талд.Орчуулга нь: "Кто приведеть к себе шамана или шаманку, то с пригласившего человека взять его лошадь, и с прибывшей шаманки взять ее лошадь, будь кто

увидить и не возмет / по лошадиу них/ то и того взять лошадь, кто увидить онгона, должен его взя а если владелец онгона вступить в спор и не отдаст то взять и его лошадь" мөн зохиолын 55-р талд

52. Алтан эрхэн 34в-35а талд

53. Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номы хөмрөгийн 416-р тэмдэгтэд энэ цагаан толгойг бүрг гэн авсан байна. Хэмжээ 23,4 х 13,5 см. хар бэх, улаан шунхаар муутуу цаасан дээр бийрээр бичжээ.

54. Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номы хөмрөгт хадгалагдаж буй "Үсгийн найрлага" гэдэг бичмэл цагаан толгой.

55. Үүнтэй холбогдуулан хэлэхэд Өндөр гэгээн Занабазарын зохиосон Соёмбо үсгийг зөвхөн Халхад зориулан, халхын аялгуунд тохируулан зохиосон гэж үзэж болохгүй мэт санагдана. Улсын нийтийн номын сангийн 77903-рт хадгалагдан буй "Соёмбын утгыг товч өгүүлсэн бичээч цоржийн зохиол оршив" гэдэг бичмэлд Соёмбо үсгийн тухай өгүүлэхдээ: "...Энэтхэгийн хэл ба, Монголд ч дотор зуур, Дөчин есөн /Өвөр монголын 49 хошуу. Л-Б/ их хошуу зэргийн хэлээр бичих уншихад хэрэглэхийн тухай зохиосон мэт ..." гэж бичсэн нь туйлын зөв бололтой.

56. Тод үсгийг зохиосон тухай ардын домгийг Г.Н. Потанин дөрвөдөөс тэмдэглэн авсан байна.

а/ "Тангутское письмо изобретено ламами Джибцзунь Цзамбу Кутухту и Арыбджань Зая Бандита., Монгольское письмо долго не могли изобресть. Когда мо лились целым хурулом о дарований письма, одна стар ха подошла к собранию лам, держа на плече эдринь /палку с зарубками, которую выделывают овчину/.

Кункерь Заячи сказал: " Это вероятно, -указа-

ние свыше". С этого эдрина и скопировали монгольское письмо. /Сарисынь, Дюрбют. г.Улан-гом/

б/ "Другие говорят, что отправившись искать письмо, монголы наткнулись на старуху, которая выделывала овчину. Приняв это за внушение свыше истолковали обстоятельно так: белая овчина-это бумага, знаки, оставляемые на ее поверхности эдрином, -буквы и позаимствовали отсюда рисунок букв для тодо-монгольского языка". / он. же/

Г.Н.Потанин Очерки северо-западной монголии: выпуск 4. Материалы этнографические. С.Петербург. 1883. 328-329-р талд.

Энэ домог нь монголчуудын үсэг бичигтэй болсон домогтой тохирч байгаа /Зүрхэн толт. Буриад барын 4а талд/ болович хэд хэдэн хүний нэр гарч байна. Нэгдүгээр домогт Жавзундамба хутагт, Равжамба Зая бандид, Хүнхэр заяач, Өндөр гэгээн Занабазар буюу нэгдүгээр Жавзундамба хутагт Соёмбо үсэг зохиосон. Равжамба Зая бандид тод үсэг зохиосон, нөгөө Хүнхэр заяач буюу Хүнгүй заяач бол Зая бандидын өвөг юм. Энэ нь хэдийгээр домог болович зарим зүйл нь үндэстэй байна.

57. Сарны гэрлийн монгол эх 12-р талд

58. Дөрвөн ойрдын тууж хэмээх оршив 6в-7а талд

59. Энэ тухай мэдээг хойно сийрүүлбэл:

60. Баруун монголд тод үсгийг зохиосон тухай домог,бас үсгийг хэлбэрээр нь нэрлэсэн дэвсгэр үсгийг өгүүлэх эрхтний байдлаар нэрлэсэн нэр байдаг билээ. Бид Улсын нийтийн номын сангаас "Тод монгол хэмээх үсэг" гэдэг нэртэй нэг цагаан толгой олсонд үсгийн тийм нэр хадсан байв. Үүнд a-г "хоёр араатай" гэжээ. /"Тод монгол хэмээх үсэг" гэдэг цагаан толгойг 3-р хавсралтанд үзнэ үү/.

61, 62. Уйгаржин монголтой харьцуулсан зүйлийг мо, тод монголыг то. гэж товчлов.

63. Тод монгол хэмээх үсэг гэдэг цагаан толгой e-г "дэгээ сүүлтэй" гэжээ.

64. Мөн цагаан толгойд i-г "хийсвэр сүүлтэй" гэжээ.

65. Мөн цагаан толгойд o-г "дөрвөлжин гэдэстэй" гэжээ.

66. Мөн цагаан толгойд u-г "Моголцог гэдэстэй" гэжээ. Ховд аймгийн Алтай, Манхан сумын захчинд "Моголцог гэдэстэй,уруугаа татсан өргөстэй" гэж хэлдэг.

67. Эгшгийн урт шүдийг i, ö, ü тухайн эгшиг буюу гийгүүлэгчид нялзаан бичих явдал XVII зууны гар бичмэлд байсан бололтой. 1967 онд Булган, Сэлэнгэ аймагт явсан манай хүрээлэнгийн шинжилгээний анги Булган аймгийн Хангал сумнаас "Маань гамбум" гэдэг судар олж ирсэн билээ. Энэ "Маань гамбум" Зая бандидын орчуулга бус болов XVII зууны үеийн бичмэл юм. Үүнд тод үсгийн u-г тэмдэглэсэн юм биш байгаа гэж бодогдмоор зүйл тохиолддог юм. Жишээ нь:

37a ᠨ, 31a ᠨ, 31a ᠨ, 39в ᠨ талд.

68. Тод монгол хэмээх үсэг гэдэг цагаан толгойд ö-г "моголцог гэдэстэй" гэжээ. Ховд аймгийн Алтай, Манхан сумын захчинд "Моголцог гэдэстэй,өөдөө татсан өргөстэй" гэж хэлдэг байна.

69. Тод монгол хэмээх үсэг гэдэг цагаан толгойд ü-г моголцог гэдэстэй гэжээ.

70. Мөн цагаан толгойд na-г "хоёр араатай өмнөө цэгтэй" гэжээ.

71 Мөн цагаан толгойд ха-г "гурван араатай өмнөө цэгтэй" гэжээ.

72. Мөн цагаан толгойд ке-г "дэгээ хөлтэй хэлэндээ өргөстэй" гэжээ.

73. Мөн цагаан толгойд γа-г "гурван араатай өмнөө дугариг цэгтэй" гэжээ.

74. Мөн цагаан толгойд ge-г "дэгээ хөлтэй" гэжээ.

75. -г Дөрвөдөд "катгар ка" гэж нэрлэнэ.

76. Б.Я.Владимирцов Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Ленинград.1929.120-123-р талд

77. Тод монгол хэмээх үсэг гэдэг цагаан толгойд da-г "уруу толгойтой" гэжээ.

78. Мөн цагаан толгойд ta-г "тариан толгойтой нэг араатай" гэжээ.

79. Мөн цагаан толгойд ba-г "битүү толгойтой нэг араатай" гэжээ.

80. Мөн цагаан толгойд ma-г"матгар толгой-

81.Тод монгол хэмээх үсэг гэдэг цагаан толгойд za(ǰi)-г "чацуу үрүүтэй" гэжээ.

82.Мөн цагаан толгойд ca (či)-г "дутуу үрүүтэй" гэжээ.

83.Мөн цагаан толгойд ya-г "ямаан ханшаартай, нэг араатай" гэжээ.

84.Мөн цагаан толгойд ga-г "хамар дээрээ өргөстэй, нэг араатай" гэжээ.

85. Мөн цагаан толгойд la-г "өөдөө эвэртэй хоёр араатай" гэжээ.

86. Мөн цагаан толгойд sa-г хөндлөн толгойтой хоёр араатай гэжээ.

87.Мөн цагаан толгойд ša-г хөндлөн толгойтой ардаа хоёр цэгтэй гэжээ.

